

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН КОМПЛАЕНСЫН
АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА
(СУУРЬ ОЙЛГОЛТ)**

2019 он

Энэхүү гарын авлагад тусгасан мэдээлэл нь Санхүүгийн зохицуулах хорооны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Хянасан:

Б.Эрдэнэбилэг

Боловсруулсан:

Б.Батзориг

У.Ганчимэг

А.Мандалжав

Н.Дуламсүрэн

Д.Лхагвасүрэн

Б.Төмөрхуяг

Б.Дөлгөөн

Ж.Шинэхүү

Contents

1. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	8
Комплаенсын ойлголт, ач холбогдол.....	8
Комплаенсын цар хүрээ	9
Комплаенсын чиг үүрэг.....	9
Байгууллагын удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн оролцоо	11
Комплаенсын ажилтан томилох/нэгж байгуулах шаардлага, ач холбогдол.....	12
Ажлын чиг үүрэг, хариуцлага	12
Комплаенсын ажилтанд тавигдах шаардлага.....	16
Комплаенсын түвшинг хэмжих нь	17
Тайлагнал	17
Ажилтнуудын оролцоо	18
Сургалт	19
МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ	62
Зохицуулагч байгууллагтай харилцах	62
Хөрөнгө оруулагчтай харилцах	63
Ажилтан хоорондын харилцаа	64
Харилцагчийн эрх ашгийг хамгаалах	64
Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх.....	65
Авлига гэж юу вэ?.....	65
Авлигын үндсэн шинж	66
“Жижиг” ба “том” хэмжээний авлига	66
Улс төр, захиргаа ба бизнесийн авлига	67
Зохион байгуулалттай буюу зохион байгуулалтгүй авлига	67
Авлигын гэмт хэрэг	70
Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?	72
Нийтийн ашиг сонирхол гэж юу вэ?	72
Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?.....	72
Авлигын нийгмийн болон хувийн хэвшилд үзүүлэх хор аюул	74
Харилцагчдаас бэлэг сэлт, урилга хүлээн авах.....	76
Шүгэл үлээх тогтолцоо	3

Шүгэл үлээх тогтолцоог бий болгоход анхаарах асуудал	3
Худал гүтгэлэг:.....	3
Урамшуулал.....	4
ШУДАРГА ӨРСӨЛДӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ	5
Шударга өрсөлдөөний зохицуулалт яагаад чухал вэ?	5
Компанийн нийгмийн хариуцлага, хамтын үнэт зүйлстэй холбогдох нь	6
Хамгийн өндөр торгуультай зөрчил	7
Гэмт хэргээс сэргийлэх	7
Өрсөлдөөний хуулийн зохицуулалт, тулгуур ойлголтуудын тойм	8
Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал.....	12
Дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ.	13
Цахим аюулгүй байдал /cybersecurity/.....	14
Цахим аюулгүй байдлын ач холбогдол	15
Нийгмийн хариуцлага	16
6. АУТСОРСИНГ	18
Аутсорсингийн ойлголт	18
Комплаенсын аутсорсинг гэж юу вэ?	19
Комплаенс Аутсорсинг хийх шалтгаанууд	19
Комплаенс Аутсорсинг хийснээр бизнесийн ямар үйл ажиллагаа хийж болох вэ	20
Байгууллагууд комплаенс Аутсорсингийг хэрхэн хийх вэ?.....	21
Мэдээллийн аюулгүй байдлыг хангах	23
ХАВСРАЛТ	24

АГУУЛГА

1. Ерөнхий ойлголт

- Комплаенсын үйл ажиллагаа ба түүний шаардлага, ач холбогдол
- Комплаенсын үйл ажиллагааны цар хүрээ
- Комплаенсын функц
 - Байгууллагын удирдлага, ТУЗ-ийн оролцоо
 - Комплаенсын нэгж байгуулах, ажилтан томилох шаардлага, ач холбогдол
 - Ажлын чиг үүрэг, хариуцлага
 - Тавигдах шаардлага
 - Комплаенсын түвшинг хэмжих нь
 - Тайлагнал
 - Ажилтнуудын оролцоо
 - Сургалт

2. Банкнаас бусад санхүүгийн байгууллага тус бүрийн комплаенсын онцлог

- Үнэт цаасны салбар
- Даатгалын салбар
- Банк бус санхүүгийн байгууллагууд
- Хадгаламж зээлийн хоршоод
- Үл хөдлөх хөрөнгө зуучлагчид

3. Эрсдэлийн үнэлгээ

- Эрсдэл гэж юү вэ?
- Комплаенсын эрсдэл гэж юү вэ?
- Комплаенсын эрсдэлийн үнэлгээ
- Комплаенсын эрсдэлийн үнэлгээний үе шатууд

4. Мэргэжлийн ёс зүй

- Зохицуулагч байгууллагатай харилцах
- Хөрөнгө оруулагчтай харилцах
- Ажилтан хоорондын харилцаа
- Харилцагчийн эрх ашгийн хамгаалах
- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх
- Харилцагчдаас бэлэг сэлт, урилга хүлээн авах
- Шударга өрсөлдөөнийг хангах
- Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал
Дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ
- “Шүгэл үлээх”/whistleblowing
- Нийгмийн хариуцлага

4. Аутсорсинг

- Аутсорсинг гэж юү вэ?
- Комплаенсын аутсоринг гэж юү вэ?

Хавсралт

Комплаенсын түвшинг хэмжих checklist

Хууль тогтоомж

Товчилсон үгс:

МУТС	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭЗХАБ	Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага
ФАТФ	Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
СМА	Санхүүгийн мэдээллийн алба

1. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Комплаенсын ойлголт, ач холбогдол

Комплаенс гэдэг нь компанийн засаглалын нэгэн хэсэг бөгөөд тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлж үйл ажиллагаа явуулах чадамж юм.

Комплаенс гэдэг нь италиар “*complire*”, испаниар “*cumplir*”, латинаар “*complere*” англиар “*compliment*” буюу гүйцэтгэх, гүйцээх, биелүүлэх гэсэн үгнүүдээс гаралтай.¹

Комплаенсын үйл ажиллагаа² нь 2 түвшинд явагддаг. Үүнд:

1. Тухайн байгууллагын мөрдөж ажиллах ёстой хууль тогтоомжууд, зохицуулагч байгууллагаас тавьсан шаардлага, мөрдөх ёстой хэм хэмжээг сахиулах /regulatory compliance/
2. Хууль эрх зүйн орчны хүрээнд тухайн байгууллагын дотооддоо баталсан дүрэм журмуудыг сахиулах /internal compliance/

Дээр дурдсан хууль, тогтоомж, журам, дүрмийг мөрдүүлэх ажиллагаа буюу комплаенс гэдэг ойлголтод авлига, ашиг сонирхлын зөрчил, “шүгэл үлээх”, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, мэргэжлийн ёс зүй, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, байгууллагын эрхэм зорилго, алсын хараанд нийцсэн дотоод сахилга бат зэрэг өргөн хүрээний асуудлууд багтдаг.

Компаний амжилт нь засаглалаасаа шууд хамааралтай. Компаний засаглалын ойлголтонд хууль, тогтоомж, дүрэм, журмыг сахиулах ажиллагаа буюу нь комплаенс хамаардаггүй байсан.

Сүүлийн 20-30 жил уг асуудлын ач холбогдлыг ойлгож, судалж, өргөнөөр хэлэх болсон. Тэр дундаа 2008-2009 оны дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямарлын дараагаар нөлөөлсөн шалтгаан, хүчин зүйлийг өргөнөөр судалсан байдаг. Түүний нэг нь комплаенсын хангалтгүй үйл ажиллагаа гэж үзэн томоохон компаниуд анхаардаг болсон. Тэр дундаа байгууллага дотор өөр хоорондоо мэдээ солилцох тогтолцоо бүрдүүлэхэд анхаарах болсон.

Комплаенс нь зөвхөн санхүүгийн салбараар хязгаарлагдахгүй. Компанийн засаглал, бизнесийн үйл ажиллагааны амин чухал хэсэг хууль, тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэх явдал юм.

Манай орны банк, санхүүгийн салбарын хувьд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудлын хүрээнд комплаенс яригддаг. Дэлхий нийтээр

¹ www.dictionary.com/browse/comply

² ‘Комплаенс гэсэн ойлголтыг юугаар тодорхойлдог вэ’, Олон улсын комплаенсын холбоо, <https://www.int-comp.org/careers/a-career-in-compliance/what-is-compliance/>

санхүүгийн тогтолцоог эрүүлжүүлэх, бохир мөнгө, алан хядах үйл ажиллагаатай холбоотой мөнгө гүйлгээнд орохоос сэргийлэх чиглэлд онцгой анхаарал хандуулж байна.

Комплаенсыг хэрэгжүүлээгүйгээс нэр хүндээ алдах, ашигтай ажиллагаа буурах, торгууль төлөхөөс авахуулаад зохицуулалтын байгууллагаас тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох улмаар бизнесийн нэр хүндээ алдах хүртэл олон төрлийн эрсдэл үүсэх боломжтой.

Оновчтой комплаенсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Комплаенс нь дагаж мөрдөх ёстой хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлнэ;
- Байгууллагын дотоод үйл ажиллагааны үр ашигтай байдал нэмэгдэх;
- Итгэлцлийг бий болгох;
- Нэр хүндээ хамгаалах,
- хөрөнгө оруулалт татах;
- Бодит эрсдэлийг бууруулах;
- Бизнесийн давуу тал бий болгох;
- Комплаенс нь алдаа дутагдал гарах нөхцөлийг багасгана г.м.

Технологийн хурдацтай дэвшлийн үед ёс зүйн алдаа дутагдал гарсан, авлига, хээл хахуульд холбогдсон зэрэг алдаа дутагдал гарсан тухай мэдээлэл гарахад тухайн мэдээлэл цахим орчинд хурдтай тархаж нэр хүндэд сөргөөр нөлөөлөх аюултай.

Комплаенсын цар хүрээ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажил нь улс орны, салбарын, байгууллагын хувьд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа хэдий ч комплаенсыг үүгээр хязгаарлаж болохгүй юм. Түүнчлэн комплаенс гэдэг нь мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын стандарт, аргачлалыг мөрдөж ажиллаж чадаж байгаа эсэх, үйл ажиллагаандаа хянан нийцүүлж чадаж байгаа эсэхийг тодорхойлохоос өргөн хүрээгээр авч үзэх шаардлагатай. Үүнд этик буюу ёс зүйн хэм хэмжээ, бизнесийн, мэргэжлийн ёс зүй, нийгмийн хариуцлага, эрсдэлийн үнэлгээ зэргүүд асуудлууд багтана.

Комплаенсын чиг үүрэг

Комплаенс нь компанийн засаглалын салшгүй нэгэн хэсэг юм. Эрсдэлийг удирдах 3 түвшний загвар байдаг ба 3 өөр түвшинд харилцан адилгүй чиг үүрэгтэй.³ Үүнд:

1. Гурван хамгаалалтын шатны эхэнд фронт оффисууд байдаг ба харилцагчдад үйлчилгээ үзүүлдэг ажилтнууд болон дотоод хяналт байна. Энэ шатанд:

- ✓ Эрсдэлийг илрүүлнэ, үнэлнэ, бууруулна, хянан мөн мэдээлнэ;

³ Urton Anderson, CSEP, Compliance and the 3 Lines of Deferense, University of Kentucky

✓ Эрсдэлийг шууд удирдаж, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлнэ;

2. Хамгаалалтын дараагийн шатанд дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хамгаалалт болон комплаенсын үйл ажиллагаа багтдаг. Шаардлагатай тохиолдолд зарим бизнесийн үйл ажиллагаанд комплаенсын чиг үүрэг тус бүрээр салгах боломжтой. Үүнд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх комплаенс, цахим аюулгүй байдлын комплаенс, уур амьсгал, орчны комплаенс г.м. Комплаенсын ажилтан нь Төлөөлөн удирдах зөвлөлд шууд ажлаа тайлагнах, бие даасан, хараат бусаар ажиллах эрхтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлгүй байгууллагуудын хувьд гүйцэтгэх удирдлагад ажлаа танилцуулна. Энэ шатны чиг үүрэг:

- ✓ Эрсдэлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;
- ✓ Бодлого, дүрэм журам боловсруулах;
- ✓ Эрсдэлийн удирдлагыг бий болгох;
- ✓ Комплаенсын одоо байгаа, тулгараад байгаа асуудлуудыг тодорхойлох, үнэлгээ хийх, зөвлөмж өгөх, цаашид авах арга хэмжээнүүдийг тодорхойлох;
- ✓ Стратеги болон эрсдэлтэй холбоотой дээрээс доошоо гэсэн чиглэлд санал гаргана;

3. Хамгаалалтын эцсийн шатанд байгууллагын дотоод аудит байх ба ингэхдээ бүрэн хараат бус байна. Сүүлийн шатны чиг үүрэг:

- ✓ Олон улсын стандартын дагуу аудит хийх;
- ✓ Байгууллагын хангалттай өндөр түвшний удирдлагад мэдээлэх;
- ✓ Үр дүнтэй механизмаар мэдээлэх.

Хүснэгт 1. Хамгаалалтын 3 үе шат⁴



⁴ “Хамгаалалтын 3 үе шат” загвар, Австралийн дотоод аудитын институт, 2018 он

Байгууллагын удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн оролцоо

Гүйцэтгэх удирдлага нь:

- Өндөр түвшний шийдвэр гаргах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэх;
- Байгууллагын эрсдэлийг олж илрүүлэх, удирдах, хянах үйл ажиллагааг боловсруулах;
- Эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг тухайн байгууллагад таарч тохирч буй эсэх, мөн үр дүнтэй эсэхэд хяналт тавьж ажиллах г.м.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ:

- Хувь нийлүүлэгчдийг төлөөлж, эрх ашгийг хангаж ажиллах;
- Дотоод дүрэм, журам, бодлогын баримт бичгийг батлах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг батална;
- Тухайн байгууллагын комплаенсын хөтөлбөр нь тухайн байгууллагын эрсдэлийн төвшин, онцлогтой таарсан байхад анхаарч комплаенсыг ажилтныг томилно;
- Комплаенсыг хэрэгжүүлэх ажилд шаардлагатай хөрөнгийг төсөвлөх;
- Комплаенсын ажилтанг томилох, түүнтэй шууд харьцаж, тайлан мэдээг хүлээн авч танилцах г.м.

Зарим байгууллагуудын хувьд Төлөөлөн удирдах зөвлөлгүй ажилладаг бол гүйцэтгэх удирдлага уг үүргийг гүйцэтгэх боломжтой.

Дээд шатны удирдлагууд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:

- Эрсдэлийн үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэх ба тухайн байгууллагын ямар үйл ажиллагаа МУТС гэмт хэрэгт өртөмтгий байна вэ гэдгийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчилж, сайжруулахад анхаарах;
- Эрсдэлийн үнэлгээн дээр тулгуурласан дотоод бодлогын баримт бичиг, хяналтын хөтөлбөрийг боловсруулахад анхаарах;
- Байгууллагын ажилтнууд дотоод бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд болон энэ чиглэлээр шаардлагатай сургалтад хамрагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах;
- Байгууллагын түвшинд бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ба зохицуулалтын байгууллага эсвэл Санхүүгийн мэдээллийн албаны зөвлөснөөр, эрсдэлийн үнэлгээний ажлын үр дүнгээс шалтгаалан холбогдох шинэчлэл, өөрчлөлтүүдийг хийж буй эсэхэд хяналт тавьж ажиллана.

Дээд шатны удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөл нь комплаенсын ажилтанд шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлэх ба ингэхдээ ажилтны бие даасан байдлыг алдагдуулах зүйл хийхгүй.

Компанийн засаглал нь комплаенстай салшгүй холбоотой бөгөөд ЭЗХАБ (Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага)-аас компанийн засаглалын дараах зарчмуудыг⁵ засаглалын бүхий л асуудлыг сайжруулах зорилгоор гаргасан. Үүнд:

- Бодит мэдээллийг агуулсан байх;
- Санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүн;
- Компанийн зорилго, зорилтууд;
- Гол хувьцаа эзэмшигчид ба тэдний саналын эрхүүд;
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын гол захирлууд, тэдний цалин хөлс, урамшуулал;
- Бодитой харагдаж байгаа эрсдэлийн хүчин зүйлс;
- Ажилтнуудтай болон бусад эрх ашгийн хамааралтай талуудтай үүссэн бодит асуудлууд;
- Засаглалын бүтэц болон бодлого журмууд.

зэргүүдийг багтаасан хэдий ч эдгээрээр хязгаарлахгүй.

Комплаенсын ажилтан томилох, нэгж байгуулах шаардлага, ач холбогдол

Комплаенсын үйл ажиллагааг албажуулах, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор комплаенс хариуцсан нэгж эсвэл ажилтан томилно. Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, нөөц бололцооноос хамааруулж комплаенсын нэгж байгуулах эсвэл ажилтан томилно. Ажилтан томилсон тохиолдолд өөр чиг үүрэг хариуцдаг ажилтанд ёс зүй, комплаенсын үйл ажиллагааг давхар хариуцуулах боломжтой. Ихэнхидээ практикт жижиг байгууллагуудад комплаенсын чиг үүргийг өөр нэг ажилтан давхар хариуцаад явдаг. Үүнийг хориглосон заалт байхгүй хэдий ч энэ тохиолдолд комплаенсын ажилтан өөрийн хариуцдаг ажилдаа арай “зөөлөн” хандах, сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдэх эрсдэлтэй.

Ажлын чиг үүрэг, хариуцлага

Комплаенсын ажилтны хэрэгжүүлэх гол чиг үүрэг үндсэндээ дараах байдалтай байна. Үүнд:

1. Эрсдэлийг илрүүлэх буюу тухайн байгууллагад тулгараад байгаа эрсдэлийг илрүүлж үүнийг бууруулах тухай зөвлөгөө өгөх;

Комплаенсын ажилтан эрсдэлийн үнэлгээг хийж байгууллагын удирдлагуудад хамгийн өндөр эрсдэлтэй үйл ажиллагааны талаар мэдээлнэ.

⁵ Т.Цэнд-Аюуш, Компанийн засаглал, 2011 он

2. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх буюу энэхүү зорилгоор авах арга хэмжээнүүдийг тодорхойлох;

Комплаенсын ажилтан эрсдэлүүдийг тодорхойлсны дараа тэдгээрийг бууруулах чиглэлд хийгдэх ажлуудыг тодорхойлж, байгууллагын удирдлагуудад танилцуулж хэлэлцэнэ. Авах арга хэмжээ бүр тухайн нөхцөл байдлаас хамаарч харилцан адилгүй байна. Зарим тохиолдолд байгууллагын ажилтнуудад нэмэлт сургалт оруулах шийдвэр гаргахад одоо мөрдөгдөж буй дүрэм, журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэр ч мөн гарах боломжтой.

3. Эрсдэлэлд мониторинг хийх буюу эрсдэлийг бууруулах зорилгоор авсан арга хэмжээний үр дүнтэй байдалд байнгын хяналт тавьж удирдлагуудад мэдээлэх.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажил болон үр дүнтэй комплаенс нь байнгын хийгдэж байх ёстой ажил юм. Комплаенсын ажилтан байгууллагын дотоод хяналт хууль тогтоомж, дотоод дүрэм журамтай нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

Комплаенсын ажилтан нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр:

- Ажилтнуудаас сэжигтэй гүйлгээний тухай санал, мэдээллийг авч, түүнд шинжилгээ хийж, шийдвэр гаргаж мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ;
- Хууль эрх зүйн актад нийцүүлсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын баримт бичгийг боловсруулна;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх соёлыг байгууллагын удирдлагын түвшинд бий болгож байгууллагад хэвшүүлэн мөрдүүлэх ажилд туслалцаа үзүүлэх;
- Тухайн банкнаас бусад байгууллагын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын баримт бичиг, эрсдэлийн үнэлгээ зэргийг баримтжуулах ажлыг хариуцна;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон байгууллагын харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийг тодорхойлох зорилгоор эрсдэлийн үнэлгээ зэргүүд нь эрсдэлд суурилсан байхад анхаарах ба гүйцэтгэх удирдлагатай зөвлөсний үндсэн дээр эдгээрийг шинэчлэх;
- Дотооддоо сэжигтэй гүйлгээний тайлангуудыг цаг алдалгүй хүлээн авч, судлах ажилд хяналт тавих;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн тухай ойлголтыг өгөх, түүнээс урьдчилан сэргийлэх, анхааруулах зорилготой сургалтыг удирдлага, ажилтнуудын дунд зохион байгуулах;
- Ажилтнууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр холбогдох хууль эрх зүйн актуудад заасан үүргээ биелүүлж буй эсэхэд хяналт тавьж ажиллана;

- Хүлээн авсан сэжигтэй гүйлгээний мэдээлэлд тухайн өдөртөө багтаж дүн шинжилгээ хийх;
- НҮБ, зохицуулалтын байгууллага, эсвэл санхүүгийн мэдээллийн албанаас ирүүлсэн хориг жагсаалтын тухай мэдэж байх шаардлагатай;
- Зохицуулалтын болон хууль хяналтын байгууллагаас мэдээлэл шаардсан тохиолдолд цаг алдалгүй хариу өгөх;
- Дансны хяналт, харилцагчдын жагсаалт, харилцагчдыг таних нарийвчилсан аргачлал, эрсдэлийн үнэлгээ зэрэг нь тухайн байгууллагын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдтэй нийцэж буй эсэхэд хяналт тавьж ажиллана;
- Өндөр эрсдэлтэй харилцагчдын автоматжуулсан жагсаалтыг гаргах ажилд хяналт тавина.

Бусад чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж болно:

- Комплаенсын соёлыг бүрдүүлэх, түгээх;
Байгууллага доторхи эрүүл комплаенсын соёл нь зохицуулалтын байгууллагаас тавьж буй шаардлагатай нийцүүлсэн үйл ажиллагаа явуулах, байгууллагын нэр хүндийг унахаас сэргийлэх гэх мэт эрсдэлүүдээс урьдчилан сэргийлнэ.
- Комплаенсын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, ажилтнууд болон удирдлагуудад хичээл орох;
Сургалтын хөтөлбөр нь ажиллагсдын ажлын чиг үүргийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх нь илүү үр дүнтэй байдаг. Мөн шаардлагатай үед хөтөлбөрийг шинэчилж байх нь чухал.
- Удирдлагуудад зөвлөх;
Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүд, ерөнхий захиралд тайлан мэдээ, танилцуулга бэлтгэж өгөх, бодлогын баримт бичиг, хяналтын хөтөлбөр, тогтолцоо, хэрэгжилтэд аливаа дутагдал, засаж залруулах зүйл байвал дээд шатны удирдлагуудад зөвлөгөө өгч ажиллана. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, компанийн үйл ажиллагаа өөрчлөгдөх, шинэ салбар нээх, дүрэм журамд нэмэлт, өөрчлөлт орох зэрэгт удирдлагуудад комплаенсын зөвлөгөө хэрэг болж болно.
- Мониторинг хийх;
Мониторинг хийж байнгын хяналт тавьснаар мөрдөх ёстой хууль тогтоомж, хэм хэмжээний хэрэгжилт ямар түвшинд байгаа талаар мэдээлэл авах боломжтой болох юм. Нөгөө талаас хэт их хэмжээний мониторинг нь бизнест шаардлагагүй үед хэт дарамт үзүүлэхээс гадна комплаенсын ажилтнаас бусад ажилтнууд “комплаенсын функц алдаа дутагдал байвал илрүүлэх учир санаа амар байж болно” гэсэн ойлголтыг өгөх эрсдэлтэй.

- Зохицуулалтын байгууллага, хууль хяналтын байгууллага зэрэг гадны байгууллагатай харилцахад байгууллагыг төлөөлөх;

Өөрөөр хэлбэл комплаенс нь зохицуулагч байгууллага, тэдгээрээс тавьж буй шаардлагыг бизнестэй холбох гүүр юм. Комплаенсын ажилтан нь нэг талаас зохицуулагч байгууллагаас гаргасан шинэ дүрэм журмыг байгууллагад хүргэх, нөгөө талаас зохицуулагч байгууллагад хүсэлт тавих байдлаар холбогдож ажиллана.

- Комплаенстай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх;

Комплаенсын ажилтан олон улсын стандарт, хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмаа маш сайн мэддэг байх шаардлагатай. Мөн тухайн бизнес, зохицуулалттай холбоотой бүх асуултанд хариулж чадахуйц мэдлэг, мэдээлэлтэй байх хэрэгтэй. Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, зорилго зорилтууд, ажлын байрны соёл зэргүүдийг сайн мэддэг байх нь маш чухал. Эдгээр шаардлагуудыг хангасан тохиолдолд комплаенсыг өндөр түвшинд хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг ёс зүйтэй явуулах, дотоод сахилга батыг хангах нөхцөл бүрдэх боломжтой.

- Эрсдэлийн үнэлгээг хийх;
- Байгууллагын комплаенсын түвшинг хэмжиж, дүгнэлт боловсруулах, цаашид алдаа дутагдлыг арилгах чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлох;
- Ажлын тайланг боловсруулж удирдлагуудад танилцуулах.

Комплаенс нь зөвхөн комплаенсын ажилтны үүрэг хариуцлага биш бөгөөд байгууллага комплаент соёлтой, удирдлага болоод ажилтнууд үүрэг оролцоотой байх шаардлагатай. Гэвч ажилтнуудад комплаенсын ач холбогдлыг хэрхэн яаж ойлгуулах вэ? Зөвхөн сургалтын хөтөлбөр боловсруулах, аль эсвэл цөөн орон тоотой байгууллагуудад бие биедээ албан бус байдлаар хэлэх нь комплаенсыг сулруулах, хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлэх юм. Иймд комплаенсын үйл ажиллагааг албажуулж, ажил хэрэг болгохын тулд комплаенсын хөтөлбөрийг боловсруулж, мөрдөх хэрэгтэй. Хөтөлбөр нь ажлыг зөвхөн цаасанд буулгаад зогсохгүй, аливаа эрсдэлийг илрүүлэх, аливаа асуудал гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх арга замын зураглалыг бий болгох ач холбогдолтой.

Комплаенсын ажилтан байгууллагын комплаенсын үйл ажиллагааг албажуулах, эмх цэгцтэй, ойлгомжтой болгох зорилгоор хөтөлбөр боловсруулах нь зохимжтой бөгөөд байгууллага бүрийн хөтөлбөр түүний онцлог, үйл ажиллагааны төрөл, эрсдэлийн түвшнээс хамаараад харилцан адилгүй байна. Комплаенсын хөтөлбөрийг боловсруулах нэгдсэн стандарт байхгүй хэдий ч дараах асуудлуудыг багтаасан байвал зохино. Үүнд:

- Комплаенсын ажилтан томилох;
- Бодлогын баримт бичиг, дотоод дүрэм журам боловсруулах;
- Сургалтын хөтөлбөртэй байх;
- Өөр хоорондоо холбогдох мэдээллийн сувгуудыг тодорхойлох;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр;

- Дотоод хяналтын хөтөлбөрийг үнэлэх үнэлгээ, мониторинг хийх;
- Хариуцлага хүлээлгэх, алдаа дутагдал илэрсэн тохиолдолд арга хэмжээ авах г.м.

Комплаенсын ажилтанд тавигдах шаардлага

Комплаенсын ажилтан буюу комплаенсын нэгжид ажиллах ажилтнуудад байгууллагын үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ, шаардлагаас хамааруулан байгууллага өөрөө холбогдох шаардлагуудыг тавьж ажиллана. Комплаенсын ажилтан өндөр хариуцлагатай ажлыг хийж гүйцэтгэдэг тул удирдлагын түвшний албан тушаалтныг томилох нь зүйтэй ба дараах чадвар болон шинж чанарууд уг ажлыг хийж гүйцэтгэхэд чухал үр нөлөөтэй. Үүнд:

Мэргэжлийн мэдлэг чадварын хувьд:

- Тухайн ажлыг үр дүнтэй хийж чадахуйц өндөр боловсролтой. Хууль эрх зүй, санхүү, эдийн засгийн чиглэлээр их дээд сургууль төгссөн байх шаардлагатай. Түүнчлэн мастер болон бакалавраас дээш зэргийн боловсролыг эзэмшсэн байх нь давуу тал болно;
- Ажлын туршлага. Комплаенсын ажилтан дотоод хяналт, комплаенс эсвэл Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр урьд өмнө дор хаяж 2 жил ажиллаж байсан туршлагатай байх нь зүйтэй. Түүнчлэн удирдах албан тушаалд ажиллаж байгаа албан тушаалтныг томилох нь илүү үр дүнтэй;
- Тухайн байгууллагыг төлөөлж чадахуйц мэдлэгтэй. Зохицуулагч байгууллага болон гадны бусад байгууллагуудад өөрийн байгууллагаа төлөөлж хурал, уулзалтад оролцох, тухайн байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эрсдэл, тухайн бизнесийн онцлог зэргийн тухай мэдлэг, чадвартай байх;
- Хууль эрх зүйн орчны талаар хангалттай мэдлэг, мэдээлэлтэй байх. Комплаенсыг хэрэгжүүлэхэд зөвхөн байгууллагын дотоод дүрэм, журам гэлтгүй, хууль тогтоомж зохицуулагч байгууллагаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажиллах шаардлагатай тул комплаенсын ажилтан холбогдох хууль, дүрэм, журмын талаар мэдлэг, мэдээлэл өндөртэй байх нь чухал юм.

Хувь хүний зан авирын хувьд:

- Удирдан зохион байгуулах чадвартай;
- Хувийн болон мэргэжлийн ёс зүй өндөртэй, ёс суртахуунтай, үнэнч шударга;
- Логик сэтгэлгээ сайтай, аливаа асуудалд дүн шинжилгээ хийх, бодитоор үнэлэх, асуудлыг шийдвэрлэх чадвартай;
- Бичгэн болон ярианы, харилцааны өндөр чадвартай. Комплаенсын ажилтан нь байгууллагын ТУЗ, удирдлага, ажилтнуудад мэдээлэл өгөх, ажлаа тайлагнах, сургалт зохион байгуулах, ойлгомжтой, үр дүнтэй зөвлөмж чиглэл өгч, зохицуулалтын болоод бусад байгууллагуудтай харилцах тул бичгэн болоод ярианы, харилцааны чадвар сайтай байх шаардлагатай.

Түүнчлэн комплаенсын ажилтан ашиг сонирхлын зөрчилгүй, урд өмнө нь гэмт хэрэгт холбогдож, шалгагдаж байгаагүй байх шаардлагатай.

Комплаенсын түвшинг хэмжих нь⁶

Байгууллагын комплаенсын хөтөлбөрийг хэмжих нь тухайн хөтөлбөрийн хэрэгжилт, байгууллагын комплаенсын давуу болон сул талууд, хууль тогтоомжид эрхэлж буй үйл ажиллагаа нийцэж байгаа эсэхийг тодорхойлох, ёс зүйн хэм хэмжээ ямар түвшинд мөрдөгдөж байгаа, байгууллагын дотоод сахилга бат аль түвшинд байгаа болон цаашид авах арга хэмжээний жагсаалтыг гаргах үндэс болно.

Комплаенсын түвшинг хэмжих аргачлалын загварт бодлогын баримт бичгийг үнэлэх, холбогдох баримт материалд үндэслэж үнэлгээ хийх, нэмэлтээр удирдлагуудтай ярилцлага хийх замаар үнэлэх олон талт аргачлал ашигласан болно. Удирдлагуудтай ярилцлага хийх гол зорилго нь тэдгээрийн ёс зүй, этик, комплаенсын тухай ойлголтыг үнэлэх явдал юм. Мөн ярилцлагын үеэр үнэлэх боломжтой асуудлуудыг жишээ болгон дурдвал:

- Ярилцлага өгч буй албан тушаалтны боловсрол, урьд өмнө ажил эрхэлж байсан байдал болон одоо хашиж буй албан тушаалын хугацаа;
- Хийж буй ажлын үүрэг хариуцлага, чиг үүрэг;
- Этик, комплаенсын асуудал хэрхэн яаж, ямар хэмжээнд оролцож ажилладаг байдал;
- Удирдлагын систем, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, аудит болон хяналтын тухай;
- Компаенсын хөтөлбөрийн бүтэц, хэв маяг;
- Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлсийг ёс зүйн асуудалд тусгасан байдал;
- Ёс зүйн хэм хэмжээний асуудалд шийтгэлийн механизмыг оруулсан байдал;
- Компанийн засаглал, үүрэг хариуцлага;
- Ёс зүй, комплаенсын чиглэлээр мэдээлэл солилцох суваг;
- Ёс зүй, комплаенсын асуудлаас урьдчилан сэргийлэх, зөрчил гарсан тохиолдолд шийдвэрлэх механизм;
- Бизнесийн болон стратегийн эрсдэл үүсэх магадлал, аюул занал.

Тайлагнал

Комплаенсын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд комплаенсын хөтөлбөр, авч хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах нь зохимжтой. Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ харьцангуй жижиг, цөөн орон тоотой үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хувьд ч энэ асуудал хамаатай. Ийм учраас комплаенсын ажилтны хийх ажлын төлөвлөгөө, үүрэг хариуцлага, хэнд, хэзээ, ямар хэлбэрээр мэдээлэх, тайлагнах тухай баримт бичигт тодорхой тусгаж өгч албажуулах нь

⁶ Компаенсын түвшинг хэмжих аргачлалын загварын жишгийг уг гарын авлагын Хавсралт А-д хавсаргасан.

зөв юм. Комплаенсын ажилтны тайланд хамгийн багадаа дараах асуудлуудыг тусгагдсан байх хэрэгтэй. Үүнд:

- Комплаенсын ажилтны тайлагнах этгээд болох давтамж;
- Комплаенсын эрсдэлийн үнэлгээ ба авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- Байгууллагын нэгж болон ажилтнууд комплаенсын зорилго, зорилт, хөтөлбөрийн дагуу хэрхэн яаж ажиллаж байгаа талаарх үнэлгээ;
- Дээд удирдлагата, байгууллагын нэгж, ажилтантай холбоотой комплаенсын аливаа асуудал болон авсан арга хэмжээ;
- Үнэлгээний үр дүнд алдаа дутагдлыг залруулах зорилготой авах арга хэмжээ.

Комплаенсын ажилтныг бие даасан, хараат бусаар үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангаж өгөх шаардлагатай. Одоогийн байдлаар комплаенсын нэгж, комплаенсын ажилтан зэрэг ойлголтууд харьцангуй шинэ байгаа бөгөөд олон улсын практикт комплаенсын ажилтан үйл ажиллагаагаа шууд ТУЗ-д, эсвэл холбогдох газар нэгж, мөн гүйцэтгэх удирдлагад тайлагнаж байна. PwC-ээс 2016 онд хийсэн “Комплаенсын нөхцөл байдал” судалгаа⁷-гаар комплаенсын ажилтнуудын 39 хувь нь ТУЗ эсвэл гүйцэтгэх удирдлагад, 36 хувь нь тодорхой газар, нэгжид, үлдсэн 17 хувь нь бусад дээд шатны удирдлагууддаа тайлагнадаг гэсэн дүнэлт гарчээ. Ерөнхийдөө комплаенсын ажилтны бие даасан, хараат бус байдалд гүйцэтгэх удирдлага нөлөөлж магадгүй гэж үздэг учир шууд ТУЗ-д ажлаа тайлагнадаг байх нь зохимжтой. Аль ч тохиолдолд комплаенсын ажилтан ТУЗ-д ажлаа шууд тайлагнадаг байх суваг нээлттэй байх учиртай. Нөгөө талаас гүйцэтгэх удирдлага комплаенсын үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байх шаардлагатай.

Ажилтнуудын оролцоо

Ажилтнууд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм журмыг сахиж мөрдөх ба комплаенсын соёлыг түгээж ажилладаг. Үүнд:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр:
 - Гүйлгээний зорилго, утга санаа, шалтгааныг олж илрүүлээгүй тохиолдолд харилцагчийн нэрийн өмнөөс гүйлгээ хийхгүй байх;
 - Тухайн харилцагч эсвэл тухайн гүйлгээ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотойг мэдэж байгаа эсвэл сэжиглэсэн болон үүний тухай мэдлэг, мэдээлэлтэй байх, сэжиглэх үндэслэлтэй тохиолдолд комплаенсын ажилтанд шуурхай мэдэгдэх;
 - Тухайн гүйлгээг сэжигтэй гүйлгээ гэж сэжиглэн мэдээлсэн тухай эсвэл тухайн гүйлгээг комплаенсын ажилтан дотроо хяналтад авсан эсвэл Санхүү мэдээллийн албанд хүргүүлж, шалгуулж буй талаар ямар ч харилцагч, ямар ч хүнд мэдээлэл өгч, дамжуулахгүй байх;

⁷ Getting ahead of watchdogs: Real-time compliance management, 2018 State of Compliance, PwC, <https://www.pwc.com/us/en/risk-assurance/state-of-compliance-study/assets/pwc-2018-state-of-compliance.pdf>

- Хяналт шалгалтын хийгдэх явцад шаардлагатай туслалцааг үзүүлж ажиллах;
- Ёс зүйн хэм хэмжээ, кодексыг мөрдөж ажиллан байгууллагын комплаенсын соёлыг дэлгэрүүлэх, дагаж мөрдөх;
- Сургалтад хамрагдсан тохиолдолд сургалтын тухай тэмдэглэл хөтлөх.

Сургалт

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн ажилтнуудыг МУТСТ тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байх шаардлагыг тавьдаг. Байгууллагын ажилтнууд МУТСТ шаардлага, түүнийг хэрхэн хангаж ажиллах тухай ойлголт, мэдлэггүй бол МУТСТ хөтөлбөр үр дүнтэй хэрэгжих боломжгүй.

Гэвч сургалтыг МУТСТ чиглэлээр хязгаарлахгүйгээр байгууллагын комплаенсын бусад асуудлуудыг багтааж, комплаенсын үйл ажиллагааны ач холбогдлыг нийт ажилтан, удирдлагуудад ойлгуулах хэрэгтэй.

Сургалтын хөтөлбөрт холбогдох хууль эрх зүйн актууд болон тухайн байгууллагын өөрийн боловсруулсан хөтөлбөр, бодлогын баримт бичгийн тухай ойлголт, МУТСТ үйл ажиллагаа, эрсдэлийн үнэлгээ, этик буюу ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчил, “шүгэл үлээх”, компанийн засаглал зэрэг сэдвүүдийг багтааж, комплаенсын соёлын тухай ойлголт өгч түүнийг дагаж мөрдөхийг хэвшүүлэх шаардлагатай. Шинэ ажилтнуудын сургалтад байгууллагын комплаенсын тухай ойлголтыг мөн багтааж өгөх нь зүйтэй.

Дээд шатны удирдлагад байгууллагын ажилтны түвшний сургалт шаардлагатай биш байж болох ч удирдлагууд тухайн байгууллагын үйл ажиллагааг хариуцдаг тул хууль эрх зүйн орчин, холбогдох дүрэм журмууд, тухайн байгууллагын эрсдэлүүд зэрэг мэдээллүүдээр хангагдаж байх хэрэгтэй. Мөн ТУЗ-ийн гишүүд болон дээд шатны удирдлага нь холбогдох хууль эрх зүйн актад өөрчлөлт орсон тохиолдолд үүний тухай мэдлэг, мэдээллээр тухай бүр хангагдаж байх ёстой.

Сургалтын агуулга нь ажилтнуудын хийдэг ажлын онцлогт хамааруулан өөр өөр байх нь тохиромжтой. Үүний тулд ажилтнуудыг эрсдэлээр эрэмбэлэх хэрэгтэй. Жишээлбэл, харилцагчтай шууд харьцаж бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг ажилтан буюу фронт оффис ажилтнуудын эрсдэлийн түвшин өндөр тул тэдгээр ажилтнуудад зориулсан сургалтаар их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээ, сэжигтэй гүйлгээ эсвэл харилцагчдыг илрүүлэх зэргийн тухай түлхүү мэдээлэл өгч, зааж сургах шаардлагатай. Түүнчлэн сургалтыг тогтмол зохион байгуулж байх шаардлагатай ба зохицуулалтын орчинд өөрчлөлт орсон, холбогдох эрх зүйн акт, байгууллагын дотоод бодлогын баримт бичиг, дүрэм журамд өөрчлөлт орсон, эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт орсон, шинээр хууль тогтоомж батлагдсан зэрэг тохиолдолд эдгээр өөрчлөлтүүдийг сургалтын агуулгад тусгаж, агуулгыг шинэчилж сургалтыг тухай бүр зохион байгуулах шаардлагатай. Үүнээс гадна комплаенсын хариуцсан ажилтан өөрөө сургалтад хамрагдаж байх шаардлагатай.

Сургалтыг олон янзаар хийж болно. Үүнд:

- Анги танхимын;

- Онлайн;
- Танхимын болон онлайн хосолсон г.м.

Ажилтнуудад комплаенсыг хоногшуулах, ач холбогдлыг нь ойлгуулах, ажилтнуудын комплаенсын оролцоог идэвхжүүлэхийн тулд сургалтыг хөгжилтэй, сонирхолтой байдлаар явуулах нь зүйтэй бөгөөд дараах аргуудыг ашиглаж болно. Үүнд:

- Дүрд хувирах, жүжигчилсэн тоглолт хийх;
- Тоглоомонд суурилсан сургалт явуулах;
- Сонирхолтой кэйс дээр ажиллах;
- Ажилтнуудад 7 хоног бүр комплаенсын тухай шинэ, соргог мэдээ, мэдээлэл хүргүүлж байх;
- Ажилтнуудаас судалгаа авах;
- Сургалтаар ямар сэдвийг үзэх хүсэлтэй байгаа талаар санал авах г.м.

Комплаенсын ажилтан байгууллагын ажилтан, удирдлагуудад сургалт зохион байгуулахад анхаарах зүйлсийн нэг нь сургалтыг баримтжуулах явдал юм. Гадаад, дотоодын аудитын шалгалт орсон тохиолдолд үүнийг шалгах бөгөөд батлагдсан сургалтын хөтөлбөр, агуулга, сургалт зохион байгуулсан огноо, байршил, сургалтад хамрагдагсдын мэдээлэл болон сургалтын материал зэрэг мэдээллүүдийг баримтжуулж хадгалж байх хэрэгтэй. Сургалтын үр дүнг хэмжих зорилгоор сургалтын өмнө болон дараа шалгалт авч болно.

2. БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ТУС БҮРИЙН КОМПЛАЕНСЫН ОНЦЛОГ

2.1. Үнэт цаасны салбар /Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны санал/

Үнэт цаасны зах зээл ба комплаенс

Комплаенс англиар *compliance*- зөвшөөрөл- оросоор *согласие*, нийцэл-оросоор *соответствие* гэж үгчилж болох ба үгийн язгуур нь англиар *to comply*- биелүүлэх- оросоор *исполнить* гэдэг үгнээс гаралтай. Комплаенсыг нийтлэг утгаар нь хүсэлт, тушаал, зааварт нийцсэн үйлдэл гэж тодорхойлсон байна. Бид монгол хэлнээ НИЙЦЭЛ хэмээн тодорхойлж байгаатай санал нэг байгаа хэдий ч олон улсад хэрэглэж хэвшсэн комплаенс гэдгээр нь хэрэглэхэд болохгүй зүйлгүй.

Үнэт цаасны зах зээлийн салбарт НИЙЦЭЛ гэдгийг хууль, эрх зүйн хэм хэмжээний акт, хяналт зохицуулалтын байгууллагын журам, стандарт, салбарын өөрийгөө удирдах байгууллагын журам, кодекс, ес зүйн шаардлагыг биелүүлээгүй, зөрчих эрсдлийн талаарх тухайн байгууллага(үнэт цаасны компани, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид, хувьцаат компани)-ын удирдлага/хяналтын тогтолцооны хэсэг гэж ойлгож болно. Нийцлийн шаардлагыг хангахгүй байх буюу хууль, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, стандартын шаардлагыг зөрчих (хангахгүй байх) эрсдэл нь хууль хяналтын болон зохицуулагч байгууллагын зүгээс санкци, хариуцлага хүлээлгэх, санхүүгийн болон үйл ажиллагааны ажил хэргийн нэр хүндээ алдах зэргээр илэрнэ.

Комплаенсын хүрээнд хууль, журам, стандартын шаардлага хангана гэдэг нь ихээхэн өргөн хүрээтэй:

- Компанийн үйл ажиллагааг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэх чиглэлээр журам, баримт бичиг боловсруулах;
- хууль, журамд заасан агуулга, хэлбэр, цаг хугацаанд нийцүүлэн тайлан, мэдээллийн урсгалыг хангах;
- дотоод мэдээллийн нууц, аюулгүй байдлыг хамгаалах;
- Зах зээлд явуулах үйл ажиллагааны дэг, шаардлага(*code of conduct*)-ыг хангах;
- Сонирхлын зөрчлийн удирдлага;
- Үйлчлүүлэгчидтэй зөв хандлагаар, шударгаар харилцах гм.

Түүнчлэн комплаенсын хүрээнд гэмт хэргийн замаар олсон орлогыг хууль ёсны болгох, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг, залилан мэхлэх, авлига, хээл хахуультай тэмцэх, ажилтнуудын зан үйл, ёс зүйн журам тогтоох зэрэг онцлог хүрээний асуудал ч хамаардаг.

Орчин үед хөгжингүй орнуудын томоохон компаниуд комплаенсыг мэргэжлийн үйл ажиллагааны нэг чиглэл болгон хөгжүүлж байна. Комплаенс гэдэг асуудал аливаа бизнесийн байгууллагад хамааралтай хэдий ч ялангуяа банк, санхүүгийн байгууллага, хөрөнгийн зах зээлийн оролцогч-үнэт цаасны компани зэрэг зохицуулалтай үйл ажиллагаа эрхлэгч, хувьцаат компаниудын хүрээнд комплаенсыг илүү түлхүү хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Тухайн компанийн хяналт шалгалт хариуцсан нэгжийг комплаенс хяналтын алба, комплаенс хэлтэс гэх зэргээр нэрлэж байна.

Комплаенсын эсрэг талд үл нийцэл буюу комплаенсын эрсдэл (үл нийцлийн эрсдэл) гэдэг ойлголт дагалдана. *Комплаенсын эрсдэл* гэдэг нь Монгол Улсын хууль тогтоомж, заавал мөрдвөл зохих төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллагаас тогтоосон журам, стандарт, зохистой харьцаа,

үнэт цаасны зах зээлийн оролцогч байгууллага өөрийн дотоод дүрэм, журмаа зөрчсөний улмаас хяналтын болон зохицуулагч байгууллагын зүгээс хариуцлага хүлээлгэх (торгох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах, бүртгэлээс хасах, эрх түдгэлзүүлэх, хасах гм), хуульд заасан бусад арга хэмжээ (онцгой байдал тогтоох, эрх хүлээн авагч томилох) авахад хүргэдэг. Энэхүү эрсдлийг *зохицуулалтын эрсдэл* гэдэг. Ийм эрсдэлд хүргэхгүйгээр нийцлийг хангаж ажиллахад компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын алба/ажилтан, нийт ажилтан бүгд хамтдаа комплаенсын бүхэл бүтэн системийг бий болгох шаардлагатай.

Комплаенс хариуцсан нэг/ажилтны чиг үүргүүд

Компанийн комплаенс эрсдлийн удирдлага/хяналтын энэхүү сиситемийн хүрээнд холбогдох нэгж, ажилтны хэрэгжүүлдэг үйл ажиллагааг тоймловол:

- Зохицуулалтыг эрсдлийг илрүүлэх;
- Зохицуулалтын эрсдэл бүхий үйл явдлыг бүртгэж, зохицуулалтын эрсдлээс үүсэх үр дагавар, үүсэх магадлалын тоон үзүүлэлтийг тоцоолж, үнэлэх;
- Зах зээлд шинээр нэвтрүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг нэвтрүүлэх арга ажиллагаанд комплаенс эрсдлийн үүднээс анализ хийх зэргээр зохицуулалтын эрсдлийн мониторингийг хэрэгжүүлэх;
- Зохицуулалтын эрсдлийн түвшинг бууруулах арга хэмжээ боловсруулахад оролцох, энэ талаарх компанийн бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны уялдааг хангах, зохицуулалтын эрсдлийн удирдлагын талаарх зөвлөмжөө компанийн удирдлагад танилцуулах;
- Зохицуулалтын эрсдлийн удирдлагын үр нөлөөний талаар мониторинг хийх;
- Зохицуулалтын эрсдлийн удирдлагын талаар компанийн дотоод журам, баримт бичиг боловсруулахад оролцох;
- Компанийн болон түүний ажилтнуудын үйл ажиллагаанд сонирхлын зөрчлийг илрүүлэх;
- Харилцагч нараас ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, өргөдлийн динамик үзүүлэлт болон компанийн зүгээс харилцагчдын эрхийг хангаж буй байдалд анализ хийх;
- Компани үйл ажиллагаа явуулахдаа зарим ажил, үйлчилгээг аутсорсингоор авч байгаа нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой эсэх талаар анализ хийх;
- Бусдад худалдагдах, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд чиглэсэн компанийн дотоод журам, баримт бичиг боловсруулахад оролцох;
- Компанийн үйл ажиллагааны дэг, шаардлага(code of conduct), мэргэжлийн ёс зүйн журмыг сахихад чиглэсэн компанийн дотоод журам, баримт бичиг боловсруулах, арга хэмжээ зохион байгуулахад оролцох;
- төрийн хяналт, зохицуулалтын байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллага, холбоод, хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагатай харилцах, хамтран ажиллахад эрх хэмжээнийхээ хүрээнд оролцох гм.

Комплаенсын журам, бодлогын баримт бичгүүд

Code of conduct (Кодекс корпоративного поведения) буюу компанийн үйл ажиллагааны дэг нь тухайн байгууллагын ажилтан өөрийн мэргэжлийн үүргээ биелүүлэх процест харилцагч-үйлчүүлэгчид, бусад ажилтнууд, нөгөө тал, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, хяналт, зохицуулалтын байгууллага зэрэг гуравдагч талуудтай харилцахад мөрдөх зан үйлийн журмыг тодорхойлдог гол баримт бичиг бөгөөд компанийн бизнес, үнэт зүйл, өмч хөрөнгө зэрэг бизнесийн зарчимд бүхэлд нь үйлчилдэг.

Code of conduct-компанийн үйл ажиллагааны дэгээс гадна дараах журам, эсхүл бодлогын баримт бичгийг боловсруулан мөрддөг:

- Компанийн ёс зүйн дүрэм (Code of Ethics);
- Бэлэг сэлт өгөх, хүлээн авах (Gift policy);
- Зөрчлийн талаар мэдээлэх- “Шүгэл үлээх” (Whistleblowing policy);
- Авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх (Financial Crime / Fraud Prevention);
- Гэмт хэргийн замаар олсон орлогыг хууль ёсны болгох буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх (Fight against Money Laundering and Terrorist Financing);
- Нууц хадгалах (Confidentiality);
- Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх (Conflict of interests, Chinese Walls);
- Дотоод мэдээлэл ашиглах, түүнд тавих хяналт;
- Зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх;
- Ажилтнуудын үнэт цаастай холбоотой гүйлгээнд тавих хяналт г.м.

Зохицуулалттай этгээд ба комплаенс

Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хуулийн 25 дугаар зүйлд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаандаа баримтлах зарчмуудыг тодорхойлсон байдаг. Энэ нь бүхэлдээ комплаенст хамаарч буй бөгөөд үүгээр ч хязгаарлагдахгүй юм. Үүнд:

- хууль тогтоомж, дүрэм, журам болон нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг мөрдөх;
- харилцагчид үйлчилгээ үзүүлэхдээ түүний хөрөнгө оруулалтын зорилго, боломжийн талаар зохих журмын дагуу судалж мэдсэн байх;
- хөрөнгө оруулалтын үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, зөвлөгөөгөөр харилцагчийг хангах;
- харилцагчтай болон холбогдох бусад этгээдтэй сонирхлын зөрчил үүсгэхээс зайлсхийх, сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд харилцагчид даруй мэдэгдэх;
- хувийн ашиг сонирхлоо харилцагчийн ашиг сонирхлоос дээгүүр тавихгүй байх, албан үүргээ гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;
- харилцагч тус бүрийн хөрөнгийг өөрийн болон бусад этгээдийн хөрөнгөөс тусгаарлан, найдвартай байдлыг хангаж ажиллах;
- тухайн үйл ажиллагааг эрхлэх, учирч болох эрсдэлийг хариуцах хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй байх;
- дотоод үйл ажиллагаагаа зохистой хэлбэрээр зохион байгуулж, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллах;
- үйл ажиллагаатай холбоотой анхан шатны бүртгэл, баримтыг стандартын дагуу хөтөлж, хадгалах;
- үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг хангахуйц хүний нөөцтэй байх;
- тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаатай холбогдолгүй бусад үйл ажиллагаа явуулахгүй байх.

Эдгээр зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор СЗХ, МХБ, МҮЦБ, ҮЦГХТөв, Арилжаа эрхлэгчдийн холбоо, түүнчлэн тухайн зохицуулалттэй этгээд болох үнэт цаасны компаниудын дотоод дүрэм, журмууд баталж мөрддөг. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 сарын 15 өдрийн 07 дугаар тогтоол Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журмыг баталсан. Уг журамд зааснаар зохицуулалттай этгээд нь тусгай зөвшөөрлийн шаардлага ёсоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх журамтай байх ба түүнд дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотойгоор хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтны үүрэг, хариуцлагыг зааглан тодорхойлсон байна.

Зохицуулалттай этгээдийн дотоод хяналтын тогтолцоо нь түүний нягтлан бодох бүртгэл, эрсдлийн удирдлагыг бүрэн хамаарч чадахуйц, үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж болохуйцаар

зохион байгуулагдсан, тухайн байгууллагын төв болон салбарын үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах зээлийн хууль, тогтоомж болон компанийн дотоод үйл ажиллагааны журмуудад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих орон тооны дотоод хяналтын ажилтантай байхаар журамласан. Дотоод хяналтын ажилтан нь хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлэх ба эрх бүхий этгээд, удирдлагаас өгсөн үүрэг, даалгавраар тухайлсан шалгалтыг гүйцэтгэж шалгалтын тайлан, дүгнэлтийг тухай бүр хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д танилцуулах үүрэгтэй.

Зохицуулалттай этгээдийн дотоод хяналтын ажилтан нь үр дүнтэй, шударга хяналтыг хэрэгжүүлж чадахуйц мэдлэг, туршлагатай байх ба компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь түүнийг бие даасан, хараат бус хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцлөөр хангах үүрэгтэй. Дотоод хяналтын ажилтан нь:

- компанийн бүх төрлийн бичиг баримт, бүртгэлийг шалгах эрхтэй, хөндлөнгийн аудитор, хянан шалгах зөвлөлд мэдээлэл өгөх
- зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, Хорооноос тогтоосон санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хангалт, эрсдлийн удирдлага, хяналтыг тогтмол мөрдүүлж ажиллах
- зохицуулалттай этгээдийн ерөнхий болон хүний нөөц, санхүү, нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээлэлд орсон өөрчлөлтийг тухай бүр Хороонд хүргүүлэх
- Хорооноос өгсөн үүрэг даалгавар болон улсын байцаагчийн албан шаардлагын биелэлт, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг Хороонд хүргүүлэх зэрэг үүрэгтэй байхаар журамласан байна.

Дотоод хяналтын ажилтан ажлаа Гүйцэтгэх удирдлагад тайлагнах ба түүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн харилцагчид хохирол учирсан бол тухайн зохицуулалттай этгээд хариуцлага хүлээхээр журамд заасан нь тэрээр үйл ажиллагаагаа бие даасан, шударга явуулах батлагааг хангах зорилготой гэж үзэж болох юм.

Комплаенс болон дотоод хяналтын хамаарлыг бид философийн ерөнхий ба тусгай гэдэг ойлголтын хүрээнд авч үзэж болох юм. Аливаа хяналт шалгалт нь үйл явдал болж өнгөрсний дараа, эхсүүл болж байхад голчлон зөрчлийг илрүүлэх, хариуцлага тооцох зорилготой байдаг бол комплаенс нь аливаа ажил, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахын өмнө, эхсүүл явцад хууль тогтоож, нийтээр хүлээн зөвшөөрсөн бизнесийн ердийн үйл ажиллагааны дэг жаягт нийцүүлэх илүү өргөн агуулга, зорилготой байна.

Үнэт цаасны зах зээлд комплаенсыг хангана гэдэг хууль тогтоомж хэм хэмжээний талаарх хуулийг унших төдий үйлдлээр үл хязгаарлагдсан, хууль журмын концепци, уялдаа холбоог бүхэлд нь судалж мэдсэн хуульчийн мэргэжлийн илүү мэргэшсэн чиглэл болгон хөгжүүлэх шаардлага манай зах зээлд тулгамдсан асуудлын нэг болоод байна. Жишээ нь, брокер дилерийн компани байгуулж, тусгай зөвшөөрөл авахад Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үйл ажиллагааны (багц) журам боловсруулсан байх, үйл ажиллагаагаа урт хугацаанд тогтвортой хангах, удирдлага, зохион байгуулалтын амьд тогтолцоо, эрх, үүргийн хуваарилалтыг хангасан Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн дотоод журмуудаа боловсруулсан байх, хүний нөөцийн болон техник технологийн шаардлагуудыг хангасан байх, мэргэжилтнүүдээ хөгжүүлэх, мэргэшүүлэх боломжит урт хугацааны сургалт-боловсролын хөтөлбөртэй байх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг бодлого, арга зүйгээ тодорхойлсон байх, санхүүгийн тайлан, хувь нийлүүлсэн хөрөнгийн болон бусад зохистой харьцааг хангасан байх, урт хугацаанд

тогтвортой үйл ажиллагаа явуулах зах зээлийн шинжилгээ, судалгаанд суурилсан бизнес төлөвлөгөө боловсруулсан байх зэрэг шаардлагууд тавигддаг. Монголын практикт ихэвчлэн “нэг загварын бичиг баримтыг дамжуулан хуулах” замаар оромдох нь ихээхэн түгээмэл байна. Энэ нь тухайн байгууллагын гадаад, дотоод орчин, онцлогт нийцсэн тогтоомын дүрэмгүйгээр, “азаа үзэх”, эсхүл “сэтгэлийн хөөрөл”-өөр тэмтчин зүтгэхтэй агаар нэг юм. Мэдээж загвар, маягтууд чухал. Гэсэн хэдий ч алхам бүр нь комплаенсын шаардлагыг хангасан амьд харилцаа, дэг журам маш чухал. Үүнд ялангуяа мэргэшсэн хуульч, мэргэжилтнүүдийг үйлчилгээ чухал үүрэгтэй бөгөөд эхнээс нь гараагаа зөв эхлүүлж хэвшүүлэхэд онцгой анхаарах нь зүйтэй юм. Буруу ажиллаад их хэмжээний торгууль хүлээх үү, зохих хэмжээний зардал гаргаад эхнээс нь зөв замаа гаргаж, урт хугацаанд хөгжин урагшлах уу гэдэг сонголтын өмнө зогсож байна гэсэн үг юм.

Цаашилбал, тухайн байгууллага байгуулагдчихсан, тусгай зөвшөөрлөө авчихсан гэж бодъё. Үнэт цаасны компанийн мэргэжлийн санхүүч, аналитикууд, зөвлөхүүдийн чадвар чансаа түүний үйлчлүүлэгчдийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх маш чухал нөөц юм. Нийтлэг жишгээс үзвэл үнэт цаасны компаниуд өөрийн харилцагчдаа ихэвчлэн дараах үйлчилгээ үзүүлдэг:

- Нийлэх нэгдэх (Mergers & Acquisiton)
- Хаалттай худалдах (Private Placements)
- Засгийн газрын болон орон нутгийн бонд гаргах (Government & Municipal Securities)
- Үнэт цаасны репо, зээлдэх (Repo & Securities Lending)
- Маркет мэкинг (Market Makers)
- Жижиглэнгийн бүх үйлчилгээ, үнэт цаасны данстайгаа харилцах (Full service retail with clearing relationship).

Хамгийн сайн мэргэжилтэн ч эдгээр үйлчилгээг хууль зүйн зөвлөгөө, туслалцаагүйгээр, ямар нэгэн загвар, маягт ашиглан үзүүлэх нь комплаенс эрсдэлд хүргэх дараагийн эрсдлийг хаахгүй гэдгийг анхаарах нь зүйтэй юм.

Манай үнэт цаасны брокер дилерийн компаниуд харилцагч-иргэн, хуулийн этгээд үнэт цаасны арилжаанд оролцохтой холбоотойгоор данс нээх, захиалга авах, биелүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг нийтлэг үйлчилгээ үзүүлдэг. Зарим тохиолдолд хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, үнэт цаасны бүртгэлээс хасуулах, нийлэх, нэгдэх ажиллагаанд туслалцаа үзүүлж байна. Хэдийгээр тухайн үйл ажиллагааны явцад үнэт цаасны компанийн мэргэшсэн зөвлөгөө туслалцаа авах шаардлага гарах тохиолдол байхыг үгүйсгэх боломжгүй ч тухайн хувьцаат компани үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө өгөх эрх бүхий мэргэшсэн хуульчгүй, эсхүл тийм үйлчилгээг аутсорсингоор авдаггүйтэй холбоотойгоор үнэт цаасны компаниуд энэ үйлчилгээг үзүүлж байгааг тэдний жинхэнэ мэргэжлийн үйлчилгээ мөн гэдэгт эргэлзэхээр байна.

Комплаенсын асуудлыг хөндөж, хөгжүүлэх бодлого хүчтэй тавигдаж байгаатай зэрэгцэн төрөл бүрийн мэргэжлийн үйлчилгээ даган хөгжих, илүү өндөр түвшинд мэргэших боломж нээгдэж байна.

Комплаенс ба хууль зүйн зөвлөгөө

Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр сургалтанд хамрагдаж, СЗХ-д бүртгүүлсэн хуулийн фирмүүд одоогийн ҮЦК-уудын үзүүлээд байгаа дээр дурдсан үйлчилгээнээс

гадна дараах чиглэлээр мэргэшсэн хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чадамжтай болж хөгжиж байна:

- IPO хийхийн өмнөх хууль зүйн шинжилгээ, судалгаа-Due Diligence;
- IPO хийх үед хууль зүйн дүгнэлт гаргах;
- Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, хууль зүйн дүгнэлт;
- Үнэт цаасны бүртгэлээс хасах, хууль зүйн дүгнэлт;
- Бондын бүтэц, бонд гаргах, өрийн хувьцаагаар солих;
- Компанийн засаглалын журмуудыг тухайн байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулах;
- Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр;
- Нийлэх нэгдэх буюу хувьцаат компанийг худалдан авах;
- Бүртэлтэй компанийн ХЭХ зохион байгуулах;
- Тухайн компанитай үйл ажиллагаагаа нягт уялдуулсны үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай болон Компанийн тухай хуульд заасан нийтэд мэдээлэх үүргийн хэрэгжилтийн болон сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мониторинг;
- ХК болон бусад оролцогчдын хүсэлтээр комплаенсын сургалт, семинар зохион байгуулах;
- Тухайн ХК эсхүл үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч компанийн комплаенс гарын авлага боловсруулах.

Хэрэв тухайн компани ямар нэгэн зохицуулалтын эрсдэлгүй байхыг хүсч байгаа бол хууль тогтоомж, хяналт, зохицуулалтын байгууллагын баталсан журам, стандарт, өөрийгөө удирдах байгууллагаас тогтоосон хэм хэмжээ болон компанийн өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн комплаенс гарын авлага боловсруулж, ажилтан бүрээ сургаж дадлагажуулан хэвшил болгон мөрдүүлэх шаардлагатай байна. Үүнд удирдлагын манлайлал, санхүүгийн болон хууль зүйн хосолсон мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа зайлшгүй юм. Орчин үеийн мэдээллийн технологийн хөгжлийн эрин үед технологийн тусламжтайгаар комплаенсын эрсдэл гаргахгүй байх боломжийг ч үргэлжлүүлэн судалж, боловсруулж, нэвтрүүлэх үүд хаалга нээлттэй байна.

Үнэт цаасны зах зээл ба комплаенс

Комплаенс англиар *compliance*- зөвшөөрөл- оросоор *согласие*, нийцэл-оросоор *соответствие* гэж үгчилж болох ба үгийн язгуур нь англиар *to comply*- биелүүлэх- оросоор *исполнить* гэдэг үгнээс гаралтай. Комплаенсыг нийтлэг утгаар нь хүсэлт, тушаал, зааварт нийцсэн үйлдэл гэж тодорхойлсон байна. Бид монгол хэлнээ НИЙЦЭЛ хэмээн тодорхойлж байгаатай санал нэг байгаа хэдий ч олон улсад хэрэглэж хэвшсэн комплаенс гэдгээр нь хэрэглэхэд болохгүй зүйлгүй.

Үнэт цаасны зах зээлийн салбарт НИЙЦЭЛ гэдгийг хууль, эрх зүйн хэм хэмжээний акт, хяналт зохицуулалтын байгууллагын журам, стандарт, салбарын өөрийгөө удирдах байгууллагын журам, кодекс, ес зүйн шаардлагыг биелүүлээгүй, зөрчих эрсдлийн талаарх тухайн байгууллага(үнэт цаасны компани, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид, хувьцаат компани)-ын удирдлага/хяналтын тогтолцооны хэсэг гэж ойлгож болно. Нийцлийн шаардлагыг хангахгүй байх буюу хууль, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, стандартын шаардлагыг зөрчих (хангахгүй байх) эрсдэл нь хууль хяналтын болон зохицуулагч байгууллагын зүгээс санкци, хариуцлага хүлээлгэх, санхүүгийн болон үйл ажиллагааны ажил хэргийн нэр хүндээ алдах зэргээр илэрнэ.

Комплаенсын хүрээнд хууль, журам, стандартын шаардлага хангана гэдэг нь ихээхэн өргөн хүрээтэй:

- Компанийн үйл ажиллагааг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэх чиглэлээр журам, баримт бичиг боловсруулах;
- хууль, журамд заасан агуулга, хэлбэр, цаг хугацаанд нийцүүлэн тайлан, мэдээллийн урсгалыг хангах;
- дотоод мэдээллийн нууц, аюулгүй байдлыг хамгаалах;
- Зах зээлд явуулах үйл ажиллагааны дэг, шаардлага(code of conduct)-ыг хангах;
- Сонирхлын зөрчлийн удирдлага;
- Үйлчлүүлэгчидтэй зөв хандлагаар, шударгаар харилцах гм.

Түүнчлэн комплаенсын хүрээнд гэмт хэргийн замаар олсон орлогыг хууль ёсны болгох, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг, залилан мэхлэх, авлига, хээл хахуультай тэмцэх, ажилтнуудын зан үйл, ёс зүйн журам тогтоох зэрэг онцлог хүрээний асуудал ч хамаардаг.

Орчин үед хөгжингүй орнуудын томоохон компаниуд комплаенсыг мэргэжлийн үйл ажиллагааны нэг чиглэл болгон хөгжүүлж байна. Комплаенс гэдэг асуудал аливаа бизнесийн байгууллагад хамааралтай хэдий ч ялангуяа банк, санхүүгийн байгууллага, хөрөнгийн зах зээлийн оролцогч-үнэт цаасны компани зэрэг зохицуулалтай үйл ажиллагаа эрхлэгч, хувьцаат компаниудын хүрээнд комплаенсыг илүү түлхүү хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Тухайн компанийн хяналт шалгалт хариуцсан нэгжийг комплаенс хяналтын алба, комплаенс хэлтэс гэх зэргээр нэрлэж байна.

Комплаенсын эсрэг талд үл нийцэл буюу комплаенсын эрсдэл (үл нийцлийн эрсдэл) гэдэг ойлголт дагалдана. *Комплаенсын эрсдэл* гэдэг нь Монгол Улсын хууль тогтоомж, заавал мөрдвөл зохих төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллагаас тогтоосон журам, стандарт, зохистой харьцаа, үнэт цаасны зах зээлийн оролцогч байгууллага өөрийн дотоод дүрэм, журмаа зөрчсөний улмаас хяналтын болон зохицуулагч байгууллагын зүгээс хариуцлага хүлээлгэх (торгох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах, бүртгэлээс хасах, эрх түдгэлзүүлэх, хасах гм), хуульд заасан бусад арга хэмжээ (онцгой байдал тогтоох, эрх хүлээн авагч томилох) авахад хүргэдэг. Энэхүү эрсдлийг *зохицуулалтын эрсдэл* гэдэг. Ийм эрсдэлд хүргэхгүйгээр нийцлийг хангаж ажиллахад компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын алба/ажилтан, нийт ажилтан бүгд хамтдаа комплаенсын бүхэл бүтэн системийг бий болгох шаардлагатай.

Комплаенс хариуцсан нэг/ажилтны чиг үүргүүд

Компанийн комплаенс эрсдлийн удирдлага/хяналтын энэхүү сиситемийн хүрээнд холбогдох нэгж, ажилтны хэрэгжүүлдэг үйл ажиллагааг тоймловол:

- Зохицуулалтыг эрсдлийг илрүүлэх;
- Зохицуулалтын эрсдэл бүхий үйл явдлыг бүртгэж, зохицуулалтын эрсдлээс үүсэх үр дагавар, үүсэх магадлалын тоон үзүүлэлтийг тоцоолж, үнэлэх;
- Зах зээлд шинээр нэвтрүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг нэвтрүүлэх арга ажиллагаанд комплаенс эрсдлийн үүднээс анализ хийх зэргээр зохицуулалтын эрсдлийн мониторингийг хэрэгжүүлэх;
- Зохицуулалтын эрсдлийн түвшинг бууруулах арга хэмжээ боловсруулахад оролцох, энэ талаарх компанийн бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны уялдааг хангах, зохицуулалтын эрсдлийн удирдлагын талаарх зөвлөмжөө компанийн удирдлагад танилцуулах;
- Зохицуулалтын эрсдлийн удирдлагын үр нөлөөний талаар мониторинг хийх;

- Зохицуулалтын эрсдлийн удирдлагын талаар компанийн дотоод журам, баримт бичиг боловсруулахад оролцох;
- Компанийн болон түүний ажилтнуудын үйл ажиллагаанд сонирхлын зөрчлийг илрүүлэх;
- Харилцагч нараас ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, өргөдлийн динамик үзүүлэлт болон компанийн зүгээс харилцагчдын эрхийг хангаж буй байдалд анализ хийх;
- Компани үйл ажиллагаа явуулахдаа зарим ажил, үйлчилгээг аутсорсингоор авч байгаа нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой эсэх талаар анализ хийх;
- Бусдад худалдагдах, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд чиглэсэн компанийн дотоод журам, баримт бичиг боловсруулахад оролцох;
- Компанийн үйл ажиллагааны дэг, шаардлага(code of conduct), мэргэжлийн ёс зүйн журмыг сахихад чиглэсэн компанийн дотоод журам, баримт бичиг боловсруулах, арга хэмжээ зохион байгуулахад оролцох;
- төрийн хяналт, зохицуулалтын байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллага, холбоод, хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагатай харилцах, хамтран ажиллахад эрх хэмжээнийхээ хүрээнд оролцох г.м.

Комплаенсын журам, бодлогын баримт бичгүүд

Code of conduct (Кодекс корпоративного поведения) буюу компанийн үйл ажиллагааны дэг нь тухайн байгууллагын ажилтан өөрийн мэргэжлийн үүргээ биелүүлэх процест харилцагч-үйлчүүлэгчид, бусад ажилтнууд, нөгөө тал, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, хяналт, зохицуулалтын байгууллага зэрэг гуравдагч талуудтай харилцахад мөрдөх зан үйлийн журмыг тодорхойлдог гол баримт бичиг бөгөөд компанийн бизнес, үнэт зүйл, өмч хөрөнгө зэрэг бизнесийн зарчимд бүхэлд нь үйлчилдэг.

Code of conduct-компанийн үйл ажиллагааны дэгээс гадна дараах журам, эсхүл бодлогын баримт бичгийг боловсруулан мөрддөг:

- Компанийн ёс зүйн дүрэм (Code of Ethics);
- Бэлэг сэлт өгөх, хүлээн авах (Gift policy);
- Зөрчлийн талаар мэдээлэх- “Шүгэл үлээх” (Whistleblowing policy);
- Авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх (Financial Crime / Fraud Prevention);
- Гэмт хэргийн замаар олсон орлогыг хууль ёсны болгох буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх (Fight against Money Laundering and Terrorist Financing);
- Нууц хадгалах (Confidentiality);
- Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх (Conflict of interests, Chinese Walls);
- Дотоод мэдээлэл ашиглах, түүнд тавих хяналт;
- Зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх;
- Ажилтнуудын үнэт цаастай холбоотой гүйлгээнд тавих хяналт г.м.

Зохицуулалттай этгээд ба комплаенс

Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хуулийн 25 дугаар зүйлд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаандаа баримтлах зарчмуудыг тодорхойлсон байдаг. Энэ нь бүхэлдээ комплаенст хамаарч буй бөгөөд үүгээр ч хязгаарлагдахгүй юм. Үүнд:

- хууль тогтоомж, дүрэм, журам болон нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг мөрдөх;
- харилцагчид үйлчилгээ үзүүлэхдээ түүний хөрөнгө оруулалтын зорилго, боломжийн талаар зохих журмын дагуу судалж мэдсэн байх;

- хөрөнгө оруулалтын үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, зөвлөгөөгөөр харилцагчийг хангах;
- харилцагчтай болон холбогдох бусад этгээдтэй сонирхлын зөрчил үүсгэхээс зайлсхийх, сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд харилцагчид даруй мэдэгдэх;
- хувийн ашиг сонирхлоо харилцагчийн ашиг сонирхлоос дээгүүр тавихгүй байх, албан үүргээ гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;
- харилцагч тус бүрийн хөрөнгийг өөрийн болон бусад этгээдийн хөрөнгөөс тусгаарлан, найдвартай байдлыг хангаж ажиллах;
- тухайн үйл ажиллагааг эрхлэх, учирч болох эрсдэлийг хариуцах хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй байх;
- дотоод үйл ажиллагаагаа зохистой хэлбэрээр зохион байгуулж, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллах;
- үйл ажиллагаатай холбоотой анхан шатны бүртгэл, баримтыг стандартын дагуу хөтөлж, хадгалах;
- үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг хангахуйц хүний нөөцтэй байх;
- тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаатай холбогдолгүй бусад үйл ажиллагаа явуулахгүй байх.

Эдгээр зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор СЗХ, МХБ, МҮЦБ, ҮЦГХТөв, Арилжаа эрхлэгчдийн холбоо, түүнчлэн тухайн зохицуулалттай этгээд болох үнэт цаасны компаниудын дотоод дүрэм, журмууд баталж мөрддөг. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 сарын 15 өдрийн 07 дугаар тогтоол Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журмыг баталсан. Уг журамд зааснаар зохицуулалттай этгээд нь тусгай зөвшөөрлийн шаардлага ёсоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх журамтай байх ба түүнд дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотойгоор хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтны үүрэг, хариуцлагыг зааглан тодорхойлсон байна.

Зохицуулалттай этгээдийн дотоод хяналтын тогтолцоо нь түүний нягтлан бодох бүртгэл, эрсдлийн удирдлагыг бүрэн хамаарч чадахуйц, үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж болохуйцаар зохион байгуулагдсан, тухайн байгууллагын төв болон салбарын үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах зээлийн хууль, тогтоомж болон компанийн дотоод үйл ажиллагааны журмуудад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих орон тооны дотоод хяналтын ажилтантай байхаар журамласан. Дотоод хяналтын ажилтан нь хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлэх ба эрх бүхий этгээд, удирдлагаас өгсөн үүрэг, даалгавраар тухайлсан шалгалтыг гүйцэтгэж шалгалтын тайлан, дүгнэлтийг тухай бүр хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д танилцуулах үүрэгтэй.

Зохицуулалттай этгээдийн дотоод хяналтын ажилтан нь үр дүнтэй, шударга хяналтыг хэрэгжүүлж чадахуйц мэдлэг, туршлагатай байх ба компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь түүнийг бие даасан, хараат бус хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцлөөр хангах үүрэгтэй. Дотоод хяналтын ажилтан нь:

- компанийн бүх төрлийн бичиг баримт, бүртгэлийг шалгах эрхтэй, хөндлөнгийн аудитор, хянан шалгах зөвлөлд мэдээлэл өгөх
- зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, Хорооноос тогтоосон санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хангалт, эрсдлийн удирдлага, хяналтыг тогтмол мөрдүүлж ажиллах
- зохицуулалттай этгээдийн ерөнхий болон хүний нөөц, санхүү, нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээлэлд орсон өөрчлөлтийг тухай бүр Хороонд хүргүүлэх
- Хорооноос өгсөн үүрэг даалгавар болон улсын байцаагчийн албан шаардлагын биелэлт, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг Хороонд хүргүүлэх зэрэг үүрэгтэй байхаар журамласан байна.

Дотоод хяналтын ажилтан ажлаа Гүйцэтгэх удирдлагад тайлагнах ба түүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн харилцагчид хохирол учирсан бол тухайн зохицуулалттай этгээд хариуцлага хүлээхээр журамд заасан нь тэрээр үйл ажиллагаагаа бие даасан, шударга явуулах батлагааг хангах зорилготой гэж үзэж болох юм.

Комплаенс болон дотоод хяналтын хамаарлыг бид философийн ерөнхий ба тусгай гэдэг ойлголтын хүрээнд авч үзэж болох юм. Аливаа хяналт шалгалт нь үйл явдал болж өнгөрсний дараа, эхсүүл болж байхад голчлон зөрчлийг илрүүлэх, хариуцлага тооцох зорилготой байдаг бол комплаенс нь аливаа ажил, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахын өмнө, эхсүүл явцад хууль тогтоож, нийтээр хүлээн зөвшөөрсөн бизнесийн ердийн үйл ажиллагааны дэг жаягт нийцүүлэх илүү өргөн агуулга, зорилготой байна.

Үнэт цаасны зах зээлд комплаенсыг хангана гэдэг хууль тогтоомж хэм хэмжээний талаарх хуулийг унших төдий үйлдлээр үл хязгаарлагдсан, хууль журмын концепци, уялдаа холбоог бүхэлд нь судалж мэдсэн хуульчийн мэргэжлийн илүү мэргэшсэн чиглэл болгон хөгжүүлэх шаардлага манай зах зээлд тулгамдсан асуудлын нэг болоод байна. Жишээ нь, брокер дилерийн компани байгуулж, тусгай зөвшөөрөл авахад Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үйл ажиллагааны (багц) журам боловсруулсан байх, үйл ажиллагаагаа урт хугацаанд тогтвортой хангах, удирдлага, зохион байгуулалтын амьд тогтолцоо, эрх, үүргийн хуваарилалтыг хангасан Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн дотоод журмуудаа боловсруулсан байх, хүний нөөцийн болон техник технологийн шаардлагуудыг хангасан байх, мэргэжилтнүүдээ хөгжүүлэх, мэргэшүүлэх боломжит урт хугацааны сургалт-боловсролын хөтөлбөртэй байх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг бодлого, арга зүйгээ тодорхойлсон байх, санхүүгийн тайлан, хувь нийлүүлсэн хөрөнгийн болон бусад зохистой харьцааг хангасан байх, урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах зах зээлийн шинжилгээ, судалгаанд суурилсан бизнес төлөвлөгөө боловсруулсан байх зэрэг шаардлагууд тавигддаг. Монголын практикт ихэвчлэн “нэг загварын бичиг баримтыг дамжуулан хуулах” замаар оромдох нь ихээхэн түгээмэл байна. Энэ нь тухайн байгууллагын гадаад, дотоод орчин, онцлогт нийцсэн тогтоомын дүрэмгүйгээр, “азаа үзэх”, эсхүл “сэтгэлийн хөөрөл”-өөр тэмтчин зүтгэхтэй агаар нэг юм. Мэдээж загвар, маягтууд чухал. Гэсэн хэдий ч алхам бүр нь комплаенсын шаардлагыг хангасан амьд харилцаа, дэг журам маш чухал. Үүнд ялангуяа мэргэшсэн хуульч, мэргэжилтнүүдийг үйлчилгээ чухал үүрэгтэй бөгөөд эхнээс нь гараагаа зөв эхлүүлж хэвшүүлэхэд онцгой анхаарах нь зүйтэй юм. Буруу ажиллаад их хэмжээний торгууль хүлээх үү, зохих хэмжээний зардал гаргаад эхнээс нь зөв замаа гаргаж, урт хугацаанд хөгжин урагшлах уу гэдэг сонголтын өмнө зогсож байна гэсэн үг юм.

Цаашилбал, тухайн байгууллага байгуулагдчихсан, тусгай зөвшөөрлөө авчихсан гэж бодъё. Үнэт цаасны компанийн мэргэжлийн санхүүч, аналитикууд, зөвлөхүүдийн чадвар чансаа түүний үйлчлүүлэгчдийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх маш чухал нөөц юм. Нийтлэг жишгээс үзвэл үнэт цаасны компаниуд өөрийн харилцагчдаа ихэвчлэн дараах үйлчилгээ үзүүлдэг:

- Нийлэх нэгдэх (Mergers & Acquisiton)
- Хаалттай худалдах (Private Placements)
- Засгийн газрын болон орон нутгийн бонд гаргах (Government & Municipal Securities)
- Үнэт цаасны репо, зээлдэх (Repo & Securities Lending)
- Маркет мэкинг (Market Makers)
- Жижиглэнгийн бүх үйлчилгээ, үнэт цаасны данстайгаа харилцах (Full service retail with clearing relationship).

Хамгийн сайн мэргэжилтэн ч эдгээр үйлчилгээг хууль зүйн зөвлөгөө, туслалцаагүйгээр, ямар нэгэн загвар, маягт ашиглан үзүүлэх нь комплаенс эрсдэлд хүргэх дараагийн эрсдлийг хаахгүй гэдгийг анхаарах нь зүйтэй юм.

Манай үнэт цаасны брокер дилерийн компаниуд харилцагч-иргэн, хуулийн этгээд үнэт цаасны арилжаанд оролцохтой холбоотойгоор данс нээх, захиалга авах, биелүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг нийтлэг үйлчилгээ үзүүлдэг. Зарим тохиолдолд хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, үнэт цаасны бүртгэлээс хасуулах, нийлэх, нэгдэх ажиллагаанд туслалцаа үзүүлж байна. Хэдийгээр тухайн үйл ажиллагааны явцад үнэт цаасны компанийн мэргэшсэн зөвлөгөө туслалцаа авах шаардлага гарах тохиолдол байхыг үгүйсгэх боломжгүй ч тухайн хувьцаат компани үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө өгөх эрх бүхий мэргэшсэн хуульчгүй, эсхүл тийм үйлчилгээг аутсорсингоор авдаггүйтэй холбоотойгоор үнэт цаасны компаниуд энэ үйлчилгээг үзүүлж байгааг тэдний жинхэнэ мэргэжлийн үйлчилгээ мөн гэдэгт эргэлзэхээр байна.

Комплаенсын асуудлыг хөндөж, хөгжүүлэх бодлого хүчтэй тавигдаж байгаатай зэрэгцэн төрөл бүрийн мэргэжлийн үйлчилгээ даган хөгжих, илүү өндөр түвшинд мэргэших боломж нээгдэж байна.

Комплаенс ба хууль зүйн зөвлөгөө

Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр сургалтанд хамрагдаж, СЗХ-д бүртгүүлсэн хуулийн фирмүүд одоогийн ҮЦК-уудын үзүүлээд байгаа дээр дурдсан үйлчилгээнээс гадна дараах чиглэлээр мэргэшсэн хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чадамжтай болж хөгжиж байна:

- IPO хийхийн өмнөх хууль зүйн шинжилгээ, судалгаа-Due Diligence;
- IPO хийх үед хууль зүйн дүгнэлт гаргах;
- Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, хууль зүйн дүгнэлт;
- Үнэт цаасны бүртгэлээс хасах, хууль зүйн дүгнэлт;
- Бондын бүтэц, бонд гаргах, өрийн хувьцаагаар солих;
- Компанийн засаглалын журмуудыг тухайн байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулах;
- Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр;
- Нийлэх нэгдэх буюу хувьцаат компанийг худалдан авах;
- Бүртэлтэй компанийн ХЭХ зохион байгуулах;
- Тухайн компанитай үйл ажиллагаагаа нягт уялдуулсны үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай болон Компанийн тухай хуульд заасан нийтэд мэдээлэх үүргийн хэрэгжилтийн болон сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мониторинг;
- ХК болон бусад оролцогчдын хүсэлтээр комплаенсын сургалт, семинар зохион байгуулах;
- Тухайн ХК эсхүл үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч компанийн комплаенс гарын авлага боловсруулах.

Хэрэв тухайн компани ямар нэгэн зохицуулалтын эрсдэлгүй байхыг хүсч байгаа бол хууль тогтоомж, хяналт, зохицуулалтын байгууллагын баталсан журам, стандарт, өөрийгөө удирдах байгууллагаас тогтоосон хэм хэмжээ болон компанийн өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн

комплаенс гарын авлага боловсруулж, ажилтан бүрээ сургаж дадлагажуулан хэвшил болгон мөрдүүлэх шаардлагатай байна. Үүнд удирдлагын манлайлал, санхүүгийн болон хууль зүйн хосолсон мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа зайлшгүй юм. Орчин үеийн мэдээллийн технологийн хөгжлийн эрин үед технологийн тусламжтайгаар комплаенсын эрсдэл гаргахгүй байх боломжийг ч үргэлжлүүлэн судалж, боловсруулж, нэвтрүүлэх үүд хаалга нээлттэй байна.

2.2. Даатгалын салбар /Монголын даатгагчдын холбооны санал/

1. Ерөнхий ойлголт

1.1. Энэхүү журмаар Даатгалын салбарын үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан журам, Базелийн хорооны зөвлөмж, Монголын Даатгалын Холбооноос баталсан ёс зүйн дүрэм, журмыг баримтлах, удирдлагын зохистой тогтолцоо, соёлыг төлөвшүүлэх, заавраар хүлээсэн үүргээ биелүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

2. Комплаенсын үйл ажиллагаа ба түүний шаардлага, ач холбогдол

3. Комплаенсын үйл ажиллагааны цар хүрээ

3.1 Энэхүү журмыг Даатгалын байгууллагад хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж буй ажилтан бүр дагаж мөрдөнө. Даатгалын салбарын үйл ажиллагаанд комплаенсын үйл ажиллагааг хянан нийцүүлэлийн үүрэг гэж дараах хууль, эрх зүйн баримт бичгүүдийг дагаж мөрдөхийг хэлнэ:

- Монгол Улсын хууль тогтоомж;
- Зохицуулалтын журам;
- Зохицуулалтын шаардлага;
- Дотоод дүрэм, журам;

4. Комплаенсын бүтэц, зохион байгуулалт /компанийн засаглал/

4.1 Байгууллагын удирдлага, ТУЗ-ийн оролцоо

4.1.1. Хариуцлага

4.1.2. Байгууллагын Гүйцэтгэх удирдлагын хороо нь комплаенсын асуудал эрхэлсэн мэргэжилтэнд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчил гаргасан ажилтанд байгууллагын дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлнэ.

4.2 Комплаенсын ажилтан томилох/нэгж байгуулах шаардлага, ач холбогдол, ажлын чиг үүрэг, хариуцлага, тайлан, мэдээлэл:

4.2.1 Комплаенсын ноцтой эрсдэл гарсан тохиолдолд энэ тухай асуудал эрхэлсэн мэргэжилтэнд даруй мэдэгдэнэ;

4.2.2 Комплаенсын асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь дараах зүйлийг Гүйцэтгэх захиралд даруй мэдэгдэнэ;

- Комплаенсын чиглэлээр гарсан ноцтой зөрчил
- Комплаенсын чиглэлээр гарч болзошгүй зөрчил
- Ноцтой зөрчил гарсаны улмаас хууль тогтоомжийн дагуу авагдсан арга хэмжээ, гаргасан гомдлын талаар.


4.2.3 Байгууллагын бүх захирлууд өөрийн эрхлэх асуудлыг чиглэлээр хянан нийцүүлэлтийн удирдлагын хэрэгжилтийн талаар тайланг жилд нэг удаа өөрийн ажиллаж буй байгууллагын хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн, Гүйцэтгэх захиралд тус тус хүргүүлнэ. Тайланд дараах зүйлийг тусгасан байна:

4.2.3.1 Комплаенсын үүргийг хангах зорилгоор хариуцаж буй ажлын бүх чиглэлээр хийсэн эрсдэлийн үнэлгээ:

4.2.3.2 Комплаенсын эрсдэлийг үр дүнтэй удирдах зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээ:

4.2.3.3 Тайлангийн хугаацаанд хариуцсан ажлын чиглэлээр хянан нийцүүлэлтийн үүргийн зөрчил гарсан эсэх талаар дүгнэлт, зөрчил гарсан бол зөрчлийн талаарх мэдээлэл, түүний шалтгааныг тусгах.

4.2.4 Комплаенсын асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь тайлангуудыг нэгтгэж, тухайн жилийн Гүйцэтгэх удирдлагын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.



4.2.4 Байгууллагын нийт ажилтнууд хянан нийцүүлэлтийн үүргийг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

4.2.4.1 Комплаенсын ноцтой зөрчил гарсан буюу гарах эрсдэл бий болсон тохиолдолд энэ тухай Комплаенсын асуудал эрхэлсэн мэргэжилтэн болон удирдлагад мэдээлэх;

4.2.4.2 Комплаенсын зөрчлийг шалгахтай холбоотой баримт бичиг, программ хангамж, мэдээллээр Комплаенсын асуудал эрхэлсэн мэргэжилтэнг хангах;

4.2.4.3 Ажилтан бүр өөрийн ажлын байрандаа ёс зүйн дүрэмд заасан нийтлэг зарчмыг сахин биелүүлнэ;

- 4.2.4.4 Ажилтан бүр өөрийн мэргэжлийн үйл ажиллагаандаа хууль тогтоомж, дотоод бодлого журамд заасан хэм хэмжээг дагаж мөрдөнө.
- 4.2.5 Байгууллагын удирдлагууд дараах Комплаенсын үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.2.6 Байгууллагын бүх захирлууд өөрийн эрхлэх асуудлын чиглэлээр Комплаенсын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана.
- 4.2.7 Гүйцэтгэх захирал нь байгууллагын хэмжээнд хянан нийцүүлэлтийг хангах баримт бичгийн бүрдлийг хариуцаж, тэдгээрийн ажилтнуудад мөрдүүлэх, ТУЗ-д Комплаенсын эрсдэлийн удирдлагын талаар тайлагнах үүргийг хүлээнэ.
- 4.2.8 Гүйцэтгэх захирал нь тулгарч буй Комплаенсын эрсдэлийг жилд нэгээс доошгүй удаа шаардлагатай бол хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтний оролцоотойгоор тодорхойж, тэдгээрийг системийн хэмжээнд удирдах арга хэмжээний төлөвлөгөө буюу хянан нийцүүлэлтийн хөтөлбөрийг батална.
- 4.2.9 Байгууллагын Гүйцэтгэх удирдлагын хороон нь хууль тогтоомжийн дагуу буюу эрх бүхий байгууллагын шийдвэрээр хариуцлага хүлээх, санхүүгийн их хэмжээний алдагдалд хүргэх, байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх хянан нийцүүлэлтийн ноцтой зөрчлийг ТУЗ-д шуурхай танилцуулна.

4.3 Тавигдах шаардлага, комплаенсын түвшинг хэмжих нь

4.3.1. Хамгаалалтын нэгдүгээр бүс (Бүх нэгжийн захирлууд)

- Байгууллагын бүх нэгжийн захирлууд өөрийн эрхлэх асуудлын чиглэлээр хянан нийцүүлэлтийн эрсдэлийн удирдлагыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.
- Хянан нийцүүлэлтийн ёс зүй, соёлыг төлөвшүүлэх;
- Хууль тогтоомж буюу аливаа гэрээний дагуу хүлээсэн үүргүүдийг ажилтнуудад тайлбарлаж өгөх;
- Хянан нийцүүлэлттэй холбоотой эрсдлийг тогтоох, үнэлгээ өгөх, удирдах, энэ талаар бусад захирлуудтай хамтран ажиллах;
- Хянан нийцүүлэлттэй холбоотой эрсдэл бий болсон буюу бий болж болзошгүй нөхцөл тус бүрт Хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэнд даруй мэдэгдэх;
- Хянан нийцүүлэлтийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүү, хүний нөөцийг хуваарилах;
- Хянан нийцүүлэлтийн үүргүүдийн биелэлтийг тууштай хянаж ажиллах;
- Хянан нийцүүлэлттэй холбоотой үүргүүдийг ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод тусгаж, гүйцэтгэлийн үнэлгээг тооцоход харгалзан үзэж байх.

4.3.2. Ажилтнуудын оролцоо , Хамгаалалтын хоёрдугаар бүс (Комплаенсын асуудал хариуцсан мэргэжилтэн)

- 4.3.2.1 Хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн өөрийн эрхлэх асуудлын чиглэлээр хянан нийцүүлэлтийн эрсдэлийн удирдлагыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.
- 4.3.2.2 Хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь Гүйцэтгэх удирдлагын хорооны гишүүдэд ажлаа тайлагнана.

- 4.3.2.3 Хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь ноцтой гэж үзсэн асуудлын талаар шууд удирдлагадаа шуурхай мэдэгдэж, бусад мэдээ, баримтын талаар тайлагнаж, тухай бүр нь мэдээллээр хангана.
- 4.3.2.4 Хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтны ирүүлсэн мэдээ, баримтад шууд уирдлага нь арга хэмжээ аваагүй тохиолдолд Хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь Гүйцэтгэх захирал, эсхүл Эрсдлийн удирдлагын хороонд танилцуулж, мэдээлэх эрхтэй.
- 4.3.2.5 Хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь шаардлагатай тохиолдолд хянан нийцүүлэлтийн чиглэлээр гарсан ноцтой зөрчил, гарч болзошгүй нөхцөл, ноцтой зөрчилтэй холбоотой авсан арга хэмжээ, гаргасан гомдлын талаар Төлөөлөн удирдах зөвлөлд шууд хандах эрхтэй.
- 4.3.2.6 Байгууллагын Хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь хянан нийцүүлэлтийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах эрхийг эдлэнэ.
- Байгууллагын нэгжид ажиллахдаа дотоод аудиторын адил эрх хэмжээг эдлэх;
 - Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах төсөв, програм хангамж, бусад нөөцөөр хангагдсан байх;
 - Мэргэжлийн ур чадвараа тогтмол, шаталсан сургалт, дадлагажуулах хөтөлбөрөөр дээшлүүлэх;
 - Хянан нийцүүлэлтийн ноцтой зөрчил гарсан тохиолдол бүрийг шалгаж, холбогдох нэгжийн ажилтнаас тусламж, дэмжлэг авах, шаардлагатай гэж үзвэл гадны шинжээчийг татан оролцуулах;
 - Комплаенсын зөрчил, гомдолтой холбоотой аливаа эрх зүйн акт, санхүүгийн тайлан, харилцагчийн мэдээлэл, бусад баримт бичигтэй танилцах;
 - Эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр байгууллагын нууцад хамаарах баримт бичигтэй танилцах;
 - Комплаенсын эрсдэл байж болзошгүй нэгж, үйл ажиллагаанд өөрийн санаачилгаар тандалт, шалгалтыг баталсан удирдамжийн дагуу хэсэгчилсэн байдлаар түүвэрчлэх, аргыг ашиглан хийх;
- 4.3.2.7 Байгууллагын комплаенсын асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь хянан нийцүүлэлтийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах үүргийг хүлээнэ. Үүнд;
- Байгууллагын удирдлага болон бусад ажилтанд хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгч, удирдлагыг хянан нийцүүлэлтийн зөрчил болон холбогдох мэдээллээр хангах;
 - Багууллагын хэмжээнд мөрдөх, эрсдэлд суурилсан хянан нийцүүлэлтийн хөтөлбөрийг Гүйцэтгэх захирлаар батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах;
 - Сэдэвчилсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хууль журмын хэрэгжилтийг хангах талаар заавар, зөвлөмж бэлтгэх, ажилтны ёс зүйтэй байдал, ажлын зохистой дадлын талаар санамж, удирдамж түгээх ажлыг хариуцах;
 - Комплаенсын эрсдэлийг оновчтой тодорхойлох, хэмжих, үнэлэх, ажиллагаанд удирдлагад дэмжлэг үзүүлэх;

- e. Ажил үүргээ хараат бус байдлаар хэрэгжүүлэхийн тулд бизнес эсхүл үйл ажиллагааны нэгжийн үүргийг хэрэгжүүлэхгүй;
- f. Ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсгэж болзошгүй үйл ажиллагаанд оролцохгүй байх;

4.3.3. Хамгаалалтын гуравдугаар бүс (Аудитор)

4.3.3.1 Даатгалын байгууллагын аудитор нь дараах үүрэг хүлээнэ:

4.3.3.2 Энэхүү журмын дагуу комплаенсын эрсдэлийн удирдлагын хэрэгжилт түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, харилцагчийг таньж мэдэх үүрэгтэй холбоотой эрсдэлийн төлөвийг тодорхойлох үнэлгээг жилд нэгээс доошгүй удаа хийх;

4.3.3.3 Даатгалын комплаенсын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг шалгах;

4.3.3.4 Комплаенсын удирдлагын хэрэгжилтын талаар байгууллагын ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын хороонд тайлагнах, зөвлөмж гаргах;

4.3.3.5 Комплаенсын асуудал хариуцсан мэргэжилтний ажил үүрэгт тогтмол хугацаанд шалгалт хийх;

5. Сургалт

6. **Даатгалын салбарын комплаенсын онцлог, нийтлэг зарчмууд:**

6.1 Анхаарах талбарууд:

- Эрх бүхий байгууллагаас батасан зохицуулалтын журам;
- AML (МУТСТ);
- Авилга хээл хахуулийн эсрэг хууль тогтоомж;
- Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал;
- Нөхөн төлбөрийн менежмент;
- Даатгалын залилан;
- Сонирхлын зөрчил;
- Гэрээний ил тод байдал;

6.2 6.1 Комплаенсын дүрэм журмуудыг хэрэгжүүлэхэд:

- Биелүүлэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, дотоод дүрэм, журмуудыг сахих;
- Хамтран ажиллаж байгаа нийлүүлэгч байгууллага, хувь хүнийг сонгон шалгаруулах шаардлага, хамрах хүрээг тодорхой болгох;
- Ёс зүйн дүрмийг сахих;
- Идэвхжүүлэлт сурталчилгаа хийх;
- Чанарын сертификатжуулах;
- Мэргэжлийн ёс зүйг сахих;
- Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- Харицагчаа таньж мэдэх, эрх ашгийг хамгаалах;
- Мэдээллийн аюулгүй байдал, түүний нууцлалыг хамгаалах;
- Багууллагын хөрөнгийг хамгаалах
- Авилга, хээл хахуулиас ангид байх

- Зөрчлийг мэдээлэх

7. Эрсдэлийн үнэлгээ

7.1 Комплаенсын эрсдэлийг илрүүлэх, үнэлгээ хийх аргачлал, давтамж

- Хянан нийцүүлэлийн ноцтой эрсдэл гарсан тохиолдолд энэ тухай хянан нийцүүлэлт асуудал эрхэлсэн мэргэжилтэнд даруй мэдэгдэнэ.
- Хянан нийцүүлэлт асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь , дараах зүйлийг Гүйцэтгэх захиралд даруй мэдэгдэнэ:
 - Хянан нийцүүлэлийн чиглэлээр гарсан ноцтой зөрчил;
 - Хянан нийцүүлэлийн чиглэлээр гарч болзошгүй зөрчил;
 - Ноцтой зөрчил гарсаны улмаас хууль тогтоомжийн дагуу авагдсан арга хэмжээ, гаргасан гомдлын талаар
 - Байгууллагын бүх захирлууд өөрийн эрхлэх асуудлын чиглэлээр хянан нийцүүлэлтийн удирдлагын хэрэгжилтийн талаар тайланг жилд нэг удаа өөрийн ажиллаж буй байгууллагын хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн, Гүйцэтгэх захиралд тус тус хүргүүлнэ. Тайланд дараах зүйлийг тусгасан байна:
 - Хянан нийцүүлэлтийн үүргийг хангах зорилгоор хариуцаж буй ажлын бүх чиглэлээр хийсэн эрсдэлийн үнэлгээ;
 - Хянан нийцүүлэлтийн эрсдэлийг үр дүнтэй удирдах зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээ;
 - Тайлангийн хугацаанд хариуцсан ажлын чиглэлээр хянан нийцүүлэлтийн үүргийг зөрчил гарсан эсэх талаар дүгнэлт, зөрчил гарсан бол зөрчлийн зөрчлийн талаарх мэдээлэл, түүний шалтгааныг тусгах.
 - Хянан нийцүүлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь тайлангуудыг нэгтгэж, тухайн жилийн Гүйцэтгэх удирдлагын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

8. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа

Даатгалын байгууллага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс зайлсхийж ажиллана. Дээрх хариуцлага нь харилцагчаа тодорхойлох, харилцагчийн үйлдлийг хянах, сэжиг бүхий эсхүл харилцагчийн сэжигтэй гүйлгээг хууль, дүрмийн дагуу мэдүүлэх зэрэг юм.

- МУТСТ бодлого, дотоод дүрэм журам
 - МУТСТ дотоод хяналтын хөтөлбөр боловсруулах
 - Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах
 - Удирдлагын оролцоо
 - Удирдлагад МУТСТ ажлыг танилцуулах, тайлагнах
- МУТСТ эрсдэлийн удирдлага
 - МУТСТ эрсдэлийн үнэлгээг боловсруулах
 - МУТСТ эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нь
- Харилцагчийг таньж мэдэх
 - Эцсийн өмчлөгчийг тодорхойлох
 - Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа
 - Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа

- Өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэхнарийвчилсан үйл ажиллагаа
- Тусгай хяналт
- НҮБ-ын Аюулгүй зөвлөл болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх нь
- Гүйлгээний талаар мэдээлэх нь
 - Бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны тухай мэдээлэх
 - Сэжигтэй үйлдлийг тодорхойлох
 - Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэх
 - Сэжигтэй гүйлгээний маягтыг бөглөх
 - Ажилтнуудаас сэжигтэй гүйлгээний мэдээлэл хүлээн авах
 - Гүйлгээний мэдээлэлд шинжилгээ хийж, шийдвэр гаргах
 - СМА-нд гүйлгээний мэдээллийг хүргүүлэх
- Баримт материалыг хадгалах, Мэдээллийн нууцлалыг хадгалах
 - Даатгуулагчийн болон бусдын хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүйгээр нэвтрэхгүй байх.
 - Мэдээллийг бусдад санамсаргүй болон санаатай байдлаар шилжүүлэхгүй байх.
 - Олон нийтийн дунд хүмүүс сонсож болзошгүй байхад нууц мэдээллийг чангаар, нээлттэй ярихаас зайлсхийх.
 - Хөрөнгө эзэмшлийн талаар гуравдагч этгээдтэй зөвшөөрөлгүйгээр, нууц хадгалах гэрээ байгуулаагүйгээр ярихаас зайлсхийх.
 - Хөрөнгө эзэмшлийн талаар даатгуулагч, бизнесийн түнштэй зохих ёсны зөвшөөрөл авалгүйгээр, нууц эсвэл нууц биш гэсэн харилцаатай эсэх талаар мэдэхгүйгээр ярихаас зайлсхийх.
 - Нууц баримт бичгийг зүй бусаар хаях, үрэгдүүлэхээс зайлсхийх.

9. Мэргэжлийн ёс зүй

Даатгалын байгууллагууд нь өөрсдийн даатгуулагчдад болон өөрсдөдөө шинэ боломжийг бүтээхийн төлөө өрсөлдөх ба зөвхөн хууль ёсны дагуу, ёс зүйтэй бизнес үйл ажиллагаагаар дамжуулан өрсөлдөөнд давуу тал олж авахыг эрхэмлэнэ.

- Зохицуулагч байгууллагатай харилцах
- Хөрөнгө оруулагчтай харилцах
- Ажилтан хоорондын харилцаа
- Харилцагчийн эрх ашгийн хамгаалах
- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх
- Үргэлж гишүүн байгууллага болон даатгуулагчдын ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэр гаргана – хувийн ашиг сонирхлоо дагахгүй.
- Даатгуулагч, төлөөлөгч эсхүл өрсөлдөгчдөд хөрөнгө оруулалт хийх эсхүл эдгээрт давхар ажил хийх гэх мэтчилэн хувь хүний үйлдэл хэрхэн ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй вэ гэдгийг байнга санаж ажиллах.
- Ажилтан нь удирдах албан тушаалтантайгаа ашиг сонирхлын зөрчил гэж үзэж болох нөхцөл байдлын талаар ярилцах.

- Ажилтан өөрөө болон гэр бүлийн гишүүн эсхүл танил, найз нөхдийн ашиг сонирхол гишүүн байгууллагын ашиг сонирхлын зөрчилд орж болзошгүй нөхцөл байдлыг өөрийн санаачилгаар мэдэгдэх.
- Харилцагчдаас бэлэг сэлт, урилга хүлээн авах
- Ажлын шийдвэрт буруугаар нөлөөлөх ажилтай холбоотой бэлэг, үзвэр үйлчилгээ хэзээ ч авахыг хориглоно.
- Авилгад тооцогдох зүйл, бусад зүй бус төлбөр, бэлэг өгөх, авахыг хориглоно. Төрийн албан хаагчдад бэлэг өгч эсвэл авахдаа “Авилгын эсрэг хууль”-ийг дагаж мөрдөх.
- Шударга өрсөлдөөнийг хангах
- Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал

Даатгуулагчдын бизнесийн болон хувийн мэдээлэлтэй хянамгай харьцаж, хамгаалах, хууль ёсны дагуу бусад этгээдэд даатгуулагчийн хувийн мэдээллийг задруулахыг хориглоно.

Дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ

- “Шүгэл үлээх”/whistleblowing
- Нийгмийн хариуцлага

6. Аутсорсинг

Хавсралт

Хууль тогтоомж

Эрсдэлийн үнэлгээний аргачлал

Комплаенсын түвшинг хэмжих checklist

Эх сурвалж, ашигласан материал;

1. IAIS- International Association of Insurance Supervisors “Insurance Core Principles” page 344-354
2. CENTER for REGULATORY STRATEGY Americas “Insurance regulatory outlook-2018”
3. Даатгалын холбооны жинхэнэ гишүүн байгууллагуудын хуульчдын боловсруулсан “ХЯНАН НИЙЦҮҮЛЭЛТ (COMPLIANCE)-ИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ”
4. Даатгалын Холбооны Удирдах Зөвлөлийн баталсан “Ёс зүйн кодекс-2018”

2.3. Банк бус санхүүгийн байгууллагууд

1. КОМПЛАЕНСЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ТҮҮНИЙ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ

Банк бус санхүүгийн байгууллагууд нь орлого багатай, харьцангуй эрсдэл өндөртэй, гэнэтийн санхүүгийн хэрэгцээ хангах шаардлага гарсан зэх зээлийн сегментэд хүрч үйлчилдэг. Банк бус санхүүгийн салбар нь 4,766 хувь нийлүүлэгчийн 540 банк бус санхүүгийн байгууллага, 206 салбар салбар нэгж, 5 төлөөлөгчийн газар, 2,652 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,510,982 харилцагчид 1,201,975.5 төгрөгийн хөрөнгөтэйгээр үйлчилж байна. Эдгээр 540 ББСБ-уудын дотор валют арилжаа, цахим мөнгөн гуйвуулга, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч, финтекийн шийдлүүд ашиглан зээл гаргаж байга гэх үйл ажиллагааны олон чиглэлүүд багтсан.

Банк бус санхүүгийн байгууллагууд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль гэх мэт хууль тогтоомж мөн салбарын холбогдох журам, зааврыг мөрдөн ажиллаж байна.

ББСБ-ын хувьд комплаенсын чиглэлээр хийгдэж байгаа ажлууд нэгэн жигд биш байгаа бөгөөд СЗХ-оос МУТСТ хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор зохион байгуулсан сургалтанд хамруулснаар мэдлэг сайжирч байгууллагын дотоод журмууд боловсруулагдан хэрэгжиж эхэлснээр харилцагчийг танин мэдэх үйл ажиллагааны тайлагнал нэмэгдсэн байгаа.

ББСБ-уудын комплаенсийн бодлогын хүрээ нь дан ганц хууль, эрх зүйн харилцаагаар хязгаарлагдахгүй бөгөөд шударга байдал, ёс зүйн өргөн ухагдахууныг хамарна. Тухайлбал, ажлын байранд ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг дагаж мөрдөх, салбарын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх зэрэг нь хамаарах бөгөөд харилцагчдад тэгш шударгаар хандах, тэдний эрх ашгийг хамгаалах явдал нь комплаенсийн соёлыг төлөвшүүлэх бодлогын чухал хэсэг болно.

2. SMART CAMPAIGN БУЮУ ХАРИЛЦАГЧДЫН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Олон улсын Зохицуулах Хорооноос санаачлан хэрэгжүүлж буй **Smart campaign** буюу Харилцагчыг эрх ашгийг хамгаалах ухаалаг хөдөлгөөнд одоогийн байдлаар дэлхийн 130 орны 2250 бичил санхүүгийн байгууллагууд нэгдээд байна.

Харилцагчдын эрх ашгийг хамгаалах Олон улсын хөдөлгөөнд гишүүнээр элсэн орж, тус хөдөлгөөнөөс дэвшүүлэн хэрэгжүүлж буй 7 зарчмыг байгууллагын бүхий л үйл ажиллагаанд хэрэгжүүлэн, хэвшүүлж ажилласан байгууллагууд харилцагчидтайгаа урт удаан хугацааны итгэлцэл дээр суурилсан харилцаа тогтоохоос гадна давтан зээл авах магадлалыг нэмэгдүүлж санхүүгийн эрсдлийг бууруулдаг.

ХАРИЛЦАГЧЫГ ХАМГААЛАХ ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

1. Бүтээгдэхүүн ба үйлчилгээ харилцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх,
2. Харилцагчдыг өрийн хэт их дарамтанд оруулахаас урьдчилан сэргийлж, зээлийн хэмжээг тэдний төлбөрийн чадвартай уялдуулан зөв тооцоолдог байх,
3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ханш ил тод байх,
4. Ил тод байдал
5. Хүүгээ хариуцлагатайгаар тогтоох
6. Харилцагчдын мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах,
7. Тэдний санал гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэдэг дотоод журам, механизмтай байх.

МББСБ-ийн холбооноос санаачлан энэхүү дэлхий нийтээр томоохон бичил санхүүгийн байгууллагуудын санаачлан хэрэгжүүлж буй хөдөлгөөнд нэгдэхийг уриалан, эдгээр зарчмуудыг шинээр үйл ажиллагаагаа эхлүүлж буй ББСБ-уудад таниулах үйл ажиллагаа өрнүүлж ирсэн. Одоогоор 67 ББСБ хөдөлгөөнд нэгдснийг мэдэгдэж санамж бичиг дээр гарын үсэг зурсан байна.

3. **БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

Бизнесийн байгууллагын хувьд тэр дундаа санхүүгийн байгууллагын хувьд үйл ажиллагаагаа амжилттай явуулах, ашигтай ажиллах, харилцагч, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүй байх, нэр хүнддээ сэв суулгахгүй байх нь нэн чухал билээ. Хорооноос буюу зохицуулагч байгуулагаас санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий ажлууд хийгддэг. Байгууллага тус бүр ёс зүйн дүрэм, комплаенсын болон МУТСТ чиглэлийн бодлогын баримт бичиг боловсруулж ажиллаж байгаа ба банк бус санхүүгийн

байгууллагууд нийтээр мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээ, нэгдсэн стандартыг тогтоож өгөх нь салбарын нэр хүнд, харилцагчдын салбарт итгэх итгэл, засаглал, үйл ажиллагааны чанартай, түргэн шуурхай, ил тод байдалд шууд нөлөөлнө.

Монголын банкуудын хувьд ёс зүйн дүрэм банкуудын үйлчилгээ, сайн банкны харилцааг харилцагчдад хүргэхэд чиглэсэн. Харин МББСБХ-ноос баталсан ёс зүйн дүрэм нь МББСБХ-нд элссэн гишүүдийн ёс зүйн дүрэм учир зах зээлд чиглэхээсээ илүү Холбооны гишүүн байх, Холбооны нийтлэг ашиг сонирхлыг дээгүүр тавих, Холбооны үйл ажиллагааны талаар нийтэд буруу ташаа мэдээлэл түгээхгүй байх, ёс зүйтэй Холбооны гишүүн байхад чиглэсэн. МББСБХ-нд гишүүнээр элсээгүй банк бус санхүүгийн байгууллагуудад уг дүрэм хамаарахгүй байна. Салбарын хэмжээнд тодорхой стандарт, хэм хэмжээ тогтоож өгсөн ёс зүйн дүрэмтэй байх нь дараах ач холбогдлуудтай:

- ❖ Салбарын хэмжээнд баримтлах үнэт зүйлс, зарчмуудыг тодорхой болгоно
- ❖ Байгууллагын төдийгүй салбарын нэр хүндэд эерэг нөлөө үзүүлнэ
- ❖ Харилцагчид, хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийг нэмэгдүүлнэ
- ❖ Ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ
- ❖ Нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ
- ❖ Мэргэжлийн байгууллагын стандартыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулна
- ❖ Эрсдэлийн хэмжээг буурах боломжтой г.м.

Иймд банк бус санхүүгийн байгууллагууд нийтээр мөрдвөл зохих ёс зүйн кодекс/дүрэм нэн шаардлагатай байна.

Уг ёс зүйн дүрмийг бүх банкнаас бусад санхүүгийн салбарыг төлөөлөгчид мөрдөхөөр заасан байх ба гол зорилго нь харилцагч, хувьцаа эзэмшигч болон ажилтнуудын ашиг сонирхлыг хамгаалах, санхүүгийн байгууллагуудын хоорондын харилцааг зохицуулахад дэмжлэг болох явдал юм. Үүнд:

- Зах зээлд оролцогчид, тэдгээрт тавих наад захын шаардлагууд /багаар ажиллах, хүлцэнгүй даруу байх, бусдыг хүндлэх, мэдлэг чадвараа нэмэгдүүлэх/
- Хариуцлага /хөрөнгө оруулагч, харилцагч, нийгмийн хариуцлага, байгаль орчинд нөлөөлөх,
- Банк, банкнаас бусад санхүүгийн байгууллагын өмч болон мэдээлэл /байгууллагын өмчийг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдал, үл үзэгдэх хөрөнгө, бусдын оюуны өмчид халдахгүй байх, харилцагчийн мэдээллийг хамгаалах, төрийн байгууллагад мэдээлэл гаргаж өгөх, ажилтнуудын мэдээллийг хамгаалах/
- Ашиг сонирхлын зөрчил
- Өөр бусад ажил эрхлэх

- Хувиараа хөдөлмөр эрхлэх
- Гаднаас дарамт үзүүлэх /Парламентын гишүүн, улс төрч, ТУЗ-ийн гишүүн г.м. гадаас аливаа дарамт үзүүлэх, нөлөөлөх/
- Бэлэг сэлт, гадаал улс орны шагнал урамшуулал авах
- МУТСТ үйл ажиллагаа
- Тайлан мэдээ, мэдээллийн үнэн зөв байдал
- Залилал, хулгай, хууль бус үйл ажиллагаа
- Ажиллах орчин /эрүүл мэнд, аюулгүй байдал, ажлын байрны орчин/
- Багийн ажил
- Diversity буюу солонгоруулалт
- Ажилтнуудын гомдол
- Хууль, дүрэм, журмыг сахин мөрдөх
- Ажилд орох ижил, тэгш эрх
- Ажлын байран дээрх дахь дарамт шахалт
- Ажиллах орчинд балмад авирыг үл тэвчих нь
- Удирдлагуудын онцгой хариуцлага /Ажилтнуудад тохирсон ажлыг хариуцуулах, дүрэм журмыг ойлгомжтой боловсруулах, байнгын хяналт тавих, ажилтнуудад мэдээлэх үүрэг/
- Харилцагчдад эрх тэгш үйлчлэх
- Харилцагчдын, хувьцаа эзэмшигчдийн мэдээллийн аюулгүй байдал
- Тайлан мэдээний ил тод байдал
- Олон нийтийн сүлжээгээр харилцах харилцаа
- Дүрэм, журам зөрчигдсөнийг мэдэгдэх бодлого
- Сургалт зохион байгуулах
- Технологийн дэвшлийг ашиглах
- Ажлын байрнаас гаднах ажилтны ёс зүй
- Дресс код буюу хувцаслах дүрэм
- Ажлаас гарсны дараа /хариуцлага/
- Ёс зүйн хорооны үүрэг хариуцлага
- Шагнал, урамшуулал
- Сахилгын арга хэмжээ /сахилгын арга хэмжээг үнэн зөв тодорхойлох/
- Уг дүрмийг сахих
- Дүрэмд өөрчлөлт оруулах /Төв банк өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй/

Үүнээс гадна санхүүгийн байгууллагууд тус бүртээ ёс зүйн дүрэм боловсруулж, мөрдөж ажиллахыг СЗХ-оос шаарддаг байх ёстой бөгөөд МББСБХ-с сургалтаар дамжуулан мэдээлэл түгээх үүрэг хүлээнэ.

2.4. Хадгаламж зээлийн хоршоод /Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбооны санал/

ЁС ЗҮЙН ДҮРЭМ/СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

2002 оны 12 дугаар сарын 6-ны өдөр

Хадгаламж, зээлийн хоршооны ажилтан, албан хаагчид нь аливаа үйлдлээрээ ямарваа хууль, дүрэм, журмыг зөрчихгүй байх явдлыг хангах үүрэг хүлээдэг. Тэд хүлээсэн үүргээ хариуцлагатай, найдвартай биелүүлэх үүрэгтэй, ХЗХ-ны итгэмжлэгдсэн хүмүүс юм.

Нэгэнт ХЗХ-ны ажилтан, албан хаагч болсон бол тухайн этгээд ХЗХ болон түүний гишүүдийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавих ёстой бөгөөд албан тушаалаа ашиг олох, эсвэл ямарваа нэр давуу тал олж авахад ашиглах эрхгүй.

ХЗХ-ны хуулиар тэргүүлэгчдийн зөвлөл нь хоршооны үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих ба хоршооны үйл ажиллагааны бодлого, дүрэм, журмыг боловсруулан батлах үүрэгтэй. Мэргэжлийн ёс зүйн дүрэм нь хоршооны ажилтан, албан хаагчдад зориулсан, сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, түүнээс зайлсхийхэд чиглэсэн зөвлөмж юм. Уг дүрмийн гол зорилго нь хоршооны имидж, бүрэн бүтэн байдлыг хамгаалах, түүнчлэн хоршооны ажилтан, албан хаагчдыг үүргээ биелүүлж байхдаа хувийн эрх ашгийг илүүд үзсэн аливаа үйлдэл хийхээс сэргийлэхэд оршино.

Хоршооны бүх ажилтан, албан хаагчид нь анх ажилд ороходоо мэргэжлийн ёс зүйн дүрмийг сайтар уншиж, танилцан, мэдэгдэлд жил бүр гарын үсэг зурж, хүлээн зөвшөөрснөө баталгаажуулсан байх ёстой. Мэдэгдэл нь тухайн ажилтныг ажилд авахад, түүнчлэн уг ажилтан хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь сонирхлын зөрчил үүсэх эсэхийг тодруулсан мэдээллүүдийг агуулсан байх бөгөөд мэдэгдэлд гарын үсэг зурснаар “би үүнийг сайн ойлгоогүй, мэдээгүй” гэх үндэслэлээр зөрчил гаргаж, хариуцлагаас мултрах аргагүй болно.

Мэргэжлийн ёс зүйн дүрэм болон мэдэгдэлд дараах мэдээллүүдийг багтаасан байна.

Ёс зүйн дүрэм – тухайн ажилтны оролцохгүй байвал зохих, хоршооноос хориглосон үйл ажиллагаа, үүрэг, хариуцлагын талаар тодорхой зааж өгнө. Үүнд:

- ✓ Хоршооны үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу, ёс зүйн дүрэмд нийцүүлэн явуулах;
- ✓ Хоршооны мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
- ✓ Сонирхлын зөрчил үүсгэхгүй байх, тэдгээрээс зайлсхийх;
- ✓ Хоршооны эд хөрөнгийг хамгаалах (тухайлбал, мэдээлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ гэх мэт);
- ✓ Хүлээсэн үүргээсээ үл хамааран хувийн санхүүгийн асуудлаа зохих ёсоор шийдвэрлэх, цэгцлэх;
- ✓ Хоршооны бүх ажилтан, албан хаагч, гишүүд болон тэдгээрийн харилцаж буй бүх хүмүүстэй хүндэтгэлтэй, шударга харилцах.

Зорилго, зорилт – Ёс зүйн зорилгыг маш ойлгомжтой тодорхойлох ёстой бөгөөд дүрэм нь хоршооны ажилтнуудын баримталбал зохих хэм хэмжээг зааж өгдөг. Түүнчлэн хоршооны үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу явуулахад чиглэсэн удирдамжийг өгдөг.

Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа – Хоршооноос баталж буй бүх дүрэмд зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа болон харилцааг тодорхой зааж өгөх нь зүйтэй. Хоршооны аливаа үйлчилгээг үзүүлснийхээ хариуд мөнгө болон бусад үнэ бүхий зүйл авах (шууд болон шууд бус байдлаар төлбөр төлөх болон эд хөрөнгө худалдан авахад хөнгөлөлт авах зэргийг оролцуулаад)-ыг хориглоно. Харин дор дурдсаныг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- ✓ Хэвийн үйл ажиллагааны үед цалингийн нэмэгдэл болон бусад төрлийн урамшуулал авах;
- ✓ Хоршоонд ажилладаг эсэхээс хамааралгүй гэдэг нь илэрхий байгаа гэр бүлийн болон хувийн харилцаа (хоршооны аливаа ажилтны эцэг, эх, хүүхэд, эхнэр, нөхөр гэх мэт)-нд үндэслэн бэлэг авах;
- ✓ Аливаа хурал болон бусад арга хэмжээний үеэр зоог барих, үдэшлэгт оролцох (хүн тус бүрийн зардал “.....” дүнгээс хэтрэхгүй байх ба зардлыг хоршооны үйл ажиллагааны зардалд тооцно);
- ✓ Хуулиар хориглоогүй бол хувийн хэрэгцээгээ хангах зорилгоор банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл авах;
- ✓ Үнэ төлбөргүй, сайн дураар өгсөн сурталчилгааны материал авах (зүйл болон хүн тус бүрээс “.....” -ээс хэтрэхгүй хэмжээгээр авна);
- ✓ Аливаа худалдан авалт болон үйлчилгээнээс хөнгөлөлт авах (уг хөнгөлөлт нь бусад хоршоод болон олон нийтэд үзүүлж буй хөнгөлөлтөөс илүүгүй байна);
- ✓ Албан тушаал дэвших, тэтгэвэрт гарах зэрэг шалтгаанаар үнэ бүхий зүйл, бэлэг авах (зүйл болон хүн тус бүрээс “....” -ээс хэтрэхгүй хэмжээгээр авна);
- ✓ Үйлчилгээ үзүүлснийхээ төлөө иргэний, буяны, боловсролын болон шашны байгууллагын нэрэмжит шагнал авах;
- ✓ Тэргүүлэгчдийн зөвлөлөөс бичгээр урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр энд дурдаагүй боловч тухайн тохиолдолд хүлээн зөвшөөрч болохуйц бусад үйл ажиллагаа, үйлдэл.

Хориглосон үйл ажиллагаа – Хоршооны үйл ажиллагаатай холбогдуулан ямарваа нэг зүйл амлах, санал болгох эсвэл үнэ бүхий зүйл авахыг хоршооны ажилтанд хатуу хориглоно. Тухайн улсын хууль тогтоомжийн онцлогоос хамаарч ямар үйл ажиллагааг хориглох уу, ямар үйл ажиллагааг нь зөвшөөрөх үү гэдгээрээ ялгаатай байдаг. Дор дурдагдаагүй боловч хориглох нь зүйтэй зүйлүүдийг ёс зүйн дүрэмд тусгана. Дор дурдсан үйл ажиллагаанууд нь хориглосон үйл ажиллагаанд хамаарна. Үүнд:

- ✓ Хоршооны тэргүүлэгчдийн зөвлөлийн аливаа гишүүн, албан тушаалтан, ажилтан, албан хаагч нь хоршооны үйл ажиллагаатай холбогдуулан бэлэг, шагнал, урамшуулал, аялалын болон бусад зардал, аливаа төрлийн үнэ бүхий зүйлс хүсэх, авах;
- ✓ Хоршооны гишүүд болон харилцагчаар аялал зугаалга, зугаа цэнгэлтэй холбоотой зардлыг төлүүлэх;
- ✓ Зээл өгснийхөө хариуд урамшуулал, хувь авах;
- ✓ Хувь хөрөнгө оруулах, хадгаламж хийхтэй холбогдуулан мөнгөн шагнал авах;

- ✓ Хоршооны албан тушаалтан, ажилтан, албан хаагч болон тэдгээрийн гэр бүлийн ойрын гишүүдэд давуу нөхцлөөр зээл олгох;
- ✓ Хоршооноос авсан зээлээ хугацаа хожимдуулах;
- ✓ Хоршооны албан тушаалтан, ажилтан, албан хаагч болон тэдгээрийн гэр бүлийн ойрын гишүүд нь хоршооны аливаа гишүүнээс шууд болон шууд бус байдлаар өв хөрөнгө хүлээн авах (хэрэв тухайн гишүүний гэрээслэлд өв хөрөнгөө тийнхүү өвлүүлэхээр заасан бол тухайн ажилтан нь энэ тухай хоршооны хяналтын зөвлөл болон тэргүүлэгчдийн зөвлөлд нэн даруй мэдэгдэх бөгөөд ойр төрлийн хүнээс нь өвлүүлэхээр шийдвэрлээгүй бол тухайн ажилтан өвийг хүлээн авах эрхгүй байна);
- ✓ Хоршооны аливаа гишүүний талаарх нууц мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, бусдад зөвшөөрөлгүй задруулах.

Ёс зүйн дүрмийн мэдэгдэл – Хоршооны бүх албан тушаалтан, ажилтан, албан хаагчид нь анх ажилд орохдоо ёс зүйн дүрмийг сайтар уншиж, танилцан, мэдэгдэлд гарын үсгээ зурж, хүлээн зөвшөөрснөө баталгаажуулах ба жил тутмын бүх гишүүдийн хурлаас өмнө хуралдах хоршооны ажилчдын ээлжит хурлаар, эсвэл хоршооны ажилчдын ажлыг үнэлэх жил тутмын ээлжит арга хэмжээний үеэр уг мэдэгдлийг шинэчлэн баталж, мөн адил гарын үсгээ зурж, хүлээн зөвшөөрснөө баталгаажуулна.

Ёс зүйн дүрмийн загварыг хавсаргав.

ЁС ЗҮЙН ДҮРМИЙН МЭДЭГДЭЛ

Миний бие ёс зүйн дүрмийн мэдэгдлийг хүлээн авч, уншиж танилцаад дор дурдсаныг үүгээр мэдэгдэн баталж байна. Үүнд:

Миний бие дор дурдсанаас өөр бусад санхүүгийн байгууллагад ямарваа албан тушаалтан эсвэл ажилтнаар ажилладаггүй болно.

Байгууллагын нэр, хаяг	Албан тушаал	Эзэмшлийн хувь	Сүүлийн 12 сарын хугацаанд олсон орлого

Миний бие дор дурдсанаас өөр бусад ажил хөдөлмөр эрхэлдэггүй болно.

Ажил олгогч, үйл ажиллагаа	Албан тушаал	Ажлын цаг	Цалин

Миний бие ёс зүйн дүрэмд заасан хориглосон болон сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй үйл ажиллагаанд оролцож байгаагүй болно.

Дээрх мэдээлэл үнэн зөв болохыг миний бие үүгээр мэдэгдэн баталж байна.

Огноо:

Гарын үсэг:

Албан тушаал:

2.5. Үл хөдлөх хөрөнгө зуучлагчид /Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбооны санал/

МОНГОЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН НЭГДСЭН ХОЛБОО /МҮХХЗНХолбоо/-НЫ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГЫН РЕАЛТОРЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. МҮХХЗНХолбооны гишүүн байгууллагын реалторын албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.2. МҮХХЗНХолбооны гишүүн байгууллага бүр энэхүү Дүрмийг дагаж мөрдүүлэн байнгын хяналт, хариуцлагын тогтолцоог дотооддоо бүрдүүлж ажиллана.

Хоёр. Ёс зүйн зарчим

- 1.1. МҮХХЗНХолбооны гишүүн байгууллагын реалторууд нь үйл ажиллагаандаа дор дурдсан зарчмыг баримтална:
 - Эрх тэгш байх;
 - Гэрээ хэлцэл хуулийн дагуу байх;
 - Шударга байх;
 - Хариуцлага хүлээх.

Гурав. Реалторт тавигдах ерөнхий шаардлага

- 3.1. Реалтор нь зуучлагч байгууллагад харъяалагддаг байх;
- 3.2. Реалтор нь МҮХХЗНХолбооны сургалтад сууж гэрчилгээ авч, реалторын дугаар авсан байх;
- 3.3. МҮХХЗНХолбооны лого, байгууллагын лого бүхий үнэмлэхтэй байх;
- 3.4. Реалтор нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадвар, дадлага туршлагаа байнга хөгжүүлж, зэрэглэл дээшлүүлэх шалгалт өгдөг байх;
- 3.5. Реалтор нь албан үүргийн хүрээнд бусад зуучлалын байгууллагын реалторуудын утасны дугааруудыг мэддэг байх;

- 3.6. Реалтор нь байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар МҮХХЗНХолбооноос явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх;
- 3.7. Реалтор нь хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээдэг байх.

Дөрөв. Ёс зүйн дүрэм

/Харилцааны ёс зүй/

- 4.1. Үйлчлүүлэгчтэй харилцах ёс зүй. Реалтор нь байгууллагын зорилт, чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлж, байгууллагын үйлчилгээг үзүүлэхдээ дор дурдсан заалтуудыг дагаж мөрдөнө.
 - 4.1.1. Албан үүргээ хэрэгжүүлэхдээ үйлчлүүлэгч, бусад байгууллагын реалторуудад өөрийгөө танилцуулж, эелдэг, адил тэгш, хүлээцтэй, соёлтой, хүндэтгэлтэй харилцаж байгууллагын үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;
 - 4.1.2. Байгууллагын үйлчилгээг хүргэхдээ үйлчлүүлэгчийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;
 - 4.1.3. Нийгэмд болон зуучлуулагч, үйлчлүүлэгчдэд Реалторын ашиг тусыг сурталчлан таниулах.
- 4.2. Реалторууд хоорондын харилцааны ёс зүй. Реалторууд нь байгууллагын зорилт, чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ шударга өрсөлдөж, хамтран ажиллахыг эрмэлзэх бөгөөд дор дурдсан заалтуудыг дагаж мөрдөнө:
 - 4.2.1. Реалтор нь бусад зуучлагч байгууллага болон түүний реалторын үйлчилгээг үйлчлүүлэгч, харилцагч нарт муулах, худал мэдээлэл тарааж нэр хүндэд нь халдахгүй байх;
 - 4.2.2. Албан үүргээ хэрэгжүүлэхдээ бусад зуучлагч байгууллага болон түүний Реалторын нэрийг ашиглахгүй байх;
 - 4.2.3. Реалтор нь бусад зуучлагч байгууллагын реалторын үйл ажиллагаанд саад болох, хууль бус үйлдэл хийх, реалторын ёс зүйн дүрэмд үл нийцэх үйлдэл хийхийг шаардах, дарамт шахалт өгөхийг хориглох;
 - 4.2.4. МҮХХЗНХолбооны Ёс зүйн хороонд үндэслэлгүйгээр бусад Реалторуудын тухай гомдол гаргахгүй байх;
 - 4.2.5. Реалторууд нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ хамтран ажиллаж болох бөгөөд талууд хамтын ажиллагаандаа шударга хандаж, үйлчлүүлэгчийн ерөнхий мэдээллийг солилцдог байх;
 - 4.2.6. Албан үүргээ хэрэгжүүлэхдээ реалтор гэдгээ санаатайгаар нуун бусад зуучлалын байгууллагаас мэдээлэл авахгүй байх;
 - 4.2.7. Реалторууд нь хамтын ажиллагаагаа хэрэгжүүлж Үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийг үзүүлэхдээ үйлчлүүлэгчтэй нэрийн хуудсаа солилцохгүй байх;
 - 4.2.8. Реалторууд нь хамтын ажиллагаагаа хэрэгжүүлж гэрээ хэлцэл хийх бол гэрээнд тэнцүү хувиар оролцоно;

4.2.9. Үйлчлүүлэгч нь нэг Үл хөдлөх эд хөрөнгө /ҮХХ/ дээр 2-оос дээш зуучлалын байгууллагуудаас үйлчилгээ авахаар тохирсон байгаа бол гэрээг түрүүлж байгуулсан реалтор нь гэрээний давуу эрхийг эдэлнэ.

/Албан үүрэг гүйцэтгэх ёс зүй/

4.3. Мэдээлэл, зөвлөгөө өгөх.

4.3.1. Реалтор нь үйлчлүүлэгчид хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах ба бусад хувь хүн байгууллагын судалгаа мэдээллийг ашиглах бол заавал эх үүсвэрийг дурдах;

4.3.2. Реалтор нь зах зээлийн үнийн талаар санаатай худал мэдээлж үйлчлүүлэгч, харилцагчийг төөрөгдүүлэхгүй байх ба ҮХХ-ийг ямар ч судалгаа, харьцуулалтгүйгээр үнэлж болохгүй;

4.3.3. Реалтор нь албан үүргээ хэрэгжүүлэх явцад зуучлалын хөлснөөс бусад төлбөр тооцоонд биечлэн оролцохгүй бөгөөд үйлчлүүлэгчид төлбөр тооцоог баримттай үйлдэхийг сануулдаг байх

4.4. Зураг дарах, олон нийтэд мэдээлэх.

4.4.1. ҮХХ-ийн дотоод байдлын зураг авахдаа цэвэрлэгээ хийж, эмх цэгцтэй байлгахыг зуучлуулагчид мэдэгдэх, мөн үнэ бүхий эд зүйлс, хэн нэг этгээдийн зургийг хамт дарахгүй байх ба гэр бүлийн зураг орсон тохиолдолд янзалж, зассаны эцэст байгууллагын сайт болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд байршуулах;

4.4.2. Авто машины дулаан зогсоол, гаражийн зурганд авто машин орсон бол дугаарыг нь арилгаж зассан байх;

4.4.3. Реалтор нь зуучлуулагчдын ҮХХ-ийн зургийг олон нийтэд мэдээлэх бол байрны дугаар, хаалганы дугаарыг зурагт оруулахгүй байх;

4.4.4. Зуучлалын байгууллага болон түүний реалтор нь бусад зуучлалын байгууллагын сайт дээр байршуулсан зургийг ашиглахгүй байх;

4.5. ҮХХ-ийн зар сурталчилгааг явуулах.

4.5.1. Зуучлалын байгууллага болон түүний реалтор нь зуучлуулагчдын ҮХХ-ийн зарыг олон нийтэд мэдээлэхдээ ойлгомжтой утгын алдаагүй бичсэн байх;

4.5.2. Реалтор нь зуучлуулагчийн ҮХХ-ийн зарыг олон нийтэд мэдээлэх бол байрны дугаар, хаалганы дугаарыг тодорхой бичихгүй байх;

4.5.3. Реалтор нь зуучлуулагчийн ҮХХ-ийн үнэ болон бусад мэдээллийн талаар олон нийтэд буруу ташаа мэдээлэл тараахгүй байх.

4.6. ҮХХ үзүүлэх, танилцуулах

4.6.1. Реалтор нь ҮХХ-ийг үзүүлэх, танилцуулахдаа зуучлуулагч, үйлчлүүлэгчтэй урьдчилан цаг товлодог байх ба товлосон цаг цуцлагдвал зуучлуулагч, үйлчлүүлэгчид заавал мэдэгддэг байх;

4.6.2. ҮХХ-д нэвтрэх эрхийг зуучлуулагчаас Реалторт олгоогүй бол дур мэдэн нэвтрэхгүй байх, баригдаж буй барилга руу нэвтрэх бол хамгаалалтын малгай өмсөж, аюулгүй байдалдаа анхаарах;

4.6.3. Реалтор нь зуучлуулагчийн ҮХХ-ийг үзүүлэхдээ тухайн хөрөнгө, эд зүйлд эвдрэл, гэмтэл учруулахгүй байх ба зөвшөөрөлгүй эд зүйлсийг ашиглах, хэрэглэх, авч гарахгүй байх;

- 4.6.4. Реалтор нь ҮХХ-ийг үйлчлүүлэгчид үзүүлж, танилцуулсны дараа цахилгаан, ус, цонх, хаалга зэргийг сайтар шалгаж гарах
- 4.6.5. Реалтор нь ҮХХ-ийг үйлчлүүлэгчид үзүүлсэн бол тэмдэглэл хөтөлж талуудын гарын үсгийг зуруулдаг байх
- 4.6.6. Реалтор албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах бүдүүлэг зан авир гаргахгүй байх.
- 4.7. Гэрээ хэлцэл хийх
 - 4.7.1. Реалтор нь байгууллагын бодлого, үйлчлүүлэгчийн шийдвэрийг боловсруулах болон үйл ажиллагааны хүрээнд хийгдэх бусад гэрээ хэлцлийг хуулийн дагуу хийх ба зөрүүтэй саналыг талуудад хурдан мэдэгдэж байх;
 - 4.7.2. Реалтор нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа дур мэдэн зуучлалын хөлсийг бууруулах, нэмэгдүүлэхгүй байх;
 - 4.7.3. Реалтор нь ҮХХ-ийн түрээс, хөлслөх гэрээ байгуулах бол талуудын бичиг баримтыг шалгаж, гэрээнд хавсаргах;
 - 4.7.4. Реалтор нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулахыг хориглоно;
 - 4.7.5. Реалтор нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ гэрээний заалт бүртэй танилцахыг зуучлуулагч, үйлчлүүлэгчид сануулж, гэрээтэй дутуу танилцсанаас үүсэх маргаанаас урьдчилан сэргийлэх;
 - 4.7.6. Реалтор нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ зуучлуулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг төлөөлж, дэмжиж, хамгаалдаг байх ба:
 - 4.7.6.1. ҮХХ-ийн аливаа доголдлын талаар талуудад үнэн зөв мэдээлэх;
 - 4.7.6.2. ҮХХ-ийг дорд үзэх, үл тоомсорлох, муу хэлэхгүй байх;
 - 4.7.6.3. Зуучлуулагч болон үйлчлүүлэгчийн аль нэг талын эрх ашгийг дангаар хамгаалахгүй байх;
 - 4.7.7. Гэрээ, хэлцэлтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг эвээр зохицуулахыг эрмэлзэх ба ямар нэг шийдэлд хүрээгүй тохиолдолд хууль дүрмийн дагуу зохицуулах, шийдвэрлэх.
- 4.8. Нууц хадгалах
 - 4.8.1. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа байгууллага, үйлчлүүлэгчийн хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй тараахгүй байх;
 - 4.8.2. Үйлчлүүлэгчийн талаар олж авсан нууцын зэрэгт харъяалагдах аливаа мэдээллийг зуучлалын гэрээний хугацаанд болон гэрээний хугацаа дууссаны дараа бусдад мэдээлэхгүй байх ба нууц мэдээлэл, сул талыг хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө үйлчлүүлэгчийн эсрэг ашиглахыг хориглоно.

/Хувийн ашиг сонирхлыг тэргүүнд тавихгүй байх/

- 4.9. Реалтор нь хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, хувийн болон үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх;
 - 4.9.1. Реалтор нь албаны мэдээллийг хувийн ашиг сонирхлын зорилгоор ашиглахгүй байх;
 - 4.9.2. Реалтор нь албан хэргээ гүйцэтгэх үйл ажиллагааны хүрээнд олсон орлого, зуучлалын хөлсний талаар байгууллагадаа үнэн зөв мэдээлэх;

- 4.9.3.Реалтор нь албан хэргээ гүйцэтгэх үйл ажиллагааны хүрээнээс гадуур байгууллагын удирдлагын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцэл хийхгүй байх;
- 4.9.4.Реалтор нь албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;
- 4.9.5.Реалтор нь албан үүргээ гүйцэтгэхдээ дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээд, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж авахгүй байх;
- 4.9.6.Реалтор нь албан үүргээ гүйцэтгэхдээ гэрээний үнийг өсгөх, хувьдаа завшихгүй байх;
- 4.9.7.Реалтор нь албан үүргээ гүйцэтгэхдээ гэрээний төлбөрийг дамжуулах үүрэг хүлээхгүй ба барьцаат төлбөр болон бусад төлбөрийг хувьдаа байршуулахгүй байх;
- 4.9.8.Реалтор нь зуучлалын хөлсийг бэлнээр авах бол баримт үйлддэг байх.

/Хариуцлага/

- 4.10.Хууль зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай харъяалагдах зуучлалын байгууллага, МҮХХЗНХолбоонд мэдээлэх;
- 4.11.Энэ Дүрмийг зөрчсөн Реалторуудад гаргасан зөрчлийн байдлаас шалтгаалан сахилгын хариуцлага тооцохыг харъяа зуучлалын компанид үүрэг болгох бөгөөд гаргасан зөрчил бүрийг тухайн Реалторын түүхтэй хавсаргаж байх ба цаашилбал зэрэглэлийг бууруулах;
- 4.12.Реалтор нь албан үүргээ гүйцэтгэх явцад байгууллага болон зуучлуулагч, үйлчлүүлэгчийг хохироосон, ёс зүйн дүрмийг удаа дараа зөрчсөн бол МҮХХЗНХолбооноос гэрчилгээг цуцлах.

(Тайлбар: Ёс зүйн дүрэм нь зах зээлийн байдал, хууль дүрэм, цаг үеийн дэвшил, өөрчлөлтөөс шалтгаалан шинэчлэгдэж болно.)

3. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Эрсдэл гэж юу вэ?

Эрсдэл гэдэг нь гадаад болон дотоод орчны нөлөөллөөс үүсэн хувь хүн, байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг үр дагавар юм. Эрсдэлийг үүсэх шалтгаан, учрах нөлөө, тохиолдох давтамж, учруулж болох хохирол зэрэг шинж чанараар нь ангилдаг. Эрсдэлийг хэзээ, хаана, ямар хэмжээний эрсдэл учрахыг урьдчилан тодорхойлоход бэрхшээлтэй байдаг. Аливаа эрсдэлийн цаана шалтгаан үр дагавар байдаг ба эрсдэлийн шалтгаан нь байгалийн хүчин зүйл эсхүл хүний хүчин зүйлээс хамаарч болно. Харин үр дагавар нь мөнгөн эсхүл мөнгөн бус хохирлоор хэмжигддэг.

Эрсдэлийн ангилал, төрөл

Ангилал	Төрөл
Үүсэх шалтгаанаар	<ul style="list-style-type: none">● Байгалийн хүчин зүйлийн эрсдэл: Ган, зуд, газар хөдлөлт, үер усны гамшиг гэх мэт● Эдийн засгийн эрсдэл: Ажилгүйдэл, инфляц, валютын ханш, гадаад өр гэх мэт● Улс төрийн хүчин зүйлийн эрсдэл: Улс төрийн тогтворгүй байдал, хууль эрх зүйн өөрчлөлт гэх мэт● Технологийн эрсдэл буюу аливаа зүйлийн элэгдэх, хуучрах зэргээс үүсэх эрсдэл● Холимог буюу дээрх хүчин зүйлийн аль алинаас нь хамаарч үүсэх эрсдэлүүд
Объект буюу хамрах хүрээгээр	<ul style="list-style-type: none">● Нэг эсхүл бүлэг хүмүүст учрах эрсдэл● Компанид учрах эрсдэл● Улс оронд учрах эрсдэл● Дэлхийн хэмжээнд учрах эрсдэл

Аливаа байгууллагад эрсдэл нь тодорхой хэмжээнд байдаг ба эрсдэлийн зөв менежментийг хэрэгжүүлэх нь чухал юм. Байгууллагын санхүүгийн эрсдэлийг ерөнхий дөрвөн бүлэгт хуваан нарийвчилдаг. Үүнд:

- **Зах зээлийн эрсдэл** - Нийт эдийн засагтай холбоо бүхий эрсдэлийн хүчин зүйлс.
- **Зээлийн эрсдэл** - Харилцагч талаас авсан мөнгөө бүрэн хэмжээгээр хугацаанд нь эсвэл хугацаа өнгөрснөөс хойш ч төлөхгүй байх эрсдэл. Зээлийн эрсдэлд үндсэн өрийн эрсдэл болон борлуулалтын зардлын эрсдэл орно.
- **Төлбөрийн чадварын эрсдэл** - Арилжааны банкуудын хувьд нэг талаас активын төлбөрийн чадвар, нөгөө талаас пассив буюу эх үүсвэрийн төлбөрийн чадвартай холбогдон гарах эрсдэл юм. Энэ нь харилцагч, хадгаламж эзэмшигчдийн анхны шаардлагыг биелүүлээгүйгээс учрах эрсдэл юм.

- **Үйл ажиллагааны эрсдэл** - Мэдээллийн систем, дотоод хяналт, хүний алдаа, удирдлагын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн алдагдлаас үүсэх эрсдэл юм. Энэ нь гадаад болон дотоод үйл явцад хамаатай.

Комплаенсын эрсдэл гэж юу вэ?

Комплаенс нь байгууллагын үйл ажиллагааг тухайн улсын хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэх, зохицуулагч байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь мөрдүүлэхээс гадна шударга байдал, ёс зүйн өргөн ухагдахууныг хамааруулж байгууллагын нэр хүнд, хууль, эрх зүй, санхүүгийн алдагдалд орох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чухал механизм юм.⁸

Банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хувьд комплаенсыг хэрэгжүүлэх нь тухайн байгууллагын ажилтан, харилцагч, дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчийн итгэл үнэмшлийг бэхжүүлэх, өөрийн байгууллагад учирч болохуйц аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

Аливаа байгууллага нь нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэн бизнесийн болон үйл ажиллагааны зорилгодоо хүрч чадахгүйд хүрэх эрсдэл, бизнесийн шийдлийн хэрэгжилт муу, өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицох чадвар бага зэргээс үүдэн бизнесийн боломжоо алдах, алдагдал хүлээх магадлалтай стратегийн эрсдэл, олон нийтийн сөрөг ойлголтоос үүдэн орлого, ашиг багасахад хүргэх нэр хүндийн эрсдэл зэрэг олон төрлийн эрсдэлтэй тулгарч байдаг. Тэгвэл эдгээр эрсдэлүүдээс хамгийн чухал нь буюу комплаенсын үйл ажиллагааны гол хэсэг нь комплаенсын эрсдэл байдаг.

Энэхүү комплаенсын эрсдэл нь хууль тогтоомж, дүрэм журам, ёс зүйн стандарт, байгууллагын дотоод бодлого зэрэг зөрчигдсөнөөс тухайн байгууллага нь нэр хүндээ алдах, тусгай зөвшөөрөл, лицензээ хураалгах, торгууль, акт тавиулах, санхүүгийн хувьд хохирохыг хэлдэг.

Аливаа байгууллага нь өөрийн байгууллагад учирч болох эрсдэлээ тогтоохын тулд зөвхөн эрсдэлийн үнэлгээний аргачлалыг ашиглахаас илүүтэйгээр комплаенсын эрсдэлийн үнэлгээний аргачлал руу шилжиж ашиглах хэрэгтэй.

Комплаенсын эрсдэлийн үнэлгээ /compliance risk assessment/

Комплаенсын үйл ажиллагааны чухал нэг хэсэг нь эрсдэлийн үнэлгээ юм. Комплаенсын эрсдэлийн үнэлгээ нь бизнес дэх “inherent” эрсдэлийг тодорхойлох, хянах эсвэл тухайн эрсдэлийг бууруулахын тулд байгууллагын зүгээс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг хэлдэг. Боломжит эрсдэл тус бүрийг үнэлэх зорилгоор бодит байдлын аргачлалыг ашиглан тухайн байгууллага нь эрсдэлд өртөх байдлаа ойлгож байх хэрэгтэй.

⁸ “Compliance Management Systems Handbook version 1.0”, The Office of the Currency, <https://www.occ.treas.gov/publications/publications-by-type/comptrollers-handbook/compliance-mgmt-systems/pub-ch-compliance-management-systems.pdf>

Комплаенсын эрсдэлийн үнэлгээ нь учирч болох эрсдэл, эрсдэл үүсэх шалтгаан, учруулж болох үр нөлөөг бүрэн хэмжээгээр тогтоохоос гадна тухайн байгууллага нь эрсдэлийг тогтоох, дүн шинжилгээ хийх, төлөвлөгөө боловсруулах, арга хэмжээ авахад шат дараалалтай тусалдаг.

Компани нь комплаенсын хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа бол хамгийн эхэнд эрсдэлийг тодорхойлж, үнэлгээг хийн, эрсдэлийн хэмжээг аль болох бууруулах чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

Комплаенсын эрсдэлийн үнэлгээ нь яагаад хэрэгтэй вэ?

- Банкнаас бусад санхүүгийн байгууллагад учирч болох эрсдэлийг тодорхойлох;
- Банкнаас бусад санхүүгийн байгууллагын хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчих магадлалыг үнэлэх;
- Эрсдэлийг бууруулахад чиглэсэн хяналтуудыг хэрэгжүүлэх;
- Үр дүнтэй, зөв шийдвэр гаргахын тулд байгууллагын дагаж мөрдөх комплаенсын эрсдэлийн түвшинг үнэлэх;
- Комплаенсид нийцсэн хязгаарлагдмал хугацаа, нөөцийг хамгийн сайн ашиглах.

Комплаенсын эрсдэлийн үнэлгээний үе шатууд

Тухайн байгууллага эрсдэлийн үнэлгээ хийхдээ өөрсдийн бизнесийн онцлогийг тусгах боломжтой бөгөөд түүнээс үл хамааран комплаенсын дараах алхмуудыг заавал гүйцэтгэнэ. Үүнд:

- Эрсдэлийг тодорхойлох /risk identification/
- Эрсдэлийг хэмжих /risk measurement/
- Эрсдэлийг хянах /risk monitoring/
- Эрсдэлийг удирдах /risk control and mitigation/

Комплаенсийн эрсдэлийн удирдлагын /compliance risk management/ энэхүү үе шатуудыг комплаенсийн нэгж /compliance unit/ хийж гүйцэтгэнэ.

Эрсдэлийг тодорхойлох /risk identification/: Энэ үе шат нь бизнесийн үйл ажиллагааны хаана аюул байгааг тодорхойлж ирээдүйд тулгарах эрсдэлээс сэргийлэхэд маш чухал алхам юм. Тулгараад байгаа эрсдэлүүд болон бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, гуравдагч талын харилцаанаас үүдэх, гадаад зах зээлээс хамаарсан эсхүл зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт зэргүүдээс үүсэх магадлалтай эрсдэлүүдийг тодорхойлох шаардлагатай. Эрсдэлийг тодорхойлох үйл ажиллагаа байгууллагын бүхий л түвшинд тасралтгүй хийгдэх ёстой бөгөөд дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй.

- Эрсдэлийн шинж чанар /nature of the risk/ - хаана, хэзээ, ямар үйл явдал тохиолддог вэ?

- Эрсдэлийн эх үүсвэр /source of the risk/ - ямар төрлийн хүмүүс эсхүл бизнес оролцох вэ?
- Эрсдэлийн шалтгаан /cause of the risk/ - эрсдэл яагаад тулгарч байгаа талаар шууд болон шууд бус шалтгаан юу вэ?
- Эрсдэлийн нөлөө /effect of the risk/ - үүсэх үр дагавар юу байх вэ? хэнд хамгийн сөрөг нөлөө үзүүлэх вэ?

Эрсдэлийг тодорхойлоход тухайн байгууллагад өмнө нь хууль, дүрэм журам дагаж мөрдөөгүйгээс аливаа торгууль, шийтгэл ногдож байсан эсэх, үйл ажиллагааны эрсдэлийн тайлан, дотоод аудитын тайлан, харилцагчдын өргөдөл гомдол, хэвлэл мэдээллийн мэдээ, зохицуулагч байгууллагын зөвлөгөө, төсөл хөтөлбөр зэрэг түүхэн датануудыг ашигладаг.

Эрсдэлийг хэмжих /risk measurement/: Өмнөх шатанд тодорхойлогдсон эрсдэлүүдийг нөлөөллийн хүчийг нь ялгаж харах зорилгоор ач холбогдлын түвшингээр нь ангилна. Ингэснээр эрсдэлийг хэмжихэд илүү хялбар болдог байна. Эрсдэлийг цаг алдалгүй, нарийвчлан тодорхойлох нь үр өгөөжтэй эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байдаг. Байгууллага нь өөрийн эрсдэлийн удирдлагын системтэй байх бөгөөд эрсдэлийн түвшин өндөр байх тусам улам нарийвчлалтай болдог байна. Байгууллага дотооддоо эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй арга нь зөв эсэх талаар тогтмол шалгалтыг хэрэгжүүлэх ёстой. Эрсдэлийг гүйлгээ бүрээр, багцын хүрээнд, байгууллагын хэмжээнд үнэлэх бөгөөд өсөн нэмэгдэж буй гүйлгээний хэмжээ зэрэгт илүү их анхаарал хандуулан ажиллах ёстой байна.

Эрсдэлийг хянах /risk monitoring/: Энэ үе шатанд байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, гүйлгээ, харилцагчийн мэдээлэл, харилцагч болон ажилчдын хоорондын харьцаа зэргийг нарийвчлан хянах шаардлагатай байдаг тул комплаенсийн нэгж нь дотоод аудит, хууль эрх зүйн нэгж, хяналт шалгалтын нэгж /security department/-тай хамтран ажиллаж өөрсдийн тайлан, үнэлгээнд үндэслэн зөвлөлдөх боломжтой.


Эрсдэлийг хянах гэсэн ойлголтыг өөрөөр эрсдэл нь хүлээн зөвшөөрөхүйц гэж үзсэн хэмжээнд байгаа эсэхийг шалгах гэж ойлгож болно. Энэхүү хэмжих үйл ажиллагааг байгууллагын комплаенсийн нэгж хариуцан гүйцэтгэх бөгөөд дараах үйл ажиллагаануудын тусламжтайгаар гүйцэтгэж болно. Үүнд:

- зохицуулалтын үнэлгээний үйл явцад оролцох;
- маркетингийн материалын үнэлгээнд оролцох;
- хэрэгжиж буй төслүүдэд оролцох оролцоо;
- тухайн байгууллагын нэгж тус бүрийн эрсдэлийн үнэлгээ хийх явцад оролцох;
- харилцагчдын өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад оролцох;
- туслах хэрэгслүүд (МУТСТ, ашиг сонирхлын зөрчил, өөрийн гүйлгээ гэх мэт);
- сургалт (хувийн мэдээллээ хадгалах, ёс зүй, байгууллагын нууцлал, МУТСТ) зэрэг болно.

Эдгээр үйл ажиллагаануудыг чанарын болон тоон хэрэгслүүдийг ашиглан комплаенсийн эрсдэлийг хянах шатанд хэрэглэдэг.

Чанарын хэрэгсэл /Qualitative tools/ нь бизнесийн үйл ажиллагаа болон аливаа эрсдэл тулгарах шалтгааныг дүрслэн харуулсан эрсдэлийн зураглал /risk map⁹/-ыг голчлон ашигладаг. Энэ нь эрсдэл тулгарсан, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай бизнесийн хэсгийг харуулж өгдөг онцлогтой.

Зураг 1. Эрсдэлийн зураглалын жишээ



Зураг 1-д харуулсанчлан зураглалыг гаргах бөгөөд тохиолдох магадлал /likelihood/ болон нөлөөллийн цар хүрээ /impact scale/-г дараах байдлаар тодорхойлж болно.

Хүснэгт 2. Тохиолдох магадлал, нөлөөллийн цар хүрээний ангилал

Тохиолдох магадлал		Нөлөөллийн цар хүрээ	
Ангилал	Тайлбар	Ангилал	Тайлбар

⁹ “Risk assessment in practice”, Deloitte & Touche LLP, <https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/global/Documents/Governance-Risk-Compliance/dttl-grc-riskassessmentinpractice.pdf>

<p>Байнгын /frequent/</p>	<p>2 хүртэлх жилд нэг удаа /төсөл хэрэгжих хугацаанд тохиолдох магадлал 90%-с дээш/</p>	<p>Маш аюултай /extreme/</p>	<ul style="list-style-type: none"> ● маш их хэмжээний мөнгөн алдагдал /X* сая төгрөгөөс их/ ● олон улсын хэмжээнд хэвлэл мэдээллээр байгууллагын талаар сөрөг мэдээ урт хугацаанд цацагдах ● зах зээлд эзлэх хэмжээ буурах ● торгууль, ял шийтгэлийн хэмжээ нь өндөр ● албан хаагчид эсхүл харилцагч зэрэг гуравдагч этгээдэд ноцтой хохирол учрах, бэртэж гэмтэх, амь насаа алдах
<p>Болох магадлалтай /likely/</p>	<p>2-25 жилд нэг удаа /төсөл хэрэгжих хугацаанд тохиолдох магадлал 65-90%/</p>	<p>Аюултай /major/</p>	<ul style="list-style-type: none"> ● их хэмжээний мөнгөн алдагдал /X сая төгрөгөөс X сая төгрөг/ ● улсын хэмжээнд хэвлэл мэдээллээр байгууллагын талаар сөрөг мэдээ урт хугацаанд цацагдах ● асуудлыг засаж залруулахад зохицуулагч байгууллагаас томоохон арга хэмжээ авах шаардлагатай ● албан хаагчид эсхүл харилцагч зэрэг гуравдагч этгээдэд учирсан хохиролд үзүүлэх тусламж хязгаарлагдмал
<p>Боломжтой /possible/</p>	<p>25-50 жилд нэг удаа /төсөл хэрэгжих хугацаанд тохиолдох магадлал 35-65%/</p>	<p>Дунд зэргийн /moderate/</p>	<p>мөнгөн алдагдал /X сая төгрөгөөс X сая төгрөг/ улсын хэмжээнд хэвлэл мэдээллээр байгууллагын талаар сөрөг мэдээ цацагдах зөрчлийн тухай мэдээллийг зохицуулагч байгууллагад хүргүүлж, засаж залруулах арга хэмжээг шуурхай авах албан хаагчид эсхүл харилцагч зэрэг гуравдагч этгээдэд эмчилгээ шаардлагатай байх</p>

Ховор /unlikely/	50-100 жилд нэг удаа /төсөл хэрэгжих хугацаанд тохиолдох магадлал 10-35%/	Бага /minor/	бага хэмжээний мөнгөн алдагдал /X сая төгрөгөөс X сая төгрөг/ нэр хүндэд сөргөөр нөлөөлөх зөрчлийн тухай мэдээллийг зохицуулагч байгууллагад мэдэгдэх хэмжээнд албан хаагчид, харилцагч зэрэг гуравдагч этгээдэд маш бага хэмжээнд эсхүл аливаа хохирол учраагүй
Маш ховор /rare/	100-с дээш жилд нэг удаа /төсөл хэрэгжих хугацаанд тохиолдох магадлал 10%-с доош/	Маш бага /incidental/	мөнгөн алдагдал /X сая төгрөг хүртэлх/ түр хугацаанд хэвлэл мэдээллээр шуугих зохицуулагч байгууллагад мэдэгдэх шаардлагагүй албан хаагчид эсхүл харилцагч зэрэг гуравдагч этгээдэд аливаа хохирол учраагүй

**X буюу мөнгөн алдагдлын хэмжээ, компани бүрийн хэмжээ, ашиг орлогоос хамаарч өөр байх боломжтой*

Мөн үүнээс гадна комплаенсийн эрсдэлийг хянах шатанд тоон хэрэгсэл /Quantitative tools/-ийг ашигладаг бөгөөд энэ нь элбэг олдоцтой, цуглуулахад хялбар, босго тогтооход хялбар зэрэг шинж чанартай үзүүлэлтүүдэд суурилдаг. Эдгээр үзүүлэлтүүдээс жишээ болгон харвал:

- хууль, журам дүрэм зөрсөн тохиолдлын тоо;
- харилцагчдаас ирсэн санал, гомдлын тоо;
- мөнгө угаах талаар сэжигтэй гүйлгээний тайлан, шинжилгээнүүд;
- шинэ зохицуулалт хэрэгжүүлэхэд гарах зардлын хэмжээ;
- харилцагчдаас зохицуулагч байгууллагад гаргасан өргөдөл, гомдлын тоо;
- зохицуулагч байгууллагаас ногдуулсан шийтгэл, торгуулийн хэмжээ;
- хийгдсэн хяналт, шалгалтын тоо;
- ёс зүйтэй холбоотойгоор ажилчдаас авсан судалгааны үр дүн;
- хөрөнгө оруулалтын талаар дүрэм, журам зөрсөн өөрийн гүйлгээний тоо;
- оройтож залруулах арга хэмжээ авсан тохиолдлын тоо зэрэг орно.

Эрсдэлийг хянах нь одоогийн нөхцөл байдалд шаардлагатай комплаенсийг хэрэгжүүлэх удирдлагын механизм бөгөөд энэ нь төлөвлөгдсөн, тогтмол, эрсдэлийн үнэлгээ дээр суурилж хийгддэг. Дээрх үзүүлэлтүүд нь тоон утгатай боловч эрсдэлийг хэмжихгүй, зөвхөн байгууллагын түүхэн болон одоогийн эрсдэлийн чиг хандлагыг харуулдаг. Эдгээр

тоон мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэх нь эрсдэл тулгарахаас өмнө урьдчилан мэдэгдэх дохиоллын системийг хөгжүүлэхэд ашигладаг.

Эрсдэлийг удирдах /risk control and mitigation/: Аливаа байгууллага нь эрсдэлийг бүрэн арилгах боломжгүй учир эрсдэлийн хэмжээг бууруулах, гарах сөрөг үр дагаврыг багасгах зорилгоор хүлээн зөвшөөрөхүйц бага түвшинд барих буюу эрсдэлийг удирдах алхмыг хэрэгжүүлдэг. Мөн эрсдэлийг удирдан, бууруулахад дотоод журмууд, ажилчдыг сургах, чиг үүргийн давхардлыг арилгах, “дөрвөн нүд” зарчмыг /“four eyes” principle¹⁰/ баримтлах, гүйлгээний талаар зохистой баримтжуулалт хийх, гал гарах, байгалийн гамшигт үзэгдэл тохиох, хулгай, терроризм зэрэг байгууллагыг ноцтой хохироож болзошгүй зүйлсээс техник хэрэгсэл, програм хангамж, тоног төхөөрөмжийг хамгаалах /physical security/ гэх зэрэг аргуудыг ашигладаг байна.

Эрсдэлээ үнэлснээр байгууллагад тулгарсан болон тулгарах магадлалтай комплаенсын эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Сайн боловсруулагдсан эрсдэлийн үнэлгээ нь тоон болон чанарын мэдээллийг агуулсан, бүтээгдэхүүн үйлчилгээ, бизнесийн бүхий л хүрээг хамарсан эрсдэлийг үнэлэхэд тохирсон аргачлалтай байдаг.

Хэрэв өөрийн хамрах хүрээ, зорилгыг нарийвчлан тодорхойлж чадвал комплаенсын эрсдэлийн үнэлгээ нь илүү үр дүнтэй болох боломжтой юм. Эрсдэлээр нь эрэмбэлэх, тодорхойлох, хэмжих, хянах, удирдах нь ихээхэн үр дүнтэй эрсдэлийг бууруулах үе шат юм.

¹⁰ Энэхүү зарчим нь гүйлгээ хийх, санхүүгийн шийдвэр гаргах зэрэг аливаа үйл ажилагааг хэрэгжүүлэхэд заавал хоёр хүнээр зөвшөөрөгдсөн байх шаардлагатай гэж үздэг. Бизнесийн хувьд энэ хоёр хүн нь гүйцэтгэх захирал болон санхүүгийн албаны дарга байна. Үүний шалтгаан нь нэг хүн шийдвэр гаргахад анзаараагүй алдааг хоёрдогч хүн илрүүлэх магадлал өндөр байдаг тул алдаа гарах эрсдэлийг бууруулдаг байна. Уг зарчмыг хэрэгжүүлэх үед бичиг баримт дээр тухайн хоёр хүний гарын үсэг заавал байх шаардлагатай байдаг.

МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Хорооноос хуулиар олгосон эрх зүйн хүрээнд санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад зориулсан заавал дагаж мөрдөх болон зөвлөмжийн шинж чанартай ёс зүйн журам заавруудыг боловсруулдаг. Зөвлөмжийн шинж чанартай ёс зүйн журам нь санхүүгийн үйлчилгээ үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компанийн бизнесийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явцад баримталбал зохих ёс зүйн хэм хэмжээг тогтоох, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ёс зүйн зөрчил гэдэгт холбогдох хууль, тогтоомж Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр болон журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн санаатай болон болгоомжгүй үйлдлийг ойлгоно.

Зохицуулагч байгууллагтай харилцах¹¹

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компани зохицуулагч байгууллагтай харилцахдаа дараах зарчмыг баримталж ажиллана.

- Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг болон компанийн дотооддоо мөрддөг дүрэм, журам, зааврыг чанд мөрдөн ажиллахын зэрэгцээ үйлчилгээний болон харилцааны өндөр соёлтойгоор ажиллах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага санхүүгийн тайлан мэдээг холбогдох хууль, журмын дагуу бүрэн гүйцэд, үнэн зөв, бодитой тусгах бөгөөд аливаа тайлан, мэдээ, данс бүртгэл, баримт материалыг санаатайгаар буруу гаргах, устгах, тэдгээрийг нуун дарагдуулахгүйгээр зохих заавар, стандартын дагуу үнэн зөвөөр цаг тухайд нь төрийн эрх бүхий байгууллагад мэдээлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан нь өөрийн компани, түүний удирдлага болон төрийн эрх бүхий байгууллага, үйлчлүүлэгч, олон нийтийн хоорондын харилцаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйлдэл гаргахгүй байх;
- Шинээр салбарын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн акт, мэдээлэлтэй байнга танилцаж үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;
- Төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, бодлогын арга хэмжээнүүдийг олон нийтэд гуйвуулан, худал мэдээлэл хүргэхгүй байх;
- Төрийн албан хаагчдад нөлөөлөх зорилгоор авилга, өндөр үнэтэй бэлэг, шагнал өгөхгүй байх, компанийн аль ч төвшний ажилтан хууль тогтоомж, дүрэм, журам, заавар зөрчихийг шаардахгүй байх, тусгай зөвшөөрөл эзэмшигч компани нь хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд байгууллагын үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэл тайлагнах;

¹¹ Эх сурвалж: Даатгалын салбарын компанийн засаглалын кодекс

Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, шаардлага, мэдэгдлийг зөрчсөн, зөрчихийг санаархсан удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын сөрөг талыг удирдлагадаа хэлж анхааруулж ажиллах нь зүйтэй

Хөрөнгө оруулагчтай харилцах¹²

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн бүтэц зохион байгуулалт нь дан ганц эрх зүйн зохицуулалтаас гадна өөрийн гэсэн нийтлэг зарчим, ёс зүйн хэм хэмжээг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн хэвшил болгох нь зүйтэй юм.

Хөрөнгө оруулагчид, санхүүжүүлэгчид, бизнесийн түншүүд, ажиллагсад зэрэг оролцогч талууд болон компанийн удирдлагын ашиг сонирхлын нэгдлийн зохистой харьцааг тогтоож, компанийн үйл ажиллагааг эрхлэн явуулах гадаад, дотоод таатай орчныг бий болгон, компанийн удирдлага болох төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны зохистой горимыг тогтоохын тулд компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлж, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас тодорхойлсон компанийн засаглалын үндсэн зарчмуудыг баримталж ажиллах шаардлагатай.

ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг, хариуцлагыг олон нийтэд ил тод нээлттэй байлгах, санхүүгийн тайланг хөндлөнгийн аудиторoor хянуулж хэвлэн нийтлэх, бүх хөрөнгө оруулагчдад үнэн зөв, бодит мэдээллийг цаг хугацаанд тэнцвэртэй хүргэх ёстой.

Аливаа санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч компанийн мэдээллийн ил тод байдал болон үнэн зөв тайлагнал нь тухайн компанийн удирдлагын нээлттэй, үнэнч шударга, ёс зүйтэй байдлыг илэрхийлнэ.

ТУЗ болон хөрөнгө оруулагчдыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангахад гүйцэтгэх удирдлагын баг дараах зарчмыг баримталж ажиллавал зохино.

Гүйцэтгэх удирдлагад ажиллах хувь хүн, багийн гишүүд нь тухайн компанийн үйл ажиллагаа явуулж буй салбар, чиглэлээр мэргэжлийн мэдлэг, дадлага туршлагатай байвал зохино;

- Гүйцэтгэх удирдлага нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх мэдээ, мэдээлэл, баримт материалтай саадгүй танилцах, холбогдох мэдээллийг цаг тухай бүр авах боломжоор хангагдсан байх;

- Үйл ажиллагаандаа хувьцаа эзэмшигчдийн болон харилцагчийн ашиг сонирхлоос гадна компанийн оролцогч бусад талууд болох бизнесийн түншүүд, ажилчид болон төрийн ашиг сонирхлыг харгалзан ажиллана;

Гүйцэтгэх удирдлагын багаас компанийн хувь нийлүүлэгчид, ТУЗ-ын гишүүдийн боловсрол, ур чадварын тухай дэлгэрэнгүй мэдээлэл болон тэдгээрийн өөрчлөгдсөн тухай мэдээлэл мөн тэдгээрийн үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад

¹² Эх сурвалж: Даатгалын салбарын компанийн засаглалын кодекс

хэрэг үүсгэсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн талаар мэдээллийг нийтэд мэдээллэдэг байвал зохино.

Ажилтан хоорондын харилцаа¹³

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн ажилтан өдөр тутмын үйл ажиллагаандаа дараах ёс зүйн зарчмыг баримталж ажиллана.

- Компанийн ажилтан хоорондоо харилцан итгэлцэл, хүндлэл, үнэнч шударга зарчмыг баримтлан хамтарч ажиллах;
- Үндэс угсаа, нас, хүйс, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаварлан гадуурхах, нэр төрийг гутаан доромжлох, дээрэлхэн сүрдүүлэх, гүтгэхээс ангид байх;
- Хэл амаар доромжлох, заналхийлэх, доог тохуу хийх, үйл хөдлөлөөр тохуурхах зэргээр ажил үүргээ хэвийн явуулахад саад тотгор, аливаа дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- Бүдүүлэг зан авир гаргах, бусадтай зүй бусаар харьцах болон бусдын эрүүл мэндэд хохирол учруулахгүй байх;
- Компанийн ажилтан нь компанийн өмч, албан мэдээлэл, өөрийн албан тушаалыг ашиглан олж авсан бизнесийн боломжийг өөрт ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд мэдээлэхгүй байх;
- Компанийн ажилтан ажил төрлийн холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулах замаар удирдлагаас шийдвэр гаргахад саад учруулж, цаг алдагдуулахгүй байх;
- Компанийн ажилтан бодит бус мэдээлэлд автахгүй байх мөн албан тушаал, эрх мэдлийн хэмжээгээр бусдыг ялгаварлахгүй байх;
- Компанийн ажилчдыг тэдний ажлын гүйцэтгэл болон ажлын гүйцэтгэлтэй хамаатай онцлог шинж чанаруудад нь тулгуурлан урамшуулах боломж олгох

Харилцагчийн эрх ашгийг хамгаалах

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компани харилцагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр дараах ёс зүйн зарчмыг баримталж ажиллавал зохино.

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч компани харилцагчийн эрх, ашиг, нэр хүндэд хүндэтгэлтэй хандах, харилцагчид шуурхай үйлчлэх;
- Харилцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, ажил үйлчилгээ явуулахдаа хэнийг ч ялгаварлаж хандахгүй байхын зэрэгцээ хамт ажиллаж байгаа болон бусад хүмүүсийн нэр төр, ажил хэргийн нэр хүндэд хүндэтгэлтэй хандана;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн ажилтан аливаа үйлчилгээ үзүүлсний төлөө харилцагч, түүний төлөөлөгчөөс шан харамж авах, өгөх, шаардах зэргээр салбарын нэр хүндийг унагаах, харшлах үйлдэл хийхгүй байх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх ашигт үл нийцэх, үйл ажиллагаанд нэр төр, эрх мэдэл, албан тушаалаа ашиглан хувь хүн, хуулийн этгээдэд аливаа давуу тал олгох,

¹³ Эх сурвалж: Даатгалын салбарын компанийн засаглалын кодекс

хөнгөлөлт үзүүлэх, өөрийн боломжийг хэтрүүлэн ашиглах, хуурамч бичиг баримт үйлдэхгүй байх;

- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан нь өөрийн компани, түүний удирдлага болон төрийн эрх бүхий байгууллага, үйлчлүүлэгч, олон нийтийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйлдэл гаргахгүй;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол, зар сурталчилгаа болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь олон нийтийг төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан мэдээлэл гаргахгүй байх;
- Харилцагчид үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал гаргах, аашилж зандрах, айлгах сүрдүүлэх, дарамтлах, тэдгээрийн мэдлэг, мэдээллийн дутмаг байдлыг ашиглан хууран мэхлэх үйлдэл гаргахгүй байх;
- Харилцагчийн мэдээлэл, баримт материалыг хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, задруулахгүй байх;
- Харилцагч нартаа өөрийн өрсөлдөгч байгууллагуудад шударга бусаар хандахыг зааварлахгүй байх, Олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэх, олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэж ажиллах нь зүйтэй.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх

Авлига гэж юу вэ?

Авлига нь хээл хахууль, шан харамжийн шинжтэй үйлдлүүдийг хамарсан өргөн утга агуулга бүхий ойлголт. Энэ үзэгдлийг олон янзаар тодорхойлдог, тиймээс ч олон улсын хууль зүйн нэгдсэн нэг шалгуур үзүүлэлтээр үнэлэгдээгүй байна.

Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар толь бичигт: ”Эдэд шунах, ёсон бус аргаар юмыг олзолж авах” гэж тодорхойлжээ.

Харин Авлигын эсрэг хуульд “**Авлига гэж албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил**” гэж заасан байна.

Түүнчлэн Монгол улсад авлигын эсрэг судалгааны үйл ажиллагаа явуулдаг Транспэрэнси Итернэшнл байгууллага нь авлигыг “**итгэж олгосон эрх мэдлийг хувийн ашиг хонжоо олоход ашиглах**” гэдгийг онцолсон.

Аливаа төрийн болон хувийн хэвшлийн албан хаагч өөрт нь итгэж олгосон эрх хэмжээ буюу албан тушаалын байдлаа тухайн албаны эрх ашгийн эсрэг хувийн ашиг сонирхолдоо урвуулан ашиглаж, хийвэл зохих үүргээс татгалзах, эсхүл хийхийг хориглосон үйлдэл, зүй бус үзэгдлийг авлига илэрхийлдэг байна. Өөрөөр хэлбэл итгэж олгосон эрх мэдлийг ашиг олох үүднээс урвуулах үйлдлийг авлига гэж тодорхойлж болох юм. Тэрхүү шинжийг товчхон харуулбал: Энэ нь

- Нийгэмд хортой үр дагавар бүхий үзэгдэл

- Төрийн алба, улс төр, бизнесийн хүрээн дэх “худалдагдсан” эрх мэдэл
- Албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоогоор солих
- Бусдад давуу байдал олгох

Хууль бусаар албаны эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах явдал гэх мэт үндэслэл бий.

Аливаа улсын төр барьж буй албан тушаалтан, улс төрийн зүтгэлтнүүд, засаглалыг хэрэгжүүлэгч эрх мэдэл бүхий хүмүүс хээл хахуульд автагдах магадлал харьцангуй их байдаг. Үүнийг тайбарлахдаа засаглал бол хариуцлагатай алба бөгөөд эрх мэдэл нь хүнийг эвддэг гэсэн өмгөөлөл буруутгалын холилдсон тодорхойлолт өгөхөөс өмнө тэдгээр хүмүүсийн үүргээ ухамсарлах ёс зүй, хариуцлага хүлээх чадвар, ажил хэрэгч байдал хийгээд түүний шалгуур болсон ёс суртахууны төлөвшлийн тухай асуудалд юуны урьд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Авлига нь нөхцөл боломж, хүсэл шуналын огтлолцол дээр амархан бий болно. Хахуулийг санал болгож буй тал нь өөрсдийн эрх хэмжээ хүрэлцэхгүй байгаа ямар нэгэн асуудлыг шийдвэрлүүлэхийг хүсэж байгаа, эсвэл хууль дүрмийг уландаа гишгэж ямар нэг байдлаар шан харамж өгөхгүй бол тухайн албан хаагч хүссэн зүйлийг нь гүйцэлдүүлэхгүй хэмээх ойлголттой болсны үндсэн дээр эрх мэдэлтэнд хандаж байж болох юм. Нийгмийн ядуу дорой байдал нь бусдын хүсэл шуналыг төрүүлэх нэгэн хүчин зүйл мөн боловч аливаа асуудалд бодитой хандах эрүүл саруул ухаан нь авлигал үүсэх нөхцөл боломжийг хязгаарлах арга зам болно.

Авлигын үндсэн шинж

Авлигын төрлүүд

Авлигын олон төрөл байх бөгөөд тэдгээрийг янз бүрээр ангилсан байдаг авч төрөл бүрийн судалгаа, бүтээлийг харьцуулан үзээд дараахи 3 бүлэгт хувааж үзэх нь зүйтэй байна. Үүнд:

“Жижиг” ба “том” хэмжээний авлига

Жижиг авлига. Энэ нь бага тушаалын албан хаагчтай хамаатай, мөнгөн дүнгийн хувьд их биш, голдуу төрийн албан хаагчид хясан боогдуулах замаар шан харамж авах байдлаар илэрнэ. Жижиг авлигын хохирогчид нь нийтлэг шинжтэй олны хамарсан жирийн иргэд байдаг бөгөөд жижиг авлигыг бюрократ авлига буюу хүнд суртлын хэмээн нэрлэнэ. Жижиг авлигын түгээмэл тохиолддог салбарууд нь боловсрол, эрүүл мэнд, татварын алба, хөдөлмөр зохицуулалтын алба, газрын алба, нийгмийн халамжийн алба, цагдаа, байгаль хамгаалагч, зам харилцаа холбооны ажилтан болох нь авлигын талаархи судалгаануудаар ажиглагдсан.

Том авлига. Улс төр, санхүү, засаг захиргааны томоохон албан тушаалтнууд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад албан тушаалаа хувийн ашиг хонжоо олоход ашигласан их хэмжээний мөнгөн дүнтэй үйлдлийг том авлига гэнэ. Энэ нь маш ноцтой шинжтэй, ихээхэн хор уршиг бүхий үр дагвартай юм. Жишээ нь: зөвшөөрлийг хүчингүй болгох, хэн нэгэнд ямар нэг салбарт давуу эрх эдлэх зөвшөөрөл олгох, төр засгийн шийдвэр гаргагчийн зүгээс уралдаант шалгаруулалтийн нөхцөл болон жишиг стандартыг өөрчлөх, гадаадын

иргэн хуулийн этгээдээс хахууль авч гадны банкинд данс нээлгэх, татвараас чөлөөлөх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гэх мэт хэлбэрүүдтэй байдаг байна.

Улс төр, захиргаа ба бизнесийн авлига

Улс төрийн авлига нь хөгжиж буй болон нэн буурай хөгжилтэй оронд голчлон сонгуулийн үйл явцтай уялдаа холбоотойгоор илэрлээ олдог. Цөөнхийн засаглал, улс төрчид, сонгуулийн хорооны гишүүдийг хахуульдах, улс төрийн хуурамч амлалт өгөх, сэтгүүлчдийг худалдаж авах, сонгогчдод мөнгө ба бусад зүйлс тараах зэргээр илэрдэг. Бодлогын хэрэгжилтийг гардан хариуцах явцыг гажуудуулж буй авлигыг захиргааны авлига гэнэ. Зохих шаардлага хангахгүй хүнд лиценз олгох явдал манайд хавтгайрсан нэг жишээ юм. Бизнесийн авлига бол гэмт хэрэг биш харин ажил төрлөө хурдан бүтээх, хүнд суртлыг гэтлэн давах арга гэх мэтээр авлигыг зөвтгөх хандлагатай янз бүрийн тайлбарууд байдаг ч энэ нь шударга ёсонд яавч нийцэхгүй. Тухайн төрлийн авлига нь хээл хахууль, дотоод мэдээллийн нууцыг задруулан ашиг олох, мөнгө угаах, хөрөнгө мөнгө завших, татвараас зугатах, дансны аргаар хожих зэрэг янз бүрийн хэлбэрүүдтэй.

Зохион байгуулалттай буюу зохион байгуулалтгүй авлига

Авлига тодорхой зохион байгуулалтанд орох нь олонтой. Энэ үед хэн гэгчид хэдийг өгөх, авсан хүн эргээд ямар хариу барихыг аль аль тал нь харилцан тооцоолсон байдаг. Зохион байгуулалттай авлигыг гэмт бүлэглэл үйлдэх нь элбэг. Хүний нэр ашиглах нь зохион байгуулалттай авлигын нэгэн илрэл гэх үндэслэл бүрнээ бий. Харин хэнд хэдийг өгөх нь тодорхой бус, авсан хүн эргээд хариу барих баталгаагүй бол зохион байгуулалтгүй авлигад тооцогдох учиртай. Энэ үед авлига өгөгч, авагчийн хооронд тохироо үгүй, хэлснээр өгч, авах ба эцсийн үр дүн нь тодорхойгүй байдаг өөрийн онцлогоор ялгагдана.

Авлигын хэлбэрүүд

- **Bribery /Хээл хахууль/-** “Албан хаагч, эсхүл бусад хүний албаны буюу хууль ёсны үүргийг биелүүлэхгүй болгоход нөлөөлөхийн тулд аливаа үнэт зүйлийг санал болгох, өгөх, авах, зуучлах”
- **Kickbacks-** Төр олон нийтийн эд хөрөнгө, мөн хамтын өмчийг хувь хүн, хувийн аж ахуйн нэгжид хууль бусаар олгох хэлбэрийг хэлнэ.
- **Embezzlement, theft and fraud-**Залилан мэхлэх, өмч хөрөнгө шамшигдуулах хэлбэрийг хэлнэ
- **Extortion-**Айлган сүрдүүлэх: Хэн нэгэн этгээдийг хууль бус үйлдэлдээ хамтран ажиллуулахын тулд хүч хэрэглэхээр айлган сүрдүүлэх, нэр хүндийг нь унагаж болзошгүй мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацна гэж айлгах гэх мэт.
- **Abuse of discretion-** Нээлттэй бус байдлыг урвуулан ашиглахыг хэлнэ
- **Favoritism-**Давуу тал олгох гэсэн үг.
- **Patronage, improper political contributions-**Улс төрийн намд зүй бусаар хандив олгох: одоо эрх барьж буй эсвэл ирээдүйд эрх барих нам болон төрийн өндөр албан тушаалтан аливаа сонгуулийн үеэр болон дараа мөнгө болон бусад зүйлийг

хандивын хэлбэрээр өөрийг нь дэмжигч этгээдийг нөхөн төлбөр болгон төрийн аливаа албан тушаалд томилох буюу томилуулах хэлбэр юм.

- **Шан харамж**-Авлигын шинжтэй эрх зүйн зөрчлийн нийгмийн хор аюулын зэрэглэлээр харьцангуй бага хэлбэр. Албаны үүргээ зохих ёсоор биелүүлсний төлөө тухайн этгээдийг хувиараа урамшуулан шагнахыг шан харамжид хамааруулж ойлгоно. Өнгөц харахад үүнд буруу зүйл байхгүй мэт боловч үзүүлэх хор нөлөө нь их юм. Шан харамж өгч байгаа хүний хувьд баярласнаа илэрхийлэхээс өөр гэм буруутай санаа байдаггүй мэт боловч авч байгаа албан хаагчийн хувьд мэргэжлийн ёс зүйг ноцтой зөрчсөн үйлдэл учраас гаж үзэгдэл рүү түлхэж буй хэлбэр.
- **Graft /Бэлэг/-**Тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн бэлэг авах, түүнчлэн өөрийн эрх мэдлээ урвуулан ашиг олох, аль нэг явцуу бүлэгт үйлчлэх зорилгоор нийтэд мэдээлэгдэхээс өмнө олж авсан мэдээллийг ашиглан өөртөө болон бусдад давуу эрх бий болгох хэлбэрийг хэлнэ. Бэлэг өгсөн тохиолдол бүрт “Намайг ийм албан тушаалгүй бол энэ хүн тухайн бэлгийг өгөх байсан уу” гэсэн асуултыг тавьж олсон хариултаараа авлигын шинжтэй эсэхийн заагийг ялгаж байх шаардлагатай. Бэлэг авлигын шинжтэй эсэхийг чухамхүү энэ шинжээр л тодорхойлж болно.
- **Ах дүүсэх**, найзархах-Албан тушаалтан аливаа асуудлаар найз нөхдөдөө, эсхүл төрөл садан, ах дүү нартаа илүү ашигтай шийдвэр гаргах, тэдний ажил хэргийн мэдлэг, чадварыг үл харгалзан зөвхөн хувийн харьцааны шалгуурыг баримтлан албан тушаалд томилох зэрэг байдлуудаар авлигын энэ хэлбэр илэрнэ.
- **Тал тохой** татах-Энэ нь ихэвчлэн албан тушаалын томилгоотой холбоотой илэрдэг авлигын хэлбэр юм. Албан тушаалд танилаа, эсхүл танилынхаа санал болгосон хүнийг, бүр тодруулбал “дотно танилын шалгуур”-ыг ажил хэргийнхээс ямар ч үндэслэлгүйгээр илүүд үзэж томилох явдал авлигын энэ хэлбэрийн агуулга мөн чанарыг тодорхойлно.
- **Зүй бусаар тал өгөх буюу хөнгөлөлт** үзүүлэх-Төрийн байгууллага, албан тушаалтан зарим аж ахуйн нэгжид ялгаварлан тал өгч хэт ойр харилцаа үүсгэн түүнд тусгайлсан дэмжлэг үзүүлэх явдлаар авлигын энэ хэлбэр илэрнэ.

Авлигын гэмт хэргийг үйлдэх хэлбэр нь:

“Бүтцэд суурилсан” буюу урьдчилан төлөвлөж, системтэйгээр үйлдэгдэх,

“Нөхцөлд суурилсан” буюу тохиолдолоор, тухайн үед бий болсон нөхцөл байдлаас шалтгаалан авлига үйлдэх хэлбэрүүдээр илэрлээ олно.

Авлигын илэрч болох гэмт хэргүүд. Үүнд:

-Эх орноосоо урвах, төрд тэрслэх, хууль бусаар гадаад мөнгө шилжүүлж, хил давуулж хориотой наймаа хийх,

-Дээрэм тонуул хийх, төрийн өмчийг завших, халаас суйлах ба хулгай хийх

-Хууль бусаар хөрөнгө эзэмших, хуурамч зүйл үйлдвэрлэх, дансны аргаар мөнгө идэх, өмч хөрөнгийг зүй бусаар ашиглах, зарцуулах

-Эрх мэдлээ урвуулан ашиглах, айлган сүрдүүлэх, тарчлаан зовоох, ул үндэслэлгүй өршөөл, уучлал үзүүлэх

-Мэхлэх, луйвардах, худал мэдүүлэх, хуурч залилах

-Шүүхийн шийдвэрийг мушгин гуйвуулах, хуурамч нотолгоо гаргах, хууль бусаар баривчлах, хүчээр хэрэг хүлээлгэх

-Үүрэг хариуцлагаа үл гүйцэтгэх, ажил цалгардуулах, бусдын хүчийг мөлжих

-Хээл хахууль, шан харамж авах, бусдын хөрөнгийг сүрдүүлж авах, хууль бус ашиг хонжоо олох, хууль бус орлого бий болгох

-Сонгуулийн булхай хийх, санал будлиантуулах, шудрага бус замаар орлого олох

-Нууц мэдээллийг зүй бусаар ашиглах, бичиг баримтыг хуурамчаар үйлдэх

-Төрийн албан тушаал, өмч хөрөнгө, зөвшөөрлийг дур мэдэн худалдах, хууль бус дүрэм журам гаргах, худалдан авсан эрх болон эд зүйлсийн нэр төрөл, үнийн жагсаалт, гэрээ болон зээлийг будлиантуулах

-Татвараас зайлсхийх боломж олгох

-Нөлөөлөх оролдлого гаргах, тал засч зуучлах, ашиг сонирхлын зөрчилд автах

-Зүй зохисгүй бэлэг, мөнгөн төлбөр, үзвэр үйлчилгээ, дайллага цайллагад орох

-Тал тохой татах, бусдыг хаацайлах

-Хууль бус хяналт шалгалт хийх, харилцаа холбоо болон бичиг баримт шууданг зүй бусаар ашиглах

-Албаны тамга тэмдэг, бичиг хэрэг, орон байр болон давуу эрхийг урвуулах ашиглах гэх мэт юм. Энэ бүхнээс үзэхэд нийгмийн тогтолцоог сөрөг болгох сэтгэл түгшээх хичнээн олон хууль бус гэмт хэргүүд байгаа нь тодорхой.

Авлигыг өгнө, авна гэж ярих нь зөв үү?

Авлигыг зөвхөн хээл хахууль гэж явцууруулан ойлгосноос болж “Авлига өгнө, авна” гэсэн үг бий болоод байна. Тухайлбал, “Архидалтыг ууна” гэж монголчууд ярьдаггүй. Архидалт гэдэг нь нийгмийн үзэгдэл, “архи уух” гэдэг нь архидалт гэдэг нийгмийн хорт үзэгдлийг бүрдүүлдэг нэг л үзэгдэл. Тиймээс **авлига бий болно, хээл хахууль өгнө авна** гэж ярих нь зүйтэй.

Авлига, хээл хахууль гэсэн ойлголт адилхан уу?

Авлига хээл хахууль гэсэн хоёр ойлголтыг хооронд нь адил мэт ойлгох нь Их мөрөнг уулын горхитой зүйрлэхтэй адил эрс тэс ялгаатай ойлголт.

Авлига нь нийгмийн үзэгдэл. Хээл хахууль нь авлига гэдэг нийгмийн хорт үзэгдлийг бүрдүүлэгч үзэгдлийн нэг буюу Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг.

Авлигын гэмт хэрэг

Монгол Улсын эрүүгийн хуулийн 12 зүйлд авлигын гэмт хэргийг албан тушаалын гэмт хэмээн хуульчилсан:

- Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах
- Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх
- Албан тушаалтны нэр барих
- Хээл хахууль өгөх
- Хээл хахууль зуучлах
- Хээл хахууль авах
- Хууль бусаар хөрөнгөжих
- Албан тушаалтан хуурамч бичиг баримт үйлдэх
- Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах гэх мэт.

Авлигын гэмт хэргийн онцлог

Авлигын гэмт хэрэг нь дараах шинжтэй байдаг. Үүнд:

- Энэ төрлийн гэмт хэрэг голдуу гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгддэг;
- Гэмт хэрэг үйлдэгчид нь сайтар төлөвлөсөн, зохион байгуулалттай, нуугдмал байдлаар үйлдэгддэг;
- Албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгох, иргэн хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрнэ;
- Улс, олон нийтийн ашиг сонирхол, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд гэм хор (хохирол) учруулдаг;
- Албан тушаалын гэмт хэргийн бүлэгт заасан ихэнхи гэмт хэрэг материаллаг бүрэлдэхүүнтэй өөрөөр хэлбэл Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд бусдад заавал хор уршиг учирсан байхыг шаарддаг (*хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй буюу гэмт хэргийн улмаас бусдад хохирол учраагүй байж болно*);
- Хэд хэдэн улс, аймаг дамжин үйлдэгддэг;
- Нотлох баримтыг устгах буюу үйлдлээ хууль ёсны мэт халхавчилсан байдлаар үйлддэг;

- Энэ төрлийн гэмт хэрэг нь олон холбогдогчтой, ээдрээ түвэгтэй, олны анхаарлын төвд байдгаас гадна зарим тохиолдолд нийгэмд сөрөг уур амьсгал бүрдүүлдэг.

- Албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжийг зайлшгүй буюу нэмэлт гэж хоёр ангилна. Зайлшгүй байх шинжид гэм буруугийн шууд санаатай хэлбэр, нэмэлт шинжид тусгай зорилго агуулсан, шунахай сэдэлттэй байхаас гадна гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл санааны байдал ч орж болно;

- Гэрч нь ихэвчлэн хэрэгт шалгагдаж буй сэжигтэн, яллагдагчийн шууд болон шууд бус хараат байдалд байдаг;

- “Чимээгүй байх” хууль үйлчилдэг учир талууд хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах сонирхол багатай

Авлига бусад төрлийн хүнд ноцтой гэмт хэргийн гаралтад шууд нөлөөлдөг

Авлига нь дор дурдсан гэмт хэргийн гаралтад шууд нөлөөлдөг.

- Зохион байгуулалттай гэмт хэрэг
- Хар тамхины хууль бус наймаа
- Хүний наймаа
- Галт зэвсэгийн хууль бус наймаа
- Алан хядах ажиллагаа

Дээр дурдсан таван төрлийн гэмт хэргүүд нь яагаад авлигатай шууд холбогддог вэ?

1. Авлигачдын өмгөөлөл хамгаалал дор үйлдэгддэг
2. Гэмт хэрэг үйлдсэн ул мөрөө баллахдаа авлигачидтай хамтардаг
3. Хууль сахиулах болон шүүхийн байгууллагад шалгагдахад авлигачдын нөмөр нөөлгийг авдаг
4. Бусад гэмт бүлэглэлүүдтэй тэмцэхдээ авлигачдын туслалцааг авдаг

Авлига зөвхөн төрийн албанд байдаг уу...?

Авлига нь эрх мэдэлд тавих хяналт сул, хөрөнгө мөнгө, эрх мэдлээ ахиулж болох боломжтой бол хаана ч үүсэн бий болох боломжтой. Жишээ нь:

- Улс төрийн хүрээн дэх авлига
- Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига
- Төрийн байгууллага дахь авлига
- Хувийн хэвшил дэх авлига
- Олон улсын байгууллага болон олон улсын гэрээ хэлцэл
- Сонгуулийн авлига гэх мэт

Ашиг сонирхлын зөрчил гэж юү вэ?

Нийтийн ашиг сонирхол гэж юү вэ?

Нийтийн ашиг сонирхол гэж: албан тушаалтан хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хувийн ашиг сонирхлоосоо ангид, тэгш, шударгаар ажиллана гэсэн олон нийтийн итгэл юм. Энэ бол аль нэг хувь хүн эсвэл бүлгийн сонирхол биш. Харин нийт иргэдийн нийтлэг ашиг сонирхол юм.

Нийтийн албан тушаалтан гэж хэн бэ?

Нийтийн албан тушаалтан гэж нийт олны эрх ашгийн төлөө төрийн байгууллагад албан тушаал хашиж байгаа хүмүүс юм. Өөрөөр хэлбэл таны оршин суугаа хороо, дүүргийн засаг дарга, эмнэлгийн дарга, цагдаагийн хэлтсийн даргаас эхлээд улсын их хурлын гишүүн, төрийн сайд хүртэлх олон албан тушаалтнууд энд багтана. **Нийтийн албан тушаалтан гэдэгт дараах албан тушаалтнууд багтана:**

- Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан
- Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан
- Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан
- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтад орсон албан тушаалтан

Хувийн ашиг сонирхол гэж: Нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ. Харин хамаарал бүхий этгээд гэдэг нь тухайн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах эгч дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр, нөхрийн эцэг, эх, төрсөн ах эгч дүү болон тухайн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээд юм.

Ашиг сонирхлын зөрчил гэж юү вэ?

Нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг ашиг сонирхлын зөрчил гэнэ.

Нийтийн албан дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 1 сарын 19-нд баталсан.

Ашиг сонирхлын зөрчлийг хуулиар зохицуулснаар:

- Албан хаагчид албан тушаалын гэмт хэрэг үйлдэхээс сэргийлнэ
- Төрийн бодлого, үйл ажиллагаа болон албан хаагчдад итгэх олон нийтийн итгэл нэмэгдэнэ
- Нийгэмд шударга ёс бэхжинэ
- Улс орны эдийн засгийн үр ашиг дээшилнэ

Хэрэв хуулиар зохицуулахгүй бол:

- Авлига, албан тушаалын гэмт хэрэг нэмэгдэнэ
- Баялгийн хуваарилалт тэгш бус болж баян ядуугийн ялгаа нэмэгдэнэ
- Шударга ёс алдагдаж иргэдийн эрх ашиг зөрчигдөнө

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэн ямар үүрэг хүлээдэг вэ?

Төрийн байгууллага, түүний удирдлага нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээг авах үүрэгтэй байдаг.

- Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ёс зүйн дүрэм тогтоож, мөрдүүлэх
- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг авах, бүртгэх, хянан шалгах
- Байгууллага дахь ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх
- Ашиг сонирхлын зөрчил үүссэн болон үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх, мөн урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар зөвлөмж өгөх
- Албан тушаалтан хууль, журмаар зөвшөөрсөн тохиолдолд давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх

Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах талаар хуулийн дараах зохицуулалт байдаг. Үүнд:

- Нийтийн албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах үүрэгтэй
- Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд тухайн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх ёстой.
- Ашиг сонирхлын зөрчил байгаа талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно. Харин ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авсан байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй гаргана.

- Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдлыг бичгээр тайлбарлана.

Нийтийн албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь нөлөөлсөн аливаа дарамт, шахалтын талаар удирдлага, эрх бүхий байгууллага, мөн Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй байдаг. Албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдуулан бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөлийг санал болгосон тохиолдолд дараах арга хэмжээг авах ёстой:

- Саналаас татгалзах
- Санал тавьсан этгээдийг тодорхойлох
- Тодорхой нөхцөл байдлын улмаас бэлгийг эргүүлэн өгөх боломжгүй бол бэлгийг хадгалах ба энэ талаар удирдлагадаа мэдэгдэх
- Боломжтой бол тухайн үйл явдлын гэрчийг тэмдэглэх
- Болсон нөхцөл байдлын талаарх мэдэгдлээ удирдлагадаа бичгээр хүргүүлэх
- Хариуцлага хүлээхээр зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага албан тушаалтанд мэдэгдэх

Авлигын нийгмийн болон хувийн хэвшилд үзүүлэх хор аюул

Монголын ХХ зууны эхэн үеийн нийгэм-улс төрийн томоохон сэтгэгчдийн нэг болох Ч.Дандаа 1922 онд бичсэн “Шинэ засгийн гол ёс” гэдэг зохиолдоо “элдэв улсын мандах мөхөх нь гадаадын туслах хорлоход үгүй, харин дотоод засгийн ариун тодорхойд буй”¹⁴ гэжээ. Италийн нийгмийн зүтгэлтэн түүхч Никколо Маккавели авлигын мөн чанарыг “Авлига нь ямар ч олон хэлбэр төрхтэй байлаа ч эцэстээ улс орныг сүйрүүлэх хүчтэй байдаг” хэмээн илэрхийлжээ.

Авлигын хор уршиг нь дор дурдсан байдлаар илэрдэг:

- Бизнесийн шударга өрсөлдөөн байхгүй болдог

Шударга өрсөлдөөн байхгүй болсноор бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, чанар муудан, иргэдийн аюулгүй байдалд занал учруулж эхэлнэ. Хэт монопол байдал бий болж тэд төрийн албан хаагчдыг худалдан авч эхэлнэ.

- Хоцрогдсон техник, технологи орж ирэх нь ихэсдэг

Стандартын бус техник, тоног төхөөрөмж, шаардлагагүй технологи тухайн улсад ихээр орж ирнэ.

- Үнэ өртөг ихтэй ач холбогдол багатай төслүүд ихээр орж ирдэг

- Чанаргүй бараа бүтээгдэхүүн нэмэгддэг

Улсын хилээр чанаргүй, хугацаа нь дууссан, технологийн хувьд хоцрогдсон бараа бүтээгдэхүүн орж ирэх нь нэмэгдэнэ. Дотооддоо чанаргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь нэмэгдэнэ.

¹⁴ Ч.Дандаа. *Шинэ засгийн гол ёс*. 1922. УНС. Гар бичмэл. 8 дахь тал

- **Үйлчилгээ, зарим төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг өсгөдөг**

- **Жирийн ард түмний амьдралд хүндээр тусна**

Өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүн авч дийлэхгүй. Чанаргүй бараа бүтээгдэхүүний улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирох явдал ихсэнэ.

- **Авлига гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа, гэмт хэрэгтнүүдийн үйл ажиллагааг дэмжигч хамгаалах хэрэгсэл болно**

- **Засгийн газар болон төрийн бусад байгууллага хүссэн үр дүндээ хүрч чадахгүй.**

Авлигаар томилогдсон албан тушаалтан үр бүтээлтэй ажиллаж чадахгүй. Шударгаар ажилд орох, үр дүнтэй ажиллах боломж хаагдахаар сурагч, оюутнуудын сурах эрмэлзлэл буурч боловсролын тогтолцоонд гажуудал үүсч эхэлнэ

- **Ардчилалын үнэт зүйл аажмаар алга болно.**

Шударга ажилтнууд үзэл бодлынхоо төлөө шахагдах, гадуурхагдаж эхэлнэ. Асуудлыг олонхоор бус эрх мэдэлтнүүд шийдэж эхэлнэ. Хүмүүс хэн нэгэн хүн, ашиг сонирхлын бүлэглэлийн нөлөөнд аажмаар орж эхэлнэ.

Ардчиллын үнэт зүйл алдагдсанаар сонгуулийн авлига, ард түмний саналыг луйвардах нь ихсэнэ.

- **Хэвлэл мэдээллийн эрх чөлөө алдагдана.**

Шударга сэтгүүлчдийг худалдаж авч чадахгүй болохоор түүний ажилладаг хэвлэл мэдээллийн хэрэгслийг худалдаж авна. Сэтгүүлчдийн амь нас, эрүүл мэндэд илт халдаж эхэлнэ.

- **Авъяас чадалтай чадварлаг хүмүүс гадаад руу ихээр гарч эхэлнэ. Улс орноо хөгжүүлж чадахгүй.**

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага шударга, чадварлаг хүмүүсийг шахан гадуурхаж тэднийг ажиллах боломжийг боогдуулна.

- **Тухайн орны нөхцөл байдлыг гадаадынхан илүү сайн мэддэг болно.**

Тухайн орны хүний үнэ цэнэ буурч үндэсний эрдэмтэн судлаачдаас илүү гадаад хүний үгийг сонсдог болно.

- **Авлига газар авснаар төрийн алба тэр чигээрээ ёс зүйн хэм хэмжээгээ алдан элэгдэж эхэлнэ.**

Нийтээрээ авлигад идэгдэж байхад би ганц дайчин болоод яах вэ гэж өөрөөсөө асуухад хүрдэг.

- **Засаг төр авлигад идэгдсэнээр олон түмний итгэл алдарч явуулж буй үйл ажиллагааг дэмжихээ больдог.**

Төрийн өндөр албан тушаалтнууд авлигад автсанаараа жирийн иргэд ч би яагаад болохгүй гэж бүгд авлигад автаж байна гэж бодоход хүргэнэ. Хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд авлигад автаж эхэлнэ.

- Улс төрчид авлигатай зоригтой тэмцэх хүсэл сонирхлоо илэрхийлэх, тухайн үйл ажиллагаанд манлайлан оролцохдоо болгоомжилж эхэлнэ.

- Улс орны эрх ашгийн төлөө бус хувийн явцуу эрх ашгаа хөөж улс төрийн түвшинд алсыг харсан, ард түмэндээ ашигтай шийдвэр гаргах эр зориг буурч, нийгмийг тайвшруулахад чиглэгдсэн халамж нэмэгдэж улсын хөгжил саарч уруудаж эхэлнэ.

- Хууль, дүрэм, журам, зааврын ажиллах, хүчин төгөлдөр үйлчлэх боломжийг хааж, хуулийн дагуу үйл ажиллагааг хүлж багладаг.

Хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэх сонирхол буурч эхэлнэ

- Хүчний байгууллага, нийгмийг хянах дарангуйллын бүтцэд хөрөнгө ихээр зарцуулагдах, тэднийг өөрсдийн мэдэлд авах өрсөлдөөн ил, далд ихсэнэ.

– Хууль, хяналтын байгууллагуудын нэр хүнд унана.

Авлигатай тэмцэх гэсэн хууль хяналтын байгууллагын нэр хүндийг авлигад автсан ашиг сонирхлын зөрчил бүхий бүлэглэл унагаах ажил эрчимжиж хурдыг нь сааруулахад чиглэгдсэн үйл ажиллагаа эрчимжинэ. Хууль хяналтын байгууллага авлигад автана. Хууль хяналтын байгууллагын ажилтнуудын тавьсан шаардлагыг иргэд биелүүлэхээ болино.

- Асуудлыг хуулийн дагуу бус хууль бусаар, хүч хэрэглэх замаар шийдэх нь ихсэнэ.

Нийгэмд ард түмний ирээдүйдээ итгэх итгэл багасч, баян хоосны ялгаа илт нэмэгдэж нийгмийг хамарсан шүүмжлэл өрнөж бухимдал нэмэгдэнэ. Ядуурал ихсэж, улс оронд нийгмийг хамарсан эмх замбараагүй байдал бий болно.

Харилцагчдаас бэлэг сэлт, урилга хүлээн авах

Авлига, хээл хахууль, шан харамж, бэлэг юугаараа ялгаатай вэ?

Авлига: Хээл хахууль, шан харамж, хууль бус бэлэг түүнчлэн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэх зэрэг хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүйн цогц нийгмийн үзэгдэл.

Хээл хахууль өгөх нь: Өөртөө болон бусдад давуу байдал бий болгох зорилгоор нийтийн албан тушаалтан, гадаад улсын төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтанд албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан эдийн болон эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн, төлбөргүй эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн, эсхүл тэдгээрийг амласан, санал болгож буй үйлдэл.

Шан харамж: Албан тушаалтан хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн эсхүл зохих ёсоор хэрэгжүүлээгүйн төлөө бусдаас мөнгө бусад эд зүйл, хөнгөлөлт, төлбөргүй үйлчилгээ авч байгаа үйлдэл

Бэлэг: Албан тушаалтан албан ажилтайгаа холбогдуулан бусдаас мөнгө, эд зүйл үнэ төлбөргүй шилжүүлэн авч буй үйлдэл. Хэрэв албан тушаалтан тухайн албан тушаалыг хашиж байгаагүй бол бэлэг авахгүй байсан.

МӨНГӨ УГААХ ГЭЖ ЮУ ВЭ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд “мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ гэж томъёолсон байдаг.

Гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувиргаж эдийн засгийн эргэлтэд оруулж “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлого нь мөнгө угаах гэмт хэрэг юм.

Гэмт хэрэгтнүүд их хэмжээний бэлэн мөнгийг дараах хууль бус үйл ажиллагаанаас олдог бөгөөд мөнгө угаах гэмт хэргийн үндэс болдог. Үүнд:

- Хууль бус галт зэвсгийн наймаа;
- Хүний, эд эрхтний наймаа;
- Хар тамхины худалдаа;
- Эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх;
- Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх;
- Авлига, хээл хахууль;
- Татвараас зайлсхийх;
- Байгаль орчны эсрэг, гэмт хэрэг;
- Хулгай, дээрэм;
- Цахим гэмт хэргийн хохирогчоос шаардаж авсан барьцаа төлбөр, далд веб дэх хууль бус үйл ажиллагааны төлбөр болгож биткойн, этериум зэрэг криптовалютуудаар олсон орлого гэх мэт.

Суурь гэмт хэргийг үйлдэж олсон хууль бус орлогыг гэмт хэрэгтнүүд бэлэн мөнгө хэлбэрээр хадгалах нь дараах “эрсдэлүүдийг” дагуулдаг:

- Их хэмжээгээр тээвэрлэх, хадгалахад хүндрэлтэй;
- Сэжиг төрүүлэхгүйгээр зарцуулахад хүндрэлтэй;
- Хулгай, дээрэмд өртөж болзошгүй;
- Их хэмжээгээр олдсон тохиолдолд сэжиг төрүүлнэ.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ҮЕ ШАТУУД

Гэмт хэрэгтнүүд хууль бус орлогоо нуун далдлах зорилгоор дараах үе шатыг дамждаг:

1. Байршуулах /Placement/

Мөнгө угаахад хамгийн эхний бөгөөд хамгийн эгзэгтэй үе шат нь байршуулалт юм. Учир нь энэ үе шатын гол зорилго нь их хэмжээний бэлэн мөнгийг өөртөө хадгалах нь хүндрэлтэй тул мэдээлэх үүрэгтэй этгээд эсвэл хууль хяналтын байгууллагын анхаарлыг таталгүйгээр санхүүгийн системд нэвтрүүлж, хууль бусаар олсон мөнгөний анхны эх үүсвэрээс “салах” явдал юм. Үүнд:

- Их дүнтэй мөнгийг мэдээлэх үүрэгтэй хүргэхээс сэргийлж бага дүнтэй хэсгүүдэд этгээд СМА-д цааш мэдээлэх хэмжээнд хувааж санхүүгийн системд нэвтрүүлэх;

- Мэдээлэх хэмжээнд хүргэхээс сэргийлж мөнгийг бага багаар гадаад валютад хөрвүүлэх;
- Бэлэн мөнгийг мэдээлэх хэмжээнд хүргэлгүй бага хэмжээгээр өөр улс руу биетээр зөөвөрлөх;
- Хууль бусаар олсон мөнгөөр зээлийн төлбөрөө төлөх;
- Хууль ёсны орлоготой “бохир” мөнгийг хольж санхүүгийн системд нэвтрүүлэх;

- Хуурамчаар нэхэмжлэл үйлдэх;
- Мөнгийг оффшор банкинд байршуулах;
- “Бохир” мөнгөөр үнэт цаас худалдан авах г.м.

2. Нуун далдлах /Layering/

Мөнгө угаах хоёрдугаар үе шат нь хууль бусаар олсон хөрөнгийг жинхэнэ эх үүсвэрээс нь холдуулах, төөрөгдүүлэх зорилгоор эргэлзээ төрүүлж, хөрөнгийг олон төрлийн ээдрээтэй гүйлгээ хийж санхүүгийн системийн эргэн тойронд эргэлдүүлэх үйл явц юм. Энэ үе шат нь хамгийн нарийн түвэгтэй ба мөнгөний жинхэнэ үүсвэрийг олж илрүүлэхэд хүндрэлтэй болгож “бохир” мөнгөний зүсийг хувиргаснаар жинхэнэ эх үүсвэрээр хөрөнгийг аль болох холдуулж өгөх зорилгоор хэд хэдэн улсуудаар дамжуулж хөрөнгийг эргэлдүүлдэг. Үүнд:

- Бэлэн мөнгийг санхүүгийн хэрэглүүрт шилжүүлэх;
- Өөр өөр дансуудаар дамжуулан олон удаагийн олон төрлийн гүйлгээг хийж төөрөгдөл үүсгэх;
- Хөрөнгийг оншор болон оффшор дансууд руу шилжүүлэх;
- “Бохир” мөнгөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авч түүнийг тухайн улс оронд, эсвэл гадаад улсад эргүүлж борлуулах;
- “Бохир” мөнгийг цахим мөнгөнд шилжүүлж гуйвуулга хийх г.м.

3. Буцаан төвлөрүүлэх /Integration/

Мөнгө угаах гэмт хэргийн эцсийн зорилго нь нийлүүлэлт буюу буцаан төвлөрүүлэлт юм. Гэмт хэрэгтнүүд хууль бусаар олсон хөрөнгийг санхүүгийн системд нэвтрүүлээд нуун далдлах үе шатын дараа буцаан төвлөрүүлэх үе шат руу шилжүүлэх ба энэ үед нэмэлт гүйлгээнүүдийг хийх замаар хөрөнгийг хууль ёсны мэт харагдуулахыг зорьдог. Эдгээр гүйлгээнүүд нь гэмт хэрэгтэнд хууль ёсны харагдахуйц тайлбар хэлэх боломжийг олгодог ба цаашид хөрөнгийн анхны эх үүсвэртэй холбогдохоос сэргийлдэг. Өөрөөр хэлбэл энэ шатанд “угаасан” мөнгийг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого мэт харагдуулахыг зорино. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгө худалдан авах
- Бизнес худалдан авах
- Үнэтэй машин, үнэт эдлэл зэрэг тансаг хэрэглээний бараа, бүтээгдэхүүн худалдан авах
- Биетээр оршдоггүй, хуурамч байгууллагын” ажилтнуудын” цалинг авах г.м.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖ

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 6 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэргийн шинжийг дараах байдлаар тусгасан. Үүнд:

а) Санаатай үйлдэх гэмт үйлдлийн хэлбэр:

- Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл эрх зүйн үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх;
- Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах санаатай үйлдэл;

б) Гэмт этгээдийн хувьд:

- Тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах;
- Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөгөө өгөх гэж тодорхойлсон.

“Эд хөрөнгө” гэдгийг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 2 дугаар зүйлд “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, биет эсвэл биет бус бүх төрлийн эд хөрөнгө хамаарах болон тэдгээр эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг нотлох хууль зүйн баримт бичиг, хэрэгсэл” гэж тодорхойлсон.

Монгол Улсын Эрүүгийн хуульд:

Эрүүгийн хууль дахь мөнгө угаах гэмт хэргийн шинж
18.6 дугаар зүйл Мөнгө угаах гэмт хэрэг
Объектив шинж
<ul style="list-style-type: none"> - Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; - Түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах, зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; - Түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан үйлдэл, эс үйлдэхүй байна.
Хүндрүүлэх нөхцөл
<ul style="list-style-type: none"> - Энэ гэмт хэргийн Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж; - Байнга тогтвортой үйлдэж; - Албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн; - Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн;

- Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн үйлдэл, эс үйлдэхүй байна.
Хөөн хэлэлцэх хугацаа
- Үндсэн гэмт хэрэгт: 1 жил - Хүндрүүлэх нөхцөлтэй гэмт хэрэгт: 5 жил - Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол: 12 жил

Мөнгө угаах гэмт хэргийг Монгол Улсад хянан шийдвэрлэж буй шүүхийн практик

Шүүн таслах үйл ажиллагааны статистик мэдээллээс үзэхэд 2008-2018 оны хугацаанд шүүхээс мөнгө угаах 5 гэмт хэрэг хянан шийдвэрлэж, 12 хүнд ял оногдуулжээ.

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭЖ ЮУ ВЭ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд “терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист байгууллага, террорист хүн, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг хэлнэ гэж томъёолсон байдаг. Өөрөөр хэлбэл террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх, үүнтэй холбоотой байх магадлалтай гүйлгээ хийхийг терроризмыг санхүүжүүлэх гэж нэрлэдэг.

Мөнгө угаах үйл ажиллагааны гол сэдэл нь гэмт хэрэг үйлдэж ашиг хонжоо эрэлхийлэх байхад, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн сэдэл нь үзэл сурталтай шууд холбоотой ба энэ нь шашин шүтлэг, улс төр, өш хонзон, бэлэг тэмдгийн аль нэг нь байдаг. Террорист үйл ажиллагаа нь хүний амь насыг санаатай бүрэлгэх, үй олноор хөнөөх, хүн барьцаалах, гэмтээх, түүх, соёлын үнэт өвийг санаатай хорлон сүйтгэх замаар төр засаг болоод олон улсын байгууллагыг аливаа нэг үйлдэл хийлгэхгүй байх тактик юм.

Террористууд өөрсдийн үйл ажиллагааг хууль бус болон хууль ёсны эх үүсвэрээр аль алианаар нь санхүүжүүлдэг:

- Хууль бус санхүүжилтийн эх үүсвэр:

Айлган сүрдүүлэх замаар мөнгө дээрэмдэх, хүн барьцаалж мөнгө нэхэх, хүний наймаа, хар тамхины худалдаа зэрэг хууль бус үйлдлүүд нь санхүүжилтийг томоохон эх үүсвэр болдог. Хууль бусаар улс дамжиж бараа тээвэрлэж дамжуулах, залилан, хулгай дээрэм хийх, хувийн мэдээллийг хулгайлж мөнгө нэхэх, хууль бусаар алмаз олборлох, хандив, тусламжийн хөрөнгийг зүй бусаар ашиглах зэрэг үйл ажиллагаануудыг мөн дурдаж болно.

- Хууль ёсны санхүүжилтийн эх үүсвэр:

Хууль ёсны санхүүжилтийн эх үүсвэрийг гадны улс орнуудын төр засгаас өгсөн хандив, тусламж, бизнес болон хувиараа хөдөлмөр эрхэлж олсон хууль ёсны орлого зэргүүд бүрдүүлнэ. Харамсалтай нь хандивлагчид өөрийн хандивласан хөрөнгийг терроризмыг дэмжсэн үйл ажиллагаанд чиглэгдсэн талаар мэдэхгүй

өнгөрөх тохиолдлууд гардаг. Хууль ёсны байгууллагууд мөн л террорист байгууллагуудыг санхүүжүүлсэн тохиолдлууд гардаг.

Уламжлалт мөнгө угаагч болон терроризмыг санхүүжүүлэгч хоёрын үйл ажиллагааны сэдэл ялгаатай хэдий ч арга зам нь ижилхэн эсвэл ижил төстэй байх магадлалтай. Жишээлбэл, терроризмыг санхүүжүүлэгчид валютыг хууль бусаар улс орон дамжиж зөөвөрлөх, олон төрлийн санхүүгийн хэрэглүүр болон үнэт цаасны худалдан авах, дебит болон кредит картууд,

хөрөнгийн шилжүүлэг зэрэг аргуудыг ашигладаг. Түүнчлэн хавала, хунди зэрэг “газар доорхи”, албан бус шилжүүлгийн зарим төрлүүд терроризмтой холбоотой хөрөнгийг шилжүүлэхэд үүрэг оролцоотой байсаар байна. “Хавалагаар” дамжуулсан шилжүүлэг нь бичиг баримт, хэмжээ болон гүйлгээний утга зэрэг мэдээлэл дутагдалтай, мөнгөний брокеруудаар дамждаг учир олж илрүүлэхэд хүндрэлтэй.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргүүдийн ялгаа:

	Мөнгө угаах	Терроризмыг санхүүжүүлэх
Сэдэл	Ашиг хонжоо	Үзэл суртал
Эх үүсвэр	Голдуу хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого	Хууль ёсны болон хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого аль аль нь байх боломжтой
Хэмжээ	Их дүнтэй	Ихэвчлэн бага дүнтэй
Арга хэлбэр	Нуун далдлах арга техникүүдийг ашиглаж хөрөнгийг жинхэнэ эх үүсвэрээс нь холдуулах бүх арга хэмжээг авах	Голдуу албан бус шилжүүлэг, гадаад валют арилжааны төвүүдийг ашиглаж эцсийн хэрэглэгч рүү мөнгийг чиглүүлэх
Эцсийн зорилго	“Бохир” мөнгийг угааж хууль ёсны санхүүгийн системд нийлүүлэх	Террорист үйл ажиллагааг дэмжих
Хөрөнгийн урсгал	Дугуй буюу хөрөнгө анхны эзэндээ эргэж очно	Шугаман буюу хөрөнгө анхны эзэн рүүгээ эргэж ирэхгүй

Иймд гэмт хэрэгтнүүд хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогоо мэдээлэх үүрэгтэй этгээд эсвэл, хууль хяналтын байгууллагын анхаарлыг татаж, тэдний хараанд өртөлгүйгээр зарцуулах боломжтой болохын тулд санхүүгийн системд нэвтрүүлж, жинхэнэ эх үүсвэрийг нь нуун дарагдуулж, төөрөгдүүлэх замаар хууль ёсны орлого мэт харагдуулахыг зорино.

ОЛОН УЛС ДАХЬ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУД

МУТС гэмт хэргүүд нь дэлхий нийтийн эрх ашигт нөлөөлөх эрсдэлтэй олон улсын асуудал учир үүнтэй тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаа амин чухал юм.

- Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага /ФАТФ/

Мөнгө угаах гэмт хэрэг олноор бүртгэгдэж эхэлсэнтэй холбогдуулан Франц улсын Парис хотод болсон Их 7-гийн уулзалтаар уг төрлийн гэмт хэрэгтэй олон улсын төвшинд тэмцэх зорилгоор ФАТФ-ыг 1989 онд үүсгэн байгуулсан. 2000-аад оны эхэнд гарсан террорист халдлагын улмаас уг төрлийн гэмт хэрэгт өгөх ач холбогдол нэмэгдэж мөнгө угаах гэмт хэргийг терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбож хэрэглэх болжээ. ФАТФ нь МУТСТ бодлогыг боловсруулдаг Засгийн газар хоорондын байгууллага ба МУТСТ олон улсын стандартыг тогтоож өгч 40 зөвлөмжийг боловсруулан гаргасан. Иймд улс орнууд эдгээр зөвлөмжийг мөрдөх шаардлагатай юм.

- Базелийн хороо

Базелийн хороо нь төв банкнуудын төлөөллөөс бүрдсэн олон улсын байгууллага ба үүний гол зорилго нь дэлхий дахинд үйл ажиллагаа явуулж буй банкуудын хяналт зохицуулалтыг сайжруулах замаар санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх юм.

- Вольфсбергийн групп

Санхүүгийн гэмт хэргүүдийн эрсдэлүүдийг удирдахад туслах, харилцагчийг таних, МУТСТ механизмуудыг сайжруулах зорилготой байгуулагдсан ба нийт 13 банкны төлөөллөөс бүрдсэн.

- Эгмонтын групп

Энэ нь санхүүгийн мэдээллийн албадуудын мэргэжлийн байгууллага бөгөөд мэдээлэл солилцох, сургалт семинар зохион байгуулах, туршлага солилцох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

- Ази, номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг

ФАТФ-тай төсөөтэй байгууллага ба Ази Номхон далайн бүсийн улс орнууд үүсгэн байгуулжээ. Уг бүлэгт Монгол улс 2004 онд гишүүн орноор элсэн орсон.

- НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл

Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах зорилготой уг зөвлөл нь 15 гишүүн оронтой ба зөвлөлийн гишүүн бус 60 гишүүн орнуудтай. Уг зөвлөл нь НҮБ-ыг төлөөлж цөмийн, химийн болон биологийн зэвсэг хэрэглэх аюултай орнуудын эсрэг террорист байгууллага, этгээдийн дансыг царцаах, тэдгээртэй харилцаа холбоогоо таслах, тэдгээрийн нэр дээрх гүйлгээг түдгэлзүүлэх арга хэмжээ авахыг шаардсан тогтоолуудыг гаргадаг ба Монгол Улс гишүүн улс учир дагаж мөрдөх шаардлагатай.

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭТГЭЭД

2006 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн Монгол Улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай анхны хуулийг олон улсын жишиг нийцүүлэх зорилгоор 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр шинэчлэн найруулсан.

Тус хуулийн хүрээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Монгол улсын хэмжээнд зохион байгуулдаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй дараах байгууллага байдаг. Үүнд:

- | | |
|--|---|
| 1/ Мэдээлэх үүрэгтэй этгээд | 6/ Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах байгууллага |
| 2/ Санхүүгийн мэдээллийн алба | 7/ Мөнгө угаах гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавих прокурор, хэрэг хянан шийдвэрлэх шүүх. |
| 3/ Санхүүгийн зохицуулах хороо | |
| 4/ Монголбанк | |
| 5/ Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд | |

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу хяналт тавих дор дурдсан хүн, хуулийн этгээдийг сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг СМА-д мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:

1. банк;
2. банк бус санхүүгийн байгууллага;
3. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
4. хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;
5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
6. хадгаламж, зээлийн хоршоо;
7. харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;
9. нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчийн нэрийн өмнөөс дараах ажиллагааг хийсэн бол:
 - 9.а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
 - 9.б. харилцагчийн хөрөнгийг удирдах;
 - 9.в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;

9.г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;

9.д.хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь МУТСТ тухай хуульд зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Харилцагчийг таньж мэдэх
2. Харилцагч МУТСТ тухай хуульд заасан мэдээлэл өгөхөөс татгалзвал түүнд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах
3. Харилцагчийн гүйлгээнд тусгайлан хяналт тавих
4. 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.
5. Батлагдсан журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад гаргаж өгөх
6. Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах
7. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр баталж, мөрдүүлэх
8. хуульд заасан бусад

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

СМА нь энэ хуулийн мэдээлэх үүрэгтэй этгээд холбогдох мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага байна. СМА нь Монголбанкны дэргэд ажиллана. СМА-нд бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт шалгалт хийх, санхүүгийн лавлагаа гаргуулж эрх бүхий хууль сахиулах байгууллагын төлөөллийг ажиллуулна.

СМА нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх;
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх, шилжүүлсэн сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;
3. Сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар ирүүлсэн мэдээллийн дагуу авсан арга хэмжээний тухай мэдээлэх үүрэгтэй этгээд болон эрх бүхий хууль сахиулах байгууллагад тухай бүр мэдээлэх;
4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;
5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах;
6. Хориг арга хэмжээний жагсаалтыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;
7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх;
8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;
9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах.

СМА-ны чиг үүргийг тус албаны хянан шалгагч нар хэрэгжүүлэх бөгөөд хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд дараах бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1/ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, илэрсэн зөрчлийг арилгахыг мэдээлэх үүрэгтэй этгээдээс шаардах;

2/ эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах буюу тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгуулах талаар санал боловсруулж эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх;

3/ СМА-ны дарга, ажилтан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэл, хилээр нэвтэрсэн тухай бүртгэл, хөрөнгө оруулалтын бүртгэл, банк санхүүгийн байгууллагын хоорондын гүйлгээний бүртгэлийн лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулж авах эрхтэй.

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ

Мэдээлэх үүрэгтэй этгээд буюу дараах байгууллага МУТСТ тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг СЗХ, СМА-тай хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:

1. банк бус санхүүгийн байгууллага;
2. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
3. хөрөнгө оруулалтын сан;
4. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
5. хадгаламж, зээлийн хоршоо;
6. үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;

МУТСТ тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг хүрээнд СЗХ, СМА дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн удирдлага, үйл ажиллагаанд шууд ба шууд бус байдлаар оролцох, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шалгуурыг бий болгох;
2. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт хийх;
3. МУТСТ тухай хуульд заасан үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэх үүрэгтэй этгээдэд холбогдуулж заавар, дүрэм, журам, удирдамж, зөвлөмж гаргах;
4. Эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, тусалцаа үзүүлэх;
5. Сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тохирсон стандарт, шалгуурыг СМА эрх бүхий

байгууллагатай хамтран боловсруулах;

6. Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч байгаа арга хэмжээ болон хариуцлагын талаарх статистик мэдээг нийтэд түгээх.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ

СМА-ны дэргэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны зөвлөл ажиллана. Хамтын ажиллагааны зөвлөлд

1/ гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

2/ санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

3/ хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,

4/ прокурорын байгууллага,

5/ Монголбанк,

6/ Санхүүгийн зохицуулах хороо,

7/ Цагдаагийн ерөнхий газар

8/ Тагнуулын ерөнхий газар

9/ Авлигатай тэмцэх газар

10/ Гаалийн байгууллага,

11/ СМА-ны төлөөлөл ажиллана.

Шүгэл үлээх тогтолцоо

Хувийн хэвшлийн болон төрийн байгууллага дотооддоо хууль бус, дүрэм журмаа зөрчсөн үйл явдалтай тэмцэх нь хүн бүрийн үүрэг юм. Зөвхөн, бодитой, баримттай мэдээлэлд суурилж тухайн зөрчлийг засаж, зогсоодог. Үүнийг бий болгоход нөлөөлөх нэг хүчин зүйл бол шүгэл үлээх тогтолцоо.

Америкийн иргэний эрхийн төлөө тэмцэгчдийн нэг Ralf Nader 1972 онд шүлэгч үлээгч буюу “whistleblow” гэсэн нэр товъёог эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн байгууллагын эсрэг хүчтэй дуугарч, асуудалд нийгмийн анхаарлыг чиглүүлж байгаа хүнийг шүгэл үлээгч гэх утгаар хэрэглэж эхэлсэн байна.

Энэ үг нь “нууц мэдээлэгч”, “матаач” гэсэн үгнээс эрс өөр ойлголт. Матаач¹⁵ гэдэг нь бусдыг далдуур матаан муучилдаг хүнийг хэлдэг. Нууц мэдээлэгч гэдэг нь ихэвчлэн гэмт хэрэг илрүүлэхэд ашигладаг ойлголт юм.

Харин шүгэл үлээгч нь олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зүйл бус, шударга бус үйлдэлтэй тэмцэж байдаг.

Хувийн хэвшлийн байгууллагад эзэмшигчид болон эздийн хөрөнгийг хууль бусаар зарцуулж, үрэгдүүлэхтэй тэмцэх нэг арга нь шүгэл үлээх тогтолцоо.

Олон улсын судалгаанаас үзэхэд¹⁶ хувийн хэвшлийн салбарт үйлдэгдсэн луйврын хэргийн 45 хувийг салбар дотроос мэдээлсэн мэдээлэлд тулгуурлан илрүүлсэн байдаг. Зохисгүй үйлдэл, гэмт үйлдлийг дотооддоо мэдээлэх буюу шүгэл үлээх боломжийг бүрдүүлж, хөхиүлэн дэмжихийн чухлыг эндээс харж болно.

Шүгэл үлээх тогтолцоог зөвөөр хэвшүүлэхийн сайн тал:

- Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх
- Санхүүгийн луйвраас урьдчилан сэргийлэх
- Зүй бус үйлдлийг өөгшүүлэхгүй байх

Шүгэл үлээсэн ажилтанг хамгаалах тогтолцоогүй байгууллагад учирах эрсдэл:

- Зүй бус үйлдэлтэй тэмцсэн ажилтан гадуурхагдах, ажлаасаа халагдах
- Компани дотор болж байгаа шударга бус аливаа явдалтай тэмцвэл хохирдог гэсэн ойлголт нэмэгдсэнээр ажилтнууд хууль бус үйлдлийг хараагүй мэт өнгөрүүлж, улмаар тэр үйлдэлд нь татагдах орох
- Ажилтнууд гадны нөлөөнд орох эрсдэл нэмэгдэж улмаар бизнесийн нууц алдагдахад хүрэх
- Гадаад, дотоод түншүүдийн итгэлцэл буурах
- Компанийн хөрөнгийг зүй бусаар зарцуулах нь нэмэгдэж улмаар алдагдалд орох

Шүгэл үлээх” нь тухайн хүний хувьд иргэний зориг юм.

Төр, хувийн хэвшил, ашгийн бус салбарыг хамарсан эрх зүйн цогц орчинг бий болгох нь нэн үр нөлөөтэй

- Хууль сахиулалт чухал.
- Шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангасан байх ёстой.
- Дотооддоо болон гадагш мэдээлэхийг хамгаалж, нууцлалыг хангасан байх ёстой.
- Үнэн шударгаар мэдээлэх зөв орчныг бий болгох үүднээс байгууллагуудад хүчтэй, ил тод дотоод бодлого, мэдээлэх сувгуудыг нэвтрүүлэх хэрэгтэй.
- Мөрдөн шалгах ажиллагааг шударга, хариуцлагатай явуулдаг байх.
- Байгууллагын шүгэл үлээхтэй холбоотой бодлогод ажилтнуудтайгаа сайн харилцаа холбоотой байх, тэдэнтэй зөвлөлдөж байх заалтыг тусгах шаардлагатай.
- Шүгэл үлээлтийг дэмжихэд олон нийтийн оролцоо, дэмжлэг хэрэгтэй.
- Шүгэл үлээснээр олон нийтэд ашигтай, хүртээмжтэй үр шим бий болсон талаар мэдээлэл цуглуулж, нийтэд мэдээлж байх ёстой.

¹⁶ Авлигатай тэмцэх гарын авлага. OSCE. 2016., АТГ.

- Үг хэлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрхийг хангасан нийгэм, эрх зүйн зүй зохистой орчинг бүрдүүлэх, хараат бус хэвлэл мэдээллийг бий болгох шаардлагатай.

Шүгэл үлээх тогтолцоог бий болгоход анхаарах асуудал¹⁷

Нууцлалыг хангах замаар шүгэл үлээгчийг хамгаалах:

Шүгэл үлээгчийн нууцлалыг хангах, хамгаалах асуудал нэн тэргүүнд тавигддаг. Удирдлагын зүгээс байгууллага дотроо мэдээлэгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ил болгохоос хамгаалах зорилгоор арга хэмжээг авч болно. Харин гэмт хэргийн шинжтэй мэдээллийг ил болгохгүй нууцалбал хуулийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Зөрчлийн хуулиас

15.10 дугаар зүйл. Гэмт хэргийг үл мэдээлэх

1. Санаатай хүнд гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэж байгаа, эсхүл үйлдсэнийг лавтай мэдсэн атлаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Шүгэл үлээгч нь тухайн аж ахуйн нэгж болон түүний орчимд үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг өгсөн тохиолдолд энэ нь яваандаа эрх зүйн аливаа шүүн таслах ажиллагааны үед ил болгохоос аргагүй байдалд хүрч улмаар гэрчийг хамгаалах тухай асуудал болж хувирна.

Шүгэл үлээгчийн хэлсэн ярьсан зүйл нь үндэслэлгүй, худал хуурмаг, бусдыг хорлох гэсэн мэдээлэл өгөх эрсдлийг нэмэгдүүлдэг тул асуудлыг олон талаас нягталж үзэх шаардлага зайлшгүй гардаг. Мэдээллийг нягтлахгүйгээр асуудалд хандвал элдэв сөрөг үр дагавар үүсдэг.

Дарамт шахалтаас ангид байх баталгаа:

Байгууллагын удирдлагын зүгээс мэдээллийг нийтэд дэлгэх шаардлага гарсан бол шүлгэл үлээгчид ирэх дарамт, шахалтаас зайлсхийхийн тулд хамгаалах үүрэгтэй. Учир нь шүгэл үлээснийх нь төлөө дарамт шахалтын арга хэмжээ авсан болохыг батлахад нь ажилтанд бэрхшээл тулгарч болно. Иймд шүгэл үлээгээгүй байсан ч дарамт шахалтын арга хэмжээ авсан болохыг ажилтан баталж чадахгүй тохиолдолд ажил олгогчийн зүгээс авсан арга хэмжээг дарамт шахалтын арга хэмжээ гэж үзэхийг зөвлөж байна.

Худал гүтгэлэг:

Өөр нэг асуудал нь хувь хүний эрх, нэр хүндийг худал гүтгэлгээс хамгаалах явдал юм. Тиймээс худал гүтгэлгийг хязгаарлаж, түүний учруулж болох хохирлыг нөхөн барагдуулах тодорхой журмыг хууль тогтоомж, бодлогод тусгах шаардлагатай. Гэвч иргэний нэр төрийг хамгаалах тухай хуулийг дуу хоолойгоо илэрхийлэх гэсэн хүмүүсийг дуугүй болгох гэж ашиглах нь бий. Худал гүтгэлгийн улмаас нэр хүндэд нь

¹⁷ <https://www.iaac.mn/files/6e396b8e-a4cd-41d6-8a42-535892425542/Handbook%20on%20corruption%20combating%20-%20Mon2.pdf> гарын авлагад дурдагдсан мэдээлэлд тулгуурлав.

сэв сууж болзошгүй хүний эрх болон шүгэл үлээгчийн хамгаалалт хоёрын дунд үндэслэл бүхий тэнцвэрийг барьж хадгалж байх нь чухал юм.

Урамшуулал

Шүгэл үлээх соёл нь иргэний үүрэг мөн гэх ёс зүйд тулгуурлан шүгэл үлээх соёлыг урамшуулж болно.

Ажилтнууд байгууллага дотроо буюу дотооддоо нэхэмжлэл үүсгэсэн байсан ч шагнал авах эрхтэй байдаг. Шүгэл үлээхийг шан урамшуулалтай холбож өгснөөр худал гүтгэлэг гаргах, эсхүл өмнө дурдсанчлан авлигын хэмжээ, шагналын дүнг нэмэгдүүлэх үүднээс сэжиг бүхий авлигын үйлдлийг мэдээлэхээ хойшлуулах зэрэг буруу сэдлүүд гарах эрсдэлтэй. Хэдийгээр урамшуулал нь шүгэл үлээлийг дэмжих үр дүнтэй арга мөн боловч үүнийг маш болгоомжтой хэрэгжүүлэх шаардлагатай. Хэрэв хөдөлмөрийн гэрээ, ёс зүйн дүрэмдээ мэдээлэх үүргийг зааж өгөх юм бол урамшууллын систем шаардлагагүй болно.

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

Шударга өрсөлдөөний зохицуулалт яагаад чухал вэ?

Төрийн бодлогын үүднээс авч үзвэл өргөн утгаараа өрсөлдөөнийг зохицуулах бодлого гэдэг нь зах зээл өрсөлдөөнтэй, тэр нь эдийн засгийн үр ашигтай, ямарваа хэлбэрээр хязгаарлагдаагүй эсэх талаар баталгааг бий болгон хангахад чиглэсэн цогц үйл ажиллагаа, хэм хэмжээний нийлбэр цогц юм.¹⁸ Харин явцуу утгаараа, энэ нь тодорхой нэг салбар, бүтээгдэхүүний зах зээл дээр өрсөлдөх үйл явц эрүүл, шударга байх нөхцөлийг хангахад шууд чиглэгдсэн бодлого юм.¹⁹

Орчин үеийн өрсөлдөөний зохицуулалтын бодлого зах зээлийн өрсөлдөөнт тогтоцыг хамгаалахын тулд нэг талаас сахилга батыг сахиулж хуулийг хэрэгжүүлэх, нөгөө талаас аж ахуй эрхлэх эрх чөлөөг олгох, зах зээлийн дерегуляци хийхэд чиглэж байна.²⁰

Өрсөлдөгчийн зүгээс харахад өрсөлдөөний хууль тогтоомж нь төрөл бүрийн хориглолт, хариуцлагыг зааж, өрсөлдөгчийн зах зээлд санал болгосон үнэ тариф, худалдааны арга хэрэгслийг хянан шалгаж, зөрчил торгуулиар сүрдүүлж, томоохон үнийн дүнтэй торгуулийн арга хэмжээнүүдийг аж ахуйн нэгжүүдэд оногдуулдаг хэмээн ойлгогдож, бизнесийн эрх чөлөөнд аюул, занал учруулж буй мэт ойлгогдох нь түгээмэл.

Гэтэл зарим жижиг дунд бизнес эрхлэгч, шинээр тухайн зах зээлд нэвтрэх үед тухайн зах зээлд өрсөлдөж байгаа аж ахуй эрхлэгчид дангаараа болон бусадтай үгсэн хуйвалдаж түүнийг шахан зайлуулах арга хэмжээ авах нь бий. Практикт ийм үйлдлүүд янз бүрээр гардаг бөгөөд жишээ нь бараа бүтээгдэхүүний үнийг бодит өртгөөсөө доогуур болгон бууруулах, эсхүл аж ахуйн хамтын ажиллагаа тогтоохоос үндэслэлгүйгээр татгалзах, үйлдвэрлэлийн орцыг зохиомлоор хомсдуулахаар нийлүүлэгчтэй үгсэх, шинэ өрсөлдөгчийн бүтээгдэхүүний тухай буруу ташаа мэдээлэл тараах гэх мэт олон хэлбэртэй байдаг.

Хэрэглэгчийн хувьд авч үзвэл дээрхээс өөр дүр зураг харагдана. Өрсөлдөөний зохицуулалтын үр дүнд зах зээлд бараа бүтээгдэхүүнээ санал болгож буй хэд хэдэн худалдаалагч зэрэгцэн оршсоноор хэрэглэгч сонголт хийх боломж бүрддэг. Практикт зарим компаниуд бараа бүтээгдэхүүндээ зориуд хүчээр нэмэлт дагалдуулга тулгах замаар хясан боогдуулах зэрэг илт шударга бус байдлуудыг гаргах нь бий. Энэ мэт худалдааны буруу үйлдлүүдийг таслан зогсоох нь хэрэглэгчийн эрхийг хамгаалаад зогсохгүй сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг. Зах зээл дээр хэд хэдэн худалдаалагч нэгэн зэрэг өрсөлдсөнөөр бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчид санал болгохдоо өөрсдийн сав баглаа боодлоос гадна, чанар, хэрэглэгчид хүргэж буй үйлчилгээ, үйлчилгээний соёл, тэднийг татах урлагийг хөгжүүлж, тэрчлэн үнийн хувьд ч хямдруулах, төрөл бүрийн урамшууллаар өрсөлдөх нь бий.

¹⁸Massimo Motta, 'Competition policy: Theory and Practice' (2004) p.30

¹⁹ Youngsoog Na, 'The role of Competition policy in the Economic Development of Korea' PhD dissertation, the Stanford University (2008) p. 51

²⁰ Л.Отгонбаяр "Өрсөлдөөний зохицуулалтын бодлого уян хатан мэдрэмжтэй байх ёстой" ярилцлага.
<http://news.gogo.mn/r/134324>

Гэтэл нөхцөл байдал зарим зах зээлд огтоос өөр байдаг. Тухайлбал, эрчим хүчний салбарыг аваад үзвэл түүхий эдийн эх үүсвэрийн нөөцийн хязгаарлагдмал байдал, түүний өртөг, худалдан авдаг эрэлт хэрэгцээ, дэд бүтэц, технологийн зардал зэргээс хамаарч тэр бүрий олон нийлүүлэгч тухайн зах зээлд үр ашигтай ажиллах боломж хомс байх нь бий. Магадгүй, зах зээлд нэг л нийлүүлэгч ажилласнаар нийгмийн дундаж зардал хамгийн бага байх тохиолдол байдаг. Нэгэнт нэг (монополь зах зээл) болон цөөн нийлүүлэгчтэй (олигополь зах зээл) байгаа үед хэрэглэгчид сонголт тэр хэмжээгээр бага, хараат байх учир хэрэглэгчийн эрх эмзэг байх болно. Ийм нөхцөлд монополь болон давамгайллагчийн үнэ тарифыг төрөөс хянан үзэх зайлшгүй шаардлага үүсдэг. Энэ нь ихэвчлэн монополийн болон өрсөлдөөний тухай хууль тогтоомжоор зохицуулагдана.

Ихэнхи улс орнууд гадаадын хөрөнгө оруулалт эдийн засагт нь чухал ач холбогдолтой гэж үзэн аливаа хөрөнгө оруулагч дотоодын зах зээлд өрсөлдөхөд хууль эрх зүйн төдийгүй бодлогын хувьд адил тэгш нөхцөл шалгуур тавина гэсэн итгэл үнэмшлийг бий болгохыг эрмэлздэг. Үүний тулд өрсөлдөөний хуулийг мөрдүүлдэг.

Эндээс үзвэл, олон улс орнууд өрсөлдөөний хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, улмаар эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна гэж үздэг төдийгүй энэ нь ч өргөн хүрээндээ хэрэглэгчийн нийт сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх үр дүнтэй арга болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг байна.

Анхааралдаа авах шаардлагатайг харуулсан практик үндэслэлүүд

Шударга өрсөлдөөний зохицуулалтыг аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж, бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ тарифийг тогтоох, өрсөлдөөний тактик боловсруулахдаа харгалзан үзэж байх дараах наад захын практик шалтгаанууд байгааг дурьдах нь зүйтэй.

Компанийн нийгмийн хариуцлага, хамтын үнэт зүйлстэй холбогдох нь

Компанийн нийгмийн хариуцлага хэмээх ойлголт нь бизнесийн үйл ажиллагааг ёс зүй, хүний эрх, хууль тогтоомжийг хүндэтгэн сахих, үйлдвэрлэл үйл ажиллагаа нь байгаль орчинд ээлтэй байж тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэхийг хэлнэ.

Орчин үед хэрэглэгчид төдийгүй, хөрөнгө оруулагчид, бизнесийн хамтрагчид зэрэг бизнесийн бүхий л оролцогчид нийгмийн хариуцлагатай байдлыг хамтын үнэт зүйл хэмээн үзэх болсон бөгөөд нийгмийн хариуцлагын үзүүлэлтийг аливаа сонголтынхоо төвд тавьж үзэх болсон.

Хөрөнгө оруулагчдын тухайд шийдвэр гаргахын өмнө тухайн төсөл, аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаа, тайланд мэргэжлийн хүмүүсээр дүн шинжилгээ (due diligence) хийлгэхдээ шударга өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлдэг эсэхэд онцгойлон анхаарал хандуулдаг болсон. Улмаар өрсөлдөөний хууль зөрчиж эрх зүйн хариуцлага хүлээлгэж байсан эсэхийг, бизнесийн хэлцэл хийх болон үнэ тарифын бодлого, шийдвэр батлахдаа шударга өрсөлдөөнд нийцтэй эсэх талаар мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах процедур мөрдөж ажилладаг эсэхэд үнэлэлт дүгнэлт өгдөг.

Олон улсын Стандартын байгууллагаас албан ёсоор нийтэлсэн “Нийгмийн хариуцлагын стандарт 26000” баримт бичгийн 6.6.5-д бизнесийн үйл ажиллагаа,

шийдвэрүүд нь шударга өрсөлдөөний бүхий л зарчмууд, холбогдох хуульд нийцсэн байх нь зохилтойг заасан билээ.

Хамгийн өндөр торгуультай зөрчил

Өрсөлдөөний тухай хуулийг зөрчигсдөд хүлээлгэх нь Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага нь тус хуульд заасан бусад зөрчлүүдэд хүлээлгэхээр заасан зөрчлүүдтэй харьцуулж үзвэл үлэмж өндөр хэмжээ бүхий торгуультай байна.

Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн болон Эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Зөрчлийн тухай хуулийн 10.7-д Өрсөлдөөний хуулийг зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагыг тодорхойлохдоо аж ахуй нэгжийг “хууль бусаар олсон хөрөнгө, орлого, эд зүйлийг хураах”, “тухайн бараа, бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын 6 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”, “өмнөх жилийн борлуулалтын орлогын 4 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”, “таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”, “өмнөх жилийн борлуулалтын орлогын 3 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”-оор заасан бол хувь хүнийг “таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох” гэж тус тус заажээ.²¹

Гэмт хэргээс сэргийлэх

Өрсөлдөөний хуульд заасан хэм хэмжээг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, зах зээлд өрсөлдөгчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлэх, нийтийн эрх ашиг хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоогчийн зүгээс шударга бус өрсөлдөх зарим ноцтой үйлдлүүдийг гэмт хэрэг болохыг хуульчлан заасан.

Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д зах зээл дэх давамгайл, монополь байдлаа өрсөлдөөний хуулийг зөрчиж ашиглах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, түүнийг зөрчсөн аж ахуй эрхлэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байдаг. Үүнд:

“1.Зах зээл дэх өрсөлдөөнийг хязгаарлах, устгах зорилгоор зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч, давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчид үгсэн хуйвалдах хэлцэл хийж зохиомлоор бараа, бүтээгдэхүүний хомсдол бий болгосон, бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг зогсоосон, хэмжээг хязгаарласан, бараа, бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоосон; бусад аж ахуй эрхлэгч зах зээлд гарч ирэхэд саад учруулах, түүнийг зах зээлээс шахан гаргах зорилгоор бараа, бүтээгдэхүүнээ бодит зардлаас доогуур үнээр зарж борлуулсан; өрсөлдөгч аж ахуйн нэгж, иргэний аж ахуйн үйл ажиллагааг зах зээлд оруулахгүй хясан боогдуулж бусдад их хэмжээний хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

²¹ Зөрчлийн тухай хууль (2017) <https://www.legalinfo.mn/law/details/12695?lawid=12695>

2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”²²

Өрсөлдөөний хуулийн зохицуулалт, тулгуур ойлголтуудын тойм

Дэлхий дээр өрсөлдөөний хуулийг одоогоор 120 гаруй улс орнууд батлан хэрэгжүүлдэг болоод байна.²³ Улс орнуудын өрсөлдөөний хууль тогтоомжийг хөгжүүлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагаа, мэдлэг солилцоог дэмжиж ажилладаг Эдийн Засгийн Хөгжил, Хамтын Ажиллагааны Байгууллага (OECD), НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD) байгууллагуудын соён гэгээрүүлэх үйл ажиллагаануудын үр дүнд өрсөлдөөний эрх зүй олон улсын нийтлэг жишиг болон хөгжиж байгаа бөгөөд энэ төрлийн хуулиудын зохицуулалтын агуулга ерөнхийдөө ижил төстэй байгаагаар энэ нь илэрнэ.

Өрсөлдөөний зохицуулалтын зүйлийн ерөнхий агуулгыг дараах үндсэн системд авч үзэж болох юм. Үүнд:

- Өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ хэлцлүүд
- Монополь болон давамгайл байдлаа хууль бусаар ашиглах үйлдлүүд
- Компаниудын нэгдэж нийлэх ажиллагаа
- Өрсөлдөөнийг хязгаарлах үр дагавар бүхий төрийн оролцоо

Өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ, хэлцлүүд нь хэвтээ болон босоо түвшний хэлцэл хэмээн хоёр төрөлд хуваагддаг. Энд гэрээ хэлцэл гэдэгт зөвхөн бичгээр хийсэн гэрээ хэлцлийг хамааруулахаас гадна өрсөлдөгч нарын хооронд хийгдсэн аман тохиролцоо, “жентелмэнүүдийн тохироо”-г багтааж авч үздэг жишиг бий.

Өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ хэлцлийн төрлүүдэд тендерт хуйвалдаж орох, үнийг тодорхой түвшинд барих тухай тохиролцоо, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тодорхойлох, зах зээлээ хувааж авах, аливаа нэг этгээдэд борлуулалт хийхээс татгалзах, худалдааны иж бүрдэлд бараа үйлчилгээг дагалдуулдаг байхаар хамсан тохиролцоо, мэдээлэл солилцооны гэрээ гэх мэт олон төрлийн хэлцлүүд хамаарагдах бөгөөд эдгээр нь хуулиар хориглогддог бөгөөд маш өндөр торгуультай байдаг. Энэхүү хууль бус үйл ажиллагааг байнга хэрэгжүүлдэг зохион байгуулалтыг картель гэж нэрлэдэг.

Хэвтээ хэлцэл гэдэгт нэгэн ижил бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл дээр өрсөлдөж буй аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдсэн тохиролцоог хэлнэ.

Босоо хэлцэл гэж тодорхой бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний түүхий эд ханган нийлүүлэгч, үйлдвэрлэл, технологи, борлуулалтын өөр өөр түвшинд оролцож буй аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулагдаж байгаа хэлцлийг ойлгоно.

Эдгээр хэвтээ ба босоо хэлцлүүдээр дамжин өрсөлдөгч нар төрөл бүрийн тохиролцоог хийх нь практикт шалгагдан, туршигдсан байдаг. Тухайлбал, нэг зах зээл дээр өрсөлдөж байгаа хоёр үүрэн телефон холбооны оператор компани үгсэн хуйвалдаж тус тусын үйлчилгээний үнээ нэмэгдүүлэх замаар илүү их ашиг олохоор тохиролцсон бол энэ нь хэвтээ хэлбэрийн өрсөлдөөнд харш гэрээ болно. Харин босоо хэлбэрийн

²² Эрүүгийн хууль (2015) <https://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

²³ R.Wish and David Bailey 'Competition Law' (Oxford University Press, 7th edition) 2012, p1

хэлцлийн жишээ гэхэд, барилгын арматур төмөр үйлдвэрлэгч нь бөөнөөр худалдаалагчтай үгсэн хэлцэж, өөрийн байгуулсан “А” барилга угсралтын компанидаа илт хямд арматур худалдаж, түүнийхээ алдагдлыг өрсөлдөгч барилга угсралтын “Б” компанид нийлүүлэх арматур төмрийн үнэнд шингээн илүү үнэтэйгээр нийлүүлэх замаар өртгийн хувьд ялгаа үүсгэнэ. Ингэснээр бэлэн болсон орон сууцны борлуулах үнэ “А” болон “Б” компаниудад шударга бусаар өөр болох нөхцөл бүрдэнэ.

Монополь болон давамгай байдлаа хууль бусаар ашиглах тухай зохицуулалт нь өрсөлдөөний хуультай бүх улс орнуудад байдаг. Монополь болон давамгай байдалтай аж ахуйн нэгжийг онцгойлон авч үзэхийн учир нь тэдгээр нь зах зээлд асар их хүчтэй байдаг бөгөөд тэдгээрийн аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь бусад өрсөлдөгчид хүчтэй нөлөө үзүүлэх боломжтой байдаг.

Зүй ёсны монополь гэдэг нь зах зээлд зөвхөн нэг үйлдвэрлэгч байхад л бүтээгдэхүүний нэгжийн боломжит өртөг нь хамгийн бага байх нөхцөлд үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг хэлнэ.²⁴

Давамгай байдал гэдэг нь тухайн зах зээлд давамгайлж, тухайн зах зээлд өөр этгээд нэвтрэх болон тухайн зах зээлийн үнэд хүчтэй нөлөө үзүүлэх бололцоотой байхыг хэлнэ. Давамгай байдлыг тодорхойлохдоо тухайн зах зээлийн төвлөрлийг шинжлэн үзэх ННН Index, Learners Index –үүдийг ашигладаг. Мөн хууль тогтоомжийн зохицуулалтыг харгалзан үзэх шаардлага гарна.

Зах зээлд давамгай байдалтай эсэхийг тодорхойлохын тулд өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллага аж ахуйн нэгж зах зээлд хяналт тавьж чадах эсэхийг тогтоох хэд хэдэн тодорхой хүчин зүйлийг авч үзэх хэрэгтэй. Эдгээрт:

- Зах зээлд эзлэх хувь
- Зах зээлд нэвтрэх саадын шинж чанар ба хэмжээ
- Импортын өрсөлдөөний хэмжээ (бодит ба боломжит)
- Бараа, үйлчилгээний худалдан авагчдын зүгээс үзүүлэх эсэргүүцэх чадварын хэмжээ
- Зах зээлд жижиг компаниудын зүгээс үзүүлэх хүчтэй өрсөлдөөн
- Зах зээлд гадаадын шууд хөрөнгө оруулалтанд үзүүлэх саад.²⁵

Компаниудын нэгдэж нийлэх ажиллагаа зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд нэгдэх, нийлэх үйл явц бол эдийн засгийн амьдралын хэвийн үзэгдэл. Энэхүү процесс нь хэвтээ, босоо түвшинд, мөн групп үүсгэх зэрэг хэлбэрүүдтэй.

Нэгдэх процесс нь өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэхүйц байх нь бий. Иймээс зарим төрлийн нэгдлийг өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллагаас хянан үздэг. Ийнхүү хянан үзэх гол шалтгаан нь өрсөлдөөнд үзүүлэх нөлөөллийг хянан шинжлэх, болзошгүй төвлөрлөөс зайлсхийх, нэгдсэний дараа нийгэмд болон хэрэглэгчдэд ямар нөлөөлөл үзүүлэхийг шинжлэн үзсэний үндсэн дээр зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэдэг. Мөн нэгдэн нийлэх шийдвэрээ өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллагад урьдчилан мэдэгдээгүй бол өндөр торгууль төлөх болдог.


²⁴ “Өрсөлдөөний хууль ба бодлого” УБ., 2014, Ред. Х.Цэвэлмаа, А.Ариунболд. 51 дэх тал.

²⁵ Мөн тэнд. 58 дахь тал.

Өрсөлдөөнийг хязгаарлах үр дагавар бүхий төрийн оролцоо нь өрсөлдөөний зохицуулалт, хяналтын объектуудын нэг юм. Энэ нь төрийн байгууллагаас гаргаж байгаа шийдвэр нь өрсөлдөөнийг хязгаарлах, хэн нэгэн этгээдэд давуу байдлыг хууль бусаар олгох, өрсөлдөөний процесст буруу жишиг тогтоох зэрэг үр дагавруудыг бий болгох нь бий.

Төрийн өмчийн оролцоотой ААН-үүд, эсхүл Засгийн газар, төрийн захиргааны байгууллагуудаас шууд ба шууд бус хэлбэрээр өрсөлдөөнд нөлөөлөх оролдлогуудыг энд авч үздэг. Европын холбооны Комисс нэгэн сонирхолтой кейс шийдвэрлэсэн нь энэ талаарх сонирхолтой жишээ болно гэж үзэж байна. 2009 оны 3 сард Euro Real Estate гэдэг банкийг ХБНГУ-ын төрийн “Санхүүгийн тогтворжуулалтын сан” хэмээх байгууллага өөртөө нэгтгэв. Үүнтэй зэрэгцээд KfW банкийг Засгийн газар өөртөө авав. Европын холбооны Комиссын өрсөлдөөний хороо энэ шийдвэрийг өрсөлдөөний үүднээс хянахаар хэрэг үүсгэсэн. Учир нь “Санхүүгийн тогтворжуулалтын сан” нь Сангийн яамнаас бодлогын хувьд шууд хамааралтай болох нь тодорхой байсан. Ингээд эдгээр нэгдэх процессыг шалгаж үзээд Federal Ministry of Finance (“BMF”) буюу BMF Group гэсэн бүтэц бий болсон байна гэж дүгнэсэн. Үүний дараа яг групп компаниудыг шалгадагтай ижил зарчмаар тэдний зах зээлд нөлөөлөх боломж, үр дагавруудыг шалгаж эхэлсэн түүхтэй. ²⁶





бараа бүтээгдэхүүн борлуулахдаа иж бүрдэлд ороогүй бараа дагалдуулах

хууль ёсны ашиг сонирхолд харшлах болон хэрэглэгчийг хууль бусаар хохироох худалдааны арга хэрэглэх

Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал

Санхүүгийн байгууллагуудын хувьд үйлчлүүлэгч, бизнес эрхлэгчдийн нууцлалыг хадгалах үүргийг хүлээдэг. Хэрэв энэ үүргээ зөрчсөн бол Зөрчлийн болон Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээх эрх зүйн үр дагавартайгаас гадна бизнесийн нэр хүндээ алдах асуудал үүсдэг. Санхүүгийн байгууллагуудын урт хугацааны амжилт нь харилцагчийн итгэлтэй нягт холбоотой. Иймд нийт ажилтан албан хаагчид нууцлалын үүрэг хариуцлагаа ухамсарлах нь чухал ба энэ асуудал комплаенстай нягт холбоотой юм.

Санхүүгийн байгууллагууд нь өөрсдийн эзэмшдэг мэдээллийн нууцлалыг тогтмол шалгаж байх ёстой. Үүнд дүрэм, журам, бодлого, шийдвэр, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцэл, ажил, гүйлгээ, хэвлэмэл санхүүгийн баримт болон цахим системийн нууц зэрэг асуудлууд багтана.

"Нууц мэдээлэл" гэсэн нэр томъёог өргөн утгаар нь ашиглах ёстойг санах хэрэгтэй. Тухайлбал:

- Таны хувьд ялимгүй мэт харагдах мэдээлэл бусдад ач холбогдол өгөхүйц байж болно.
- Магадгүй ач холбогдол бүхий мэдээлэл нь ирээдүйд эмзэг, ач холбогдолтой болж магадгүй юм.

Санхүүгийн байгууллагууд нь харилцагчдын нууцлалыг хадгалах асуудлыг журамлаж комплаенсын хөтөлбөрт тусгах, эсхүл бие даасан цахим мэдээлэл хамгаалах тухай дотоод журам баталж ажиллавал зохимжтой. Уг журам нь дуу, дүрс бичлэг, текст, тоо мэдээлэл гэх мэт системийн мэдээллийг интернет, цахим шуудан, гар утас, USB порт гэх мэт аливаа хэлбэрээр дамжуулан мэдээллийн нууцлалыг задруулахаас хамгаалахад чиглэнэ.

Мөн мэдээллийг задруулахаас гадна цахим халдлагаас хамгаалах асуудал чухалд тавигдах ба хамгаалалтын хана (Firewall), хамгаалалтын систем суурилуулах зардлыг төсөв төлөвлөгөөндөө суулгах асуудал комплаенс хариуцсан нэгжийн хийвэл зохих ажил юм.

Мэдээлэл болон мэдээллийн системийн бүрэн бүтэн халдашгүй, хүртээмжтэй байдлыг хангахын тулд мэдээлэл болон мэдээллийн системд зөвшөөрөлгүй хандах, мэдээллийг ашиглах, ил болгох, өөрчлөх, хуулах, устгах, мэдээллийн системийн үйл ажиллагааг тасалдуулах, хянахаас хамгаалахыг Мэдээллийн аюулгүй байдал гэнэ.²⁷

Мэдээлэл болон мэдээллийн систем халдашгүй/нууцлагдмал, бүрэн бүтэн, хүртээмжтэй байж тэдгээрийн аюулгүй байдал хангагдана.

²⁷ Д.Цогтбаатар, Н.Баатархуяг, "Мэдээллийн аюулгүй байдлын үндэс" гарын авлага, УБ, 2015 он.

Халдашгүй байдал/Confidentiality - мэдээлэл, мэдээллийн системд зөвхөн зөвшөөрөлтэй этгээд хандах боломжоор хангагдсан байхыг хэлнэ.

Бүрэн бүтэн байдал/Integrity - Мэдээлэл, мэдээллийн системээс зөвшөөрөлгүй этгээд нэвтэрч мэдээллийг өөрчлөх, устгахаас хамгаалагдсан байхыг хэлнэ.

Хүртээмжтэй байдал/Avialability - мэдээллийн системээс зөвшөөрөлтэй этгээд шаардлагатай үед мэдээлэл олж авах боломж бүрдсэн байхыг хэлнэ.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндсэн үе шат. Үүнд:

- Биет аюулгүй байдал/Phisycal security;
- Хувийн аюулгүй байдал/Personal security;
- Ажиллагааны аюулгүй байдал/Operation security;
- Харилцааны аюулгүй байдал/Communication security;
- Сүлжээний аюулгүй байдал/Network security;
- Мэдээллийн аюулгүй байдал/Information security.

Дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ

Финтек буюу дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, энэ төрлийн бизнес хандлага хэрэглэгчдэд чирэгдэл багатай, шуурхай, амар хялбар нөхцөлийг санал болгож байгаа хэдий ч энэ хэрээрээ мэдээллийн нууцлал алдагдах, хууль бус арилжаа, гүйлгээ хийгдэх зэрэг цөөнгүй эрсдэлийг дагуулж буй юм.

Финтекийн анхны элементүүд интернет орчинд бий болж эхэлсэн цагаас л регтек (RegTech/Regulation Technology) буюу зохицуулалтын шийдлүүдийг эрж хайдаг. Нэгэнт бизнес, санхүүгийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж эхэлсэн тул зохицуулалт нь мөн эдгээр зохицуулах шаардлагатай үйл ажиллагаандаа нийцсэн хэлбэрт шилжиж, шийдэл гарцаа тодорхойлсон байх учиртай.

Өнөөдөр дэлхий дахины технологийн салбарт регтек системийг хөгжүүлэх, үүний дотор санхүүгийн удирдлага, хяналтын шийдлийг олох, хөгжүүлэх үйл ажиллагаа эрчимтэй хийгдэж байна.

Санхүүгийн салбарт регтек шийдлүүд нь мөнгө угаахтай тэмцэх, хэрэглэгчийг таних, цахим аюулгүй байдлаас хамгаалах, тайлангийн өгөгдөлд шинжилгээ хийх, эрсдэлийг удирдах, залилангаас урьдчилан сэргийлэх гэх мэт олон асуудлыг шийдэхэд чиглэгдэж байна. Хэрэглэгчдийн хувьд санхүүгийн салбарын зохицуулалтын дүрэм, журмыг ойлгож үйл ажиллагаагаа тэдгээрт нийцүүлэн явуулах, тайлан, мэдээллээ сайжруулах, стандартчилах, арилжаа, гүйлгээний мэдээллээ хянах, болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлох функцуудыг регтек санал болгож буй юм. Энэ нь комплаенсын ажилтнуудад тулгардаг өдөр тутмын олон сорилтуудыг шийдвэрлэхэд тус дөхөм авч ирж байна. Ялангуяа санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл явц (Fight Financial Crime) үйлчлүүлэгчид болон гуравдагч этгээдийн зөрчлийг илрүүлэхэд маш их нөлөө үзүүлж байна.

Тухайлбал үйлчлүүлэгч, түүнтэй хамааралтай гуравдагч этгээдийн гүйлгээг, үйл ажиллагааг шалгах явцад үйл явцын нарийн төвөгтэй байдал, мэдээлэл дутуу, нөөцийн

хомсдол, зардал, цаг хугацаа шаардагдах асуудалтай тулгардаг. Регтек, комплаенсын шийдлүүд нь олон сая текст баримт бичгүүдийг боловсруулж, өгөгдлүүдээс хамгийн их үнэ цэнэтэйг ялгаж авах, шийдвэр гаргалтад шаардлагатай мэдээллүүдийг боловсруулах, агуулгын үр дүнг дээшлүүлж, илүү зорилтод түвшинд хүрэх, илүү чухалд мэдээлэлд анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгож байна.

Цахим аюулгүй байдал /cybersecurity/.

Цахим аюулгүй байдал гэж юуг хэлэх вэ?

Цахим халдлага нь ихэвчлэн зөвшөөрөлгүйгээр хувь хүн хуулийн этгээдийн данс, төлбөрийн картны мэдээлэл, компанийн нууцад хамаарах мэдээллийг хулгайлан эдийн болон эдийн бус хохирол учруулдаг тул санхүүгийн байгууллагууд цахим аюулгүй байдалд анхаарал хандуулж, комплаенсын хөтөлбөрийг дэмжих шаардлага тулгарч байдаг. Мэдээллийн технологи өндөр хөгжсөн улс орнуудын туршлагаас үзэхэд цахим гэмт хэрэг үйлдэгдсэн үед авч хэрэгжүүлэх цахим аюулгүй байдлын хөтөлбөрийг боловсруулдаг бөгөөд цахим гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон талт хөтөлбөр боловсруулах нь тодорхой асуудлуудыг үр нөлөөтэй шийдвэрлэх боломжийг олгоно.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хэрэгсэл:

1. Програмын хэрэгсэл – Мэдээлэлд зөвшөөрөлгүй хандах, хуулах, өөрчлөх, устгах, хаалтаас хамгаалах зориулалттай компьютерийн тусгай програм. Үүнд:
 - Үйлдлийн систем, лиценз, шинэчлэл/update, нөхөөс/patch;
 - Хортой кодны эсрэг програм/Anti-virus, Anti-spyware, Trojan-remover;
 - Криптограф, SSL, PGP, VPN, НТДБ(PKI), Цахим гарын үсэг;
 - Бүртгэлийн файл (log file) зэрэг болно.
2. Техник хэрэгсэл – Мэдээллийг алдагдах, задруулах, өөрчлөх, устгахаас хамгаалсан механик, цахилгаан цахим болон бусад төхөөрөмж. Үүнд:
 - Сервер, компьютерийн аюулгүй байдал;
 - Тог баригч (UPS);
 - Цахилгаан соронзон орны нийлэмж, давхцал (EMC);
 - Зөөврийн мэдээлэл тээгч (USB-Flash);
 - Гадны бичил схем, арын хаалга (back door) илрүүлэх төхөөрөмж зэргийг хамааруулна.
3. Харилцаа холбооны хэрэгсэл – Мэдээлэл дамжигдаж байгаа сүлжээний аюулгүй байдал, түүнээс мэдээлэл алдагдахаас сэргийлсэн техник болон програм хангамж. Үүнд:
 - Сүлжээний аюулгүй байдал, Router, Firewall –ийн тохиргоо;
 - Сүлжээний хаяглалт, хаягийн бүртгэл (IP- Address);
 - Гадаад болон дотоод сүлжээний тусгаарлалт (DMZ);
 - Хандалтын удирдлага (access control);

- Дотоод, гадаад хандлагад хариу үйлдэл үзүүлэх систем (Trusted WAN, IDS, IPS) зэргийг ойлгоно.

Цахим аюулгүй байдлын ач холбогдол

Цахим аюулгүй байдлын гурван үндсэн зүйл бол хүмүүс, үйл явц, технологи /technology/ бөгөөд эдгээр нь байгууллагад тулгарах аюул занал, эмзэг байдал, эрсдэлийг тодорхойлж, түүнийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

- Хүмүүс - Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан нь цахим халдлагын үед хариу арга хэмжээ авах ажлын дадлага туршлага, мэдлэг чадвар, боловсролтой байх шаардлагатай.
- Үйл явц - байгууллагын үйл ажиллагааны эрсдэл, эрсдэлийг бууруулахад байгууллагын үйл ажиллагаа тухай болон дотоод хяналтын хөтөлбөрийн талаар мэдлэг мэдээлэлтэй байх шаардлагатай. Цахим аюул занал нь одоо үед хурдтайгаар өөрчлөгдөн шинэчлэгдэж буй тул энэхүү үйл явцыг тогтмол хяналт тавих хэрэгтэй.
- Технологи - байгууллагад тулгарч буй цахим эрсдэлийг олж илрүүлэхийн тулд ямар хэлбэрийн хяналт хийх, технологийн ямар шийдэл /ректек/ ашиглахыг ойлгоно. Эрсдэлийн үнэлгээ, түүний түвшингийн байх ёстой хэмжээ хязгаараас хамааран урьдчилан сэргийлэх, багасгахын тулд технологийн шийдлийг ашиглаж болно.²⁸

Цахим халдлага нь дараах байдлаар үйлдэгддэг:

- Хортой програмуудаар дамжин халдах /тухайлбал: “Ransomware”, “Фишинг/phishing”, “Malware”, трояны вирус/“Trojans”, өт/“worms”, “Spyware”/;
- Цахим шуудан, мессежээр дамжин халдах;
- Цахим хуудас (web page) нийтийн сүлжээгээр дамжин халдах;
- Нууц үг эвдэх;
- Төлбөртэй програмуудыг эвдэж ашиглах.

Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан нь дараах үүрэгтэй:

1. Цахим аюулгүй байдалд аюул занал тулгарсан үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө бэлтгэж боловсруулах;
2. Цахим аюулгүй байдлын талаар байгууллагын ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулах.²⁹

Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

- Файлын эх сурвалжийг шалгах;
- Antivirus-ны програм байнга ашиглах, тогтмол update хийх;

²⁸ <https://www.itgovernance.co.uk/what-is-cybersecurity>

²⁹ http://www.finra.org/sites/default/files/2018_CC_CCO_Role.pdf

- Флаш диск зэрэг зөөврийн хадгалах төхөөрөмжүүдийг компьютерт шалгахгүйгээр залгахгүй байх;
- Гадны нээлттэй сүлжээнд аль болох холбогдохгүй байх (хувийн виртуал сүлжээ хэрэглэхээс бусад тохиолдолд);
- Laptop, зөөврийн төхөөрөмж дэх чухал мэдээллийг шифрлэх, хараа хяналтгүй үлдээхгүй байх;
- Интернет хандалтын аюулгүй байдлыг хангах.

Нийгмийн хариуцлага

Комплаенс нь мэргэжлийн болон ёс зүйн, гүйцэтгэлийн алдаа гарах эрсдэлийг бууруулж, хууль эрх зүй, нэр хүнд, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулдаг. Компанийн нийгмийн хариуцлага нь гадаад болон дотоодын гэсэн хоёр ангилалд хуваагддаг. Гадаад нийгмийн хариуцлага нь сайн үйлс, хандив, дэмжлэг үзүүлэх, нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох гэх мэт компаниудын гадаад нэр хүндийг өсгөх үйл ажиллагаанд чиглэдэг. Харин дотоод нийгмийн хариуцлага нь гүйцэтгэлийн алдаа гарах эрсдэлийг бууруулахад чиглэдэг ба компанийн бизнесийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгмийн хувьд сөрөг нөлөө үзүүлэхгүй ажиллах арга замуудыг баримтлахад оршдог.³⁰

Иймд комплайнс хөтөлбөрт нийгмийн хариуцлагын талаар, мөн нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичигт комплайнс талаар 2 талаас нь тусгаж өгөх нь зүйтэй.

Өмнө нь бизнес хөрөнгө оруулагчдын эрх ашгийн төлөө нийгмийн болон байгаль орчны бусад үнэ цэнийг устгадаг байсан бол өнөөдөр PPP (Хүн буюу Хэрэглэгч) People + (Хүрээлэн буй орчин буюу Эх дэлхий) Planet = (Ашиг) Profit гэсэн дарааллаар ажилладаг болсон.

Эдгээр үйл ажиллагаанууд нь хоорондоо харилцан уялдаа холбоотой бөгөөд компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлж, үр дүн гарахад зайлшгүй чухал асуудлууд юм. Хариуцлагатай бизнес эрхлэхэд дараах асуудлын аль нэгийг орхигдуулахгүйгээр жигд авч явах шаардлагатай.

Нийгмийн хариуцлагатай байгууллага байхын тулд:

1. Нийгмээ судлах;
2. Судалгаанд үндэслэн байгууллагынхаа одоогийн нөхцөл байдал, байгууллагын дотоод болон гадаад орчны дүн шинжилгээг хийх;
3. Байгууллагын онцлогт нийцсэн нийгмийн хариуцлагын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, Нийгмийн хариуцлагын бодлогын хэрэгжилтэд үнэлгээ хийх.

Санхүүгийн байгууллагууд хувьд дотоод нийгмийн хариуцлагад анхаарч, нийгмийн хариуцлагын хөтөлбөрт комплайнсын асуудлыг түлхүү тусгаж өгөх нь зөв юм. Жишээлбэл зээлийн үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн байгууллагууд дүн болон том хэмжээний зээлийн хүсэлтийг судлахдаа байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг хийж олгож байх, Андеррайтерын үйлчилгээ үзүүлэгч байгууллага IPO гаргагч этгээдэд

³⁰ <http://www.marketing.org.mn/news/read/“үнэт-зүйлсээ-хуваалцъя>

мөн дээрх үнэлгээнүүдийг хийж, үнэт цаасны танилцуулгад тусгаж байх гэх мэтээр дотоод үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх тал дээр анхаарах шаардлагатай юм.

Санхүүгийн зах зээлийн оролцогч, хөрөнгө оруулагчид ёс зүйтэй, хариуцлагатай бизнесийг дэмжих сонирхолтой байдаг. Нийгэм, байгаль орчинтой холбоотой эрсдэлүүд, боломжуудыг компаниуд хэрхэн шийдэж буй талаарх мэдээ мэдээллийг ихээр шаардах болсон. Компанийн нийгмийн хариуцлага нь хувьцааны үнэ цэнийг өсгөх, капиталын зардлыг багасгах, зах зээлд илүү тогтвортой харилцааг бий болгох зэрэгт тусалдаг.

Байгууллагын нийгмийн хариуцлага нь зөвхөн зөв зүйлийг, тэр дундаа буяны, эсхүл хандивын ажил хийнэ гэж шууд утгаар ойлгох нь өрөөсгөл бөгөөд бизнесийн нэр хүндийг өндөрт өргөх үйл явцаар дамжин хэрэглэгчдээ өөртөө татах, хадгалж үлдэх, олон нийтэд зөвөөр ойлгогдож хүлээн зөвшөөрөгдөх нь хариуцлагатай бизнесийн чухал шинж юм. Олонхи хэрэглэгчид ёс зүйтэй бизнес эрхэлж буй байгууллагаас үйлчилгээ авахыг илүүтэй хүсдэг.

Байгууллагын нийгмийн хариуцлагыг сайн хэрэгжүүлж буй компанийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд өсөн нэмэгддэг. Тухайн компанийн нэр хүнд, байр суурь нэмэгдэх нь тухайн байгууллагын найдвартай байдал, төлбөрийн чадвар, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Түүнчлэн бизнесийн ёс зүйтэй холбоотой хэрэг зөрчил нь хувьцаа эзэмшигчид болоод ажилтан, албан хаагчдын итгэлийг алдагдуулах, нийгэм олон нийтийн зүгээс тухайн компанид итгэх итгэлийг бууруулах зэрэг олон сөрөг үр дагаварыг бий болгодог. Компанийн нийгмийн хариуцлага нь компанийн удирдлагыг сайжруулах, ил тод байдлыг бий болгох, ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөх боломжийг олгох бөгөөд эрсдэлийг багасгаж, шинэ боломжуудыг нээн өгч, компанийн нэр хүндийг өсгөж, үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг нөлөөтэй. Дараах боломжуудыг шууд болон шууд бусаар үүсгэдэг гэж үздэг. Үүнд:

- Өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Компанийн нэр хүнд нийгэмд өсөн нэмэгдэх;
- Тогтвортой, чадварлаг, хүний нөөцийг татах;
- Технологиор тэргүүлэх, тасралтгүй сайжруулалт бий болох;
- Санхүүгийн үзүүлэлтийг сайжруулах;
- Тогтмол борлуулалт, нийлүүлэлтийн сувгийг бий болгох;
- Өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх;
- Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх;
- Баялгийг бүтээн бий болгох;
- Төрийн байгууллагуудтай харилцах харилцаа сайжруулах;

- Тогтвортой хэрэглээг дэмжих.³¹

Санхүүгийн байгууллагууд компаниудын нийгэм, байгаль орчны шалгуур үзүүлэлтүүдийг өөрсдийн үйл ажиллагаа, бодлого шийдвэр гаргах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ өргөн ашигладаг. Хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө мөнгөө компанийн нийгмийн хариуцлагын үр дүнтэй, өгөөжтэй менежмент бүхий компанид оруулах сонирхол өндөр байдаг бөгөөд нийгмийн хариуцлагыг сайн тусгаж оруулсан бизнес төлөвлөгөө, төсөл нь сайн менежментийн нэг гол хэрэгсэл болдог.

6. АУТСОРСИНГ

Аутсорсингийн ойлголт

Байгууллагад комплаенсын үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхгүй байх нь хууль эрх зүйн хариуцлага хүлээх, ял шийтгэлд холбогдох, стратегийн зорилтууд нь хангагдахгүй нөхцөл байдалд хүрэх, бизнесийн нэр хүнд унах зэрэг эрсдэлүүдтэй тулгарах үндэс болдог. Товчоор бол байгууллагын оршин тогтнох байдалд заналхийлдэг байна.

Байгууллага ямар зорилгоор аутсорсинг хийдэг вэ?

- Үйл ажиллагааны зардлыг танах, зардлыг удирдах
- Нэгдэл, группын хувьд бусад салбар нэгжүүдэд тавих хяналтаа сайжруулах
- Олон улсын хэмжээнд бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх
- Дотоод нөөцийг бусад илүү хэрэгцээт талбарт ашиглах
- Цаг хугацаа болон өндөр хяналт шаардах үйл ажиллагааг удирдан зохицуулах
- Байгууллагын дотоод нөөц боломж хангалтгүй байгаа нөхцөлд /хүний нөөц гэх мэт/
- Эрсдэлийг тархаан байршуулах гэх мэт үндсэн зорилгоор байгууллагууд аутсорсинг хийдэг.

Өмнө дурдсан эрсдэлүүдийг бууруулахын тулд байгууллага, компаниуд:

1. Комплаенсын функц, сургалт чадавхжуулалт, үйл ажиллагааны чанар, технологийн чадамж зэрэгт өргөн цар хүрээтэй хөрөнгө оруулалт хийх,
2. Аутсорсинг гэх мэт гаднаас авч болох боломжуудыг ашиглах,

³¹ <https://www.kas.de/einzeltitel/-/content/kompanijn-nijgmijn-hariuclaga-gez-uu-ve>

3. Дээрх боломжуудыг багтаасан хөтөлбөр хэрэгжүүлэх нь зүйтэй.

Комплаенс нь орлого олох бизнесийн хэрэгсэл биш. Харин аж ахуйн нэгжийн эрсдэлийг удирдах, бизнесийн стратегийг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл юм. Тиймээс комплаенсын шаардлагуудыг хангахын тулд олонхи байгууллагууд томоохон комплаенсын функцыг хэрэгжүүлдэг ба тэр хэмжээгээр үйл ажиллагааны зардал өсдөг талтай. Зохицуулалтын төвөгтэй байдал, албан хаагчдын ур чадвар, туршлагын байдал, үйл ажиллагааны өндөр зардлаа танах хэрэгцээ зэргээс үүдэн аж ахуйн нэгж байгууллага гадны болон бусад боломж эх үүсвэрийг ашиглах шаардлага тулгардаг.

Комплаенсын аутсорсинг нь тухайн байгууллагад өөрийн үндсэн бизнес, үйл ажиллагаандаа анхааран ажиллахын зэрэгцээ комплаенсын үндсэн шаардлагуудыг ханган ажиллах боломжоор хангадаг. Комплаенсын, санхүүгийн, эрсдэлийн чиглэлийн удирдах албан тушаалтнууд нь комплаенсын аутсорсингийг хэрхэн ашиглах вэ, хэрхэн улс орны болон олон улсын хэмжээний нарийн шаардлагуудыг ханган ажиллах вэ гэдэгт анхаарал хандуулан ажиллах нь зүйтэй. Эдгээрээс үүдэн дараах асуултууд урган гардаг:

- Комплаенсын аутсорсинг гэж юу вэ?
- Комплаенсын аутсорсинг юунд хүргэх вэ?
- Бизнесийн үйл ажиллагаатай комплаенсын аутсорсинг ямар хамааралтай вэ?
- Байгууллага комплаенсын аутсорсингийг хэрхэн ашиглаж нэвтрүүлэх вэ?

Комплаенсын аутсорсинг гэж юу вэ?

Аутсорсинг гэдэг нь энгийнээр тодорхойлвол аливаа бизнесийн байгууллага шаардлагатай үед өөрийн ямар нэгэн үйл ажиллагаа, ажил үйлчилгээг гэрээний дагуу гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх үйл явц юм. Харин комплаенсын аутсорсинг гэдэг нь дотоодын бус эх үүсвэрийг бизнесийн үйл ажиллагаандаа ашиглан комплаенсын хэрэгцээ шаардлагуудыг биелүүлэх үйл явц ба тухайн аж ахуй нэгжийн комплаенсын нэгжтэй уялдаа холбоотой ажилладаг. Ихэвчлэн тухайн улс оронд юмуу гадны улс оронд байрлах гуравдагч этгээдээр гүйцэтгүүлдэг байна. Мөн гадны гуравдагч этгээдээс гадна нэг нэгдэл, группд хамаарах өөр компаниар комплаенсын үйл ажиллагааг гүйцэтгүүлэх боломжтой байдаг.

Комплаенс Аутсорсинг хийх шалтгаанууд

Комплаенсын үйл ажиллагааг жигд байлгахад тулгамдаж буй хэд хэдэн асуудлуудаас шалтгаалан аутсорс хийх шийдвэрийг гаргаж болно.

Боловсон хүчний дутагдал – Комплаенсын хүрээний хууль эрх зүйн орчны өөрчлөлт болон нэмэлт шаардлагуудаас үүдэн, комплаенсын үйл ажиллагаа болон хууль эрх зүйн мэдлэг бүхий боловсон хүчин шаардлагатай болж болно. Энэхүү мэргэжлүүд нь эрэлт ихтэй ч нийлүүлэлт багатай байдаг болно. Байгууллагууд нь комплаенсыг хангахын тулд нэмэлт сургалтууд болон бусад үйл ажиллагааны зардлаа нэмэхэд хүрдэг.

Комплаенсын боломжит доод шаардлага – Байгууллагууд нь өөрсдийн комплаенсын үйл ажиллагааг хэвийн голдрилд оруулж, үр дүнг тодорхой байлгах сонирхолтой байдаг. Гэсэн хэдий ч хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал нь тухайн комплаенсын үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалтыг үр дүнгүй болгох аюултай

байдаг. Энэ нь ихэвчлэн комплаенсын үйл ажиллагаанд хүндрэл учруулж жишиг байдлаар зохицуулалт хийхэд хэцүү болгодог. Цаашлаад комплаенсын үйл ажиллагааны өндөр өртөг, чанарын доголдол дахин шинээр эхлэхэд хүргэдэг.

Технологийн дэд бүтцийг сайжруулах – Комплаенсын шаардлагыг хангахын тулд байгууллагууд нь шинэ дэвшилтэт технологи болон дэд бүтэцдээ байнгын хөрөнгө оруулалт хийж байдаг. Хууль эрх зүйн орчинд хийгдэж буй өөрчлөлтүүдээс хамааран технологийн хөрөнгө оруулалт нь нэг удаагийн мөн байнгын хэлбэртэй байдаг.

Дэлхий нийтийн комплаенсын шаардлагыг дагаж мөрдөх – Олон улсын байгууллагууд нь комплаенсын боловсон хүчнийг бэлтгэж, хөлсөлж боловсон хүчний сан үүсгэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Мөн дэлхий даяар нэгдсэн комплаенсын мэдлэг туршлагын бааз үүсгэхийн тулд нэмэлт хөрөнгө оруулалтууд шаардлагатай байна.

Үйл ажиллагааны зардлын нэмэгдэл – Хууль эрх зүйн орчинд хийгдэж буй өөрчлөлтүүд нь үйл ажиллагааны зардалд нилээдгүй хэмжээний нэмэгдэл үүсгэж байна.

Комплаенс Оутсорсинг хийснээр бизнесийн ямар үйл ажиллагаа хийж болох вэ

Байгууллага тус бүр, өөрсдийн хөрөнгөөр комплаенсын шаардлагыг хангаж их хэмжээний хөрөнгө зарцуулсны оронд комплаенс аутсорсинг хийх нь ашигтай эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Хууль эрх зүйн өөрчлөлтүүд нь байгууллагуудыг комплаенсын дэд бүтэц үүсгэн хөгжүүлэхэд хүндрэлтэй болгосон. Хөрөнгийн бололцоо байсан ч гэсэн байгууллагууд тус үйл ажиллагааг явуулахад боловсон хүчний чадамжийн асуудал нь хүндрэл болдог.

Харин нөгөө талаас, комплаенс аутсорсинг хийхэд тус байгууллагууд нь боловсон хүчний чадамж өндөр ба зөвхөн комплаенсын чиглэлээр ажилладаг байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг байна. Тус байгууллагууд нь ихэвчлэн хуулийн чиглэлээр туршлагатай хүмүүс эсхүл санхүүгийн чиглэлийн байцаагч нар гэх мэт чадварлаг боловсон хүчнүүдийг ажиллуулдаг болно. Мөн тус байгууллагууд энэхүү үйл ажиллагааг олон өөр харилцагч нарт үзүүлснээр, комплаенсын тал дээр ижил төстэй туршлагуудаас харьцуулан ажиллах боломжтой болдог. Өөрөөр хэлбэл тодорхой хэмжээний туршлагатай болж төрөл бүрийн кейсүүд дээр ажилласан байдаг.

Комплаенсын аутсорсинг хийснээр байгууллагууд нь өөрсдөө комплаенсын үйл ажиллагаа явуулснаас хэд хэдэн давуу талтай ба энэ нь ихэвчлэн мэргэшсэн боловсон хүчин болон тусгайлсан үйл ажиллагааны системтэй байдагтай холбоотой.

Байгууллага дотооддоо комплаенсын үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх болон комплаенс аутсорсинг хийх нөхцөл байдлын харьцуулалт:

Сонголтууд	Дотооддоо хийх	Комплаенс Аутсорсинг
Зардал	Тогтмол	Хувьсан багасах

Ажиллах хүч	Хязгаарлагдмал	Таарсан
Мэдлэг боловсон хүчин	Хязгаарлагдмал	Шаардлагын дагуу
Үйл ажиллагааны чиглэлийн мэдлэг мэдээлэл	Хязгаарлагдмал	Шаардлагатай тохиолдолд бэлэн
Сургалт хийх	Хөрөнгө болон цаг хугацаа шаардлагатай	Шаардлагагүй
Олон улсад үйл ажиллагаа явуулахад тулгамдах асуудлууд (Хэл, Тухайн бүс нутгийн хууль эрх зүй, Ложистик)	Их	Бага
Түгээмэл туршлагаууд	Хуваагдмал	Нэгдсэн
Өөрчлөлт хийх боломж	Удаан	Хурдан

Байгууллагууд комплаенс Аутсорсингийг хэрхэн хийх вэ?

Комплаенс аутсорсинг-д бодлогын хүрээнд стратегитай хандсанаар сайн үр дүнд хүрэх боломжтой. Доорхи хүснэгт нь комплаенс аутсорсинг хийх стратеги, дэс дараатай үйл ажиллагааны бүтцийг харуулж байна.



Үндсэн үйл ажиллагаанууд

Нэг

- Комплаенсын үйл ажиллагаа болон тайлангуудын мастер жагсаалт үүсгэх
- Үйл ажиллагаанд дүгнэлт хийж аутсорсинг хийх эсхүл дотооддоо ажиллахыг тодорхойлох
- Аутсорсинг хийснээр гарч болох ашиг, хөрөнгө оруулалтыг тодорхойлох
- Байршил болон бизнесийн үргэлжлэлийн талаар харгалзан үзэх

Хоёр

- Аутсорсинг хийж буй үйл ажиллагааныхаа санал хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулах
- Аутсорсинг үйлчилгээ үзүүлэх байгууллагыг үнэлэх схемийг бий болгох

- Санал хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулах аутсорсингийн компанийг сонгох

- Эцсийн гэрээ болон ажлын хамрах хүрээг тохиролцох

Гурав.

- Шилжилтийн төлөвлөгөөг гаргаж үйлчилгээний гэрээг хийх

- Үйлчилгээ үзүүлэгчтэй харилцан тохиролцож эрсдлийг тодорхойлох

- Үйлчилгээ үзүүлэгчийн дэвшилтэт технологийг ашиглан үйл ажиллагааг

хурдасгах

- Комплаенсын үйл ажиллагааг тогтворжуулж мэдээллийг шилжүүлэн өгөх

Дөрөв

- Мэдээлэл цуглуулалт хийж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх

- Оновчтой мэдээлэл цуглуулалт хийн түүндээ хяналт шалгалт хийх

- Болзошгүй эрсдлүүдийг тодорхойлох, шаардлага хангаагүй үйл ажиллагааг

мэдээлэх

- Хууль эрх зүйн өөрчлөлтөд зориулсан үйл ажиллагааг тодорхойлох

Тав

- Үйл ажиллагааг комплаенсын шаардлагуудтай харьцуулан шалгах

- Аутсорсинг хийж буй байгууллагад хяналт тавих аудит хийх

- Дата анализ хийх

- Үйл ажиллагааны оноог тогтоох (KPI)

Гол харгалзах зүйлүүд

- Стратегийн дүн шинжилгээ

- Эрсдлийн шинжилгээ

- Зардлын ашигтай байдлын судалгаа

- Засгийн газартай оутсорсингын талаар зөвлөлдөх

- Ашигтай зардлын харицааг тодорхойлох

- Үйлчилгээ үзүүлэгчийн хүчин чадал

- Үйлчилгээ үзүүлэгчийн эрсдлийн менежмент болон тайлантай танилцах

- Эрсдлийн талаархи нэгдсэн ойлголт

- Харилцаа холбоог нээх

- Сайн харилцаа

- Дотоодын аудит

- Тайлангийн ил тод байдал

- Мэдээлэл технологийн дотоодын хөрөнгө оруулалт

Комплаенс аутсорсинг хийх нь байнгын анхаарал шаардах ба оутсорсинг хийж буй байгууллагуудад хяналт тавьж ажилладаг байх шаардлагатай.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах

Аутсорсинг хийх нь үйл ажиллагаа болон стратегитай холбоо бүхий мэдээллийн аюулгүй байдал үүсгэж болно. Тийм учраас байгууллагууд нь комплаенс аутсорсинг хийж буй байгууллагаас тус байгууллагыг мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг шаардаж, мэдрэг мэдээллүүдийг гэрээндээ тусгаж өгнө. Комплаенс аутсорсинг хийж байхдаа дараах асуудлуудыг харгалзан үзэх хэрэгтэй.

- Санал авах хүсэлт гаргахдаа мэдээллийн аюулгүй байдлын шаардлага тавих
- Аутсорс хийх компани сонгохдоо мэдээллийн аюулгүй байдал болон Мэдээллийн технологийн чадамжийг харгалзах
- Гэрээндээ мэдээллийн аюулгүй байдлыг тусгаж өгөх

Мэдээллийн аюулгүй байдал нь аутсорсинг хийж байх үед байгууллагын шийдвэр бүрт нөлөөлж байх шаардлагатай.

Комплаенс аутсорсинг хийснээр тухайн байгууллага нь дотоодын болон гадны нөөц бололцоог ашиглан комплаенсын шаардлагуудыг биелүүлэх замыг нээж өгөх болно.

Комплаенс аутсорсингийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд нь, шаардлагатай боловсон хүчин, техник технологийн дэвшил, үйл ажиллагааны шилдэг арга барил, зохистой дадлыг хангасан байдаг. Мөн тус байгууллага нь хууль эрх зүйн орчны өөрчлөлтийн үед баримтлах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байдаг. Мөн тэд олон харилцагчдад төстэй үйлчилгээ үзүүлснээр байгууллага тус бүр комплаенсын үйл ажиллагаа явуулснаас асар хямд тусдаг. Тиймээс комплаенс аутсорсинг хийх нь зардал, боловсон хүчин, цаг хугацааны хувьд хэмнэлттэй гарц болно.

2016 онд олон улсын санхүүгийн зөвлөх үйлчилгээний байгууллагаас гаргасан судалгаанд:

- Тус судалгааг дэлхийн хэмжээнд бизнесийн байгууллагуудын дунд хийсэн ба жилийн орлогын хувьд 1-25 тэрбум доллар бүхий томоохон байгууллагуудыг хамруулсан байна.
- Судалгаанд хамргадагсдын 78% нь аутсорсинг харилцаа бүхий этгээддээ сэтгэл хангалуун байдгаа илэрхийлсэн.
- Тус судалгаагаар 25 төрлийн аутсорсинг үйлчилгээг хамруулсан ба эзлэх хувийг авч үзвэл:

Үйлдвэрлэл үйлчилгээний - 29%

Санхүүгийн үйлчилгээний - 27%

Шинжлэх ухаан, эрүүл мэндийн чиглэлээр - 25%

Технологи, харилцаа холбооны - 9%

Мөн тус судалгаанд байгууллагууд яагаад аутсорсинг хийдэг вэ гэсэн асуулганд:

1. Зардал хэмнэх хэрэгсэл гэж үзсэн - 59%
2. Үндсэн бизнестээ илүү төвлөрөх боломж олгодог - 57%

3. Байгууллагын чадавхийн асуудлыг шийдвэрлэдэг - 47%
4. Үйлчилгээний чанарыг нэмэгдүүлдэг - 31%
5. Бизнесийн хэрэгцээнд чухал ач холбогдолтой - 28% г.м

ХАВСРАЛТ

Байгууллагын комплаенсын хөтөлбөрийн үнэлгээний загвар³²

Стратеги, эрхэм зорилго, алсын хараа

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Байгууллагын стратеги, эрхэм зорилго болон алсын хараа нь байгууллагын комплаент болон ёс зүйтэй үйл ажиллагаа явуулах соёлд нөлөөлж байгаа байдал		

Комплаенсын стандарт, хөтөлбөр болон үйл ажиллагаа

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Байгууллага комплаенсын стандарт, хөтөлбөр боловсруулсан байгаа байдал		

Компанийн засаглалын үүрэг хариуцлага

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Комплаенсын засаглал нь комплаес, ёс зүйн талаар мэдлэгтэй эсэх, комплаенсын хөтөлбөрийн хэрэгжүүлэх боломжтой эсэх		

Стратеги, эрхэм зорилго, алсын хараа

³² Jack Quinn, Esq, Quinn Gillespie and Associates, LLC, Washington, D.C., Suzanne Rich Folsom, Esq, Victoria McKenney, Esq, Robert T.Garretson, Patrick F.Speice, Jr., Esq. United States Steel Corporation, Pittsburgh, Pennsylvania, Gregory P.Belanger, Esq, Tiffany K.Tuggle ACADEMI LLC, Washington, D.C., Corporate Compliance: Building a World-Class Borderless Ethics Compliance Program

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Байгууллагын стратеги, эрхэм зорилго болон алсын хараа нь байгууллагын комплаент болон ёс зүйтэй үйл ажиллагаа явуулах соёлд нөлөөлж байгаа байдал		

Байгууллагын удирдлагыг таньж мэдэх үйл ажиллагаа

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Байгууллага этик болон комплаенс хөтөлбөрт нийцсэн, хууль бус үйл ажиллагаанд оролцож байгаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй удирдлага томилж ажиллуулж чадаж байгаа эсэх		

Сургалт

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Ёс зүй, комплаенсын чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулдаг эсэх. Мөн сургалтыг удирдлагуудад, ажилтнуудад, зуучдад зориулж ангилж өөр өөр сургалтын хөтөлбөр боловсруулж зааж чадаж байгаа эсэх		

Мониторинг болон үнэлгээ

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Байгууллага комплаенсын үйл ажиллагаанд мониторинг хийж чадаж		

байгаа эсэх, комплаенсын үр дүнтэй байдалд үнэгээ хийж чадаж байгаа байдал		
--	--	--

Дотоод харилцаа холбоо болон мэдээлэх, тайлагнах функц

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Байгууллага ТУЗ болон удирдлагуудад комплаенсын хөтөлбөр, ёс зүйн хэрэгжилт, үйл ажиллагаа, үр дүн зэргийн тухай мэдээлж байгаа эсэх		

Хариуцлага хүлээлгэх тогтолцоо

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Тухайн байгууллагад ёс зүйн хэм хэмжээ, комплаенсын хөтөлбөрийг ажилтнуудад мөрдүүлэх тогтолцоо болон тэдгээрийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо бүрдсэн байдал		

Эрсдэлийн үнэлгээ

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
Комплаенсын эрсдэлийн үнэлгээг хууль тогтоомжид нийцэж буй талаар тогтмол хийж байгаа эсэх. Мөн эрсдэлийн үнэлгээний дүгнэлтэд суурилж комплаенсын хөтөлбөрт өөрчлөлт оруулсан эсэх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа		

МУТСТ үйл ажиллагаа

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж
МУТСТ тухай хуульд нийцүүлж үйл ажиллагаа явуулж байгаа эсэх. Үүнд гүйлгээний мэдээллийг явуулсан байдал, харилцагчийг таних процедурыг хийж байгаа байдал зэрэг асуудлуудыг батгтаана.		

Авлигын эсрэг

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж

Ашиг сонирхлын зөрчлийн

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж

Төрийн байгууллагатай байгуусан гэрээ, хэлцэл

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж

Хүний нөөц

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж

Байгууллагын нэр хүнд, түүний эрсдэл

Зорилт	Ажиглагдсан асуудлууд	Зөвлөмж

Овог нэр	Албан тушаал	Огноо	Ажиглагдсан асуудлууд

Үнэлгээ хийсэн баримт бичгүүдийн жагсаалтын загвар

Баримт бичгийн нэр	Ажиглагдсан асуудлууд

КОМПЛАЕНСЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТҮЛХҮҮ ХАМААРАХ ХУУЛЬ

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

2013 оны 5 дугаар сарын
31-ний өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

Төрийн ордон,
Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтооход оршино.

2 дугаар зүйл.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж

2.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2¹ дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

2¹.1.Энэ хуульд заасан терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүхий л зохицуулалтад үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аливаа үйл ажиллагаа нэгэн адил хамаарна.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;

3.1.2.“терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист байгууллага, террорист хүн, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг;

3.1.3.“бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглаж хийсэн гүйлгээг;

3.1.4.“бэлэн бус мөнгөний гүйлгээ” гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, инкасс, төлбөрийн карт, цахим төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг;

3.1.5.“улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн3 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;

3.1.6.“эцсийн өмчлөгч” гэж:

3.1.6.а.харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.б.харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.в.хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.7.“халхавч банк” гэж гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагаа нь тухайн зөвшөөрөл авсан, эсхүл бүртгүүлсэн улсдаа бодитоор оршин байдаггүй, эсхүл тусгай зохицуулалттай ба нэгдсэн хяналт шалгалтад хамрагддаг санхүүгийн байгууллагад хамаардаггүй банкныг банкныг;

3.1.8.“харилцагч” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдээр үйлчлүүлж байгаа этгээдийг;

3.1.9.“хөрөнгө” гэж Иргэний хуулийн4 83 дугаар зүйлд заасныг;

3.1.10.“гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 2-т заасныг;

3.1.11.“үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг;

3.1.12.“үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч” гэж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнийг;

3.1.13.“хөрөнгийг удирдах” гэж харилцагчийн хөрөнгийг түүний нэрийн өмнөөс ашиглах, эзэмших, захиран зарцуулахыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээд

4.1.Дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй:

4.1.1.банк;

4.1.2.банк бус санхүүгийн байгууллага;

4.1.3.даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;

4.1.4.хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;

4.1.5.үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;

4.1.6.хадгаламж, зээлийн хоршоо;

4.1.7.харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;

4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

4.1.9.нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчийн нэрийн өмнөөс дараах ажиллагааг хийсэн бол:

4.1.9.а.үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;

4.1.9.б.харилцагчийн хөрөнгийг удирдах;

4.1.9.в.банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;

4.1.9.г.компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;

4.1.9.д.хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээх, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглахыг хориглоно.

4.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд ийнхүү хэрэгжүүлэхдээ дараах эрсдэлийг харгалзан өөрийн аж ахуйн үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцүүлэн бодитойгоор үнэлнэ:

4.3.1.харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл;

4.3.2.бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарч үүсэх эрсдэл;

4.3.3.бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;

4.3.4.газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл.

4.4.Энэ хуулийн 4.3-т заасан эрсдэлийг үнэлэхэд ашигласан баримт, мэдээллийг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанд хадгалах ба энэ хугацаанд эрх бүхий хянан шалгагч, улсын байцаагчийн шаардсан даруйд гарган өгөхөд бэлэн байлгана.

4¹ дүгээр зүйл.Эцсийн өмчлөгчийг тогтоох

4¹.1.Эцсийн өмчлөгчийг дараах дарааллаар шалгаж тогтооно:

4¹.1.1.хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг;

4¹.1.2.энэ хуулийн 4¹.1.1-д заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг;

4¹.1.3.энэ хуулийн 4¹.1.1, 4¹.1.2-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг.

4¹.2.Эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагааг энэ хуулийн 5.14-т заасан журмаар зохицуулна.

5 дугаар зүйл.Харилцагчийг таньж мэдэх

5.1.Дараах тохиолдолд энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй:

5.1.1.санхүүгийн харилцаа үүсгэхийн өмнө;

5.1.2.дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;

5.1.3.харилцагчийн 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь энэ хуулийн 5.1.2-т заасан хэмжээнээс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй бол;

5.1.4.харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд;

5.1.5.тухайн харилцагч, тухайн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасны дагуу харилцагчийг таньж мэдэхийн тулд энэ хуулийн 4.1-д заасан этгээд дараах арга хэмжээ авна:

5.2.1.харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн, эсхүл гадаад паспортын хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулж авах;

5.2.2.харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг гаргуулж авах;

5.2.3.эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс данс нээж, гүйлгээ хийж байгаа эсэхийг мэдэх, ойлгох зорилгоор тухайн бизнесийн харилцааны зорилго, гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах;

5.2.4.харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах;

5.2.5.харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгах;

5.2.6.банк, санхүүгийн байгууллагын хоорондын шилжүүлэг хийгч, хүлээн авагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, харилцах утасны дугаар, дансны дугаарыг авах.

5.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь харилцагчийн эрсдэлийн түвшинг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх ба уг үйл ажиллагааг энэ хуулийн 5.14-т заасан журмаар зохицуулна.

5.4.Харилцагч энэ хуулийн 5.2, 5.3-т заасны дагуу шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзвал энэ хуулийн 4.1-д заасан этгээд түүнд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

5.5.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь дараах тохиолдолд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг энэ хуулийн 5.2.1, 5.2.2-т заасан хүрээнд харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагааг хийж болно:

5.5.1.харилцагч нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эсхүл хөрөнгийн биржид бүртгэлтэй компани нь хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийг ил тод мэдээлэх үүрэгтэй бол;

5.5.2.ижил түвшний урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг мэдээлэх үүрэгтэй этгээд хоорондоо харилцахад.

5.6.Энэ хуулийн 4.1.1-д заасан этгээд нь гадаад гуйвуулга, шилжүүлэг, төлбөр тооцоо хийх зорилгоор гадаад улсын банктай корреспондент харилцаа тогтоохоос өмнө дараах мэдээллийг авсан байна:

5.6.1.тухайн банкны үйл ажиллагааны чиглэлийн талаарх мэдээлэл;

5.6.2.тухайн банк нь нийтэд танигдсан байдлын талаарх мэдээлэл;

5.6.3.корреспондент харилцааг тогтоох талаар гаргасан удирдлагын шийдвэр, уг харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг харилцан тохирсон тухай мэдээлэл;

5.6.4.тухайн банк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, дотоод хяналтын хөтөлбөртэй эсэх;

5.6.5.тухайн банк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд холбогдон шалгагдсан, шалгагдаж байгаа эсэх талаарх мэдээлэл.

5.7.Энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7-д заасан этгээдэд:

5.7.1.халхавч банктай харилцахыг;

5.7.2.халхавч банктай харилцаа тогтоосон банктай харилцахыг;

5.7.3.халхавч банктай өмнө нь харилцаа тогтоосон байсан бол харилцааг үргэлжлүүлэхийг хориглоно.

5.8.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь шинэ бүтээгдэхүүн, технологи нэвтрүүлэхийн өмнө түүний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдаж болох эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.9.Дараах харилцагчийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэгэн адил авч үзнэ:

5.9.1.улс төрд нөлөө бүхий этгээд;

5.9.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;

5.9.3.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд.

5.10.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хийх, хүлээн авах, дамжуулах шилжүүлэг нь шилжүүлэгч, хүлээн авагчийн талаарх тодорхой мэдээллийг бүрэн агуулсан байх ба шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл тодорхой бус тохиолдолд шилжүүлэг хийх, хүлээн авах, дамжуулахаас татгалзана.

5.11.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан мэдээлэлд байнгын хяналт тавьж, өөрчлөлт орсон тухай бүрд мэдээллийг шинэчилнэ.

5.12.Энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7-д заасан этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх тохиолдолд тавигдах шаардлагыг энэ хуулийн 5.14-т заасан журмаар зохицуулна.

5.13.Гуравдагч этгээдээр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийлгэх нь энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7-д заасан этгээдийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

5.14.Дараах нарийвчилсан үйл ажиллагааг тусгасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална:

5.14.1.эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.2.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа;

5.14.3.харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.4.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх тохиолдолд тавигдах шаардлага;

5.14.5.эрсдэлийн үнэлгээний талаарх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.6.дотоод хяналтын хөтөлбөрийн талаар;

5.14.7.хориг арга хэмжээний жагсаалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ;

5.14.8.холбогдох бусад арга хэмжээ.

6 дугаар зүйл.Тусгай хяналт

6.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд дараах гүйлгээнд тусгайлан хяналт тавих үүрэгтэй:

6.1.1.огцом өөрчлөгдсөн их дүнтэй;

6.1.2.эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй;

6.1.3.улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн;

6.1.4.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан гүйлгээний талаар энэ хуулийн 4.1-д заасан этгээд нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, үр дүнг бичгээр хадгална.

6¹ дүгээр зүйл.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх

6¹.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад нийцүүлэн Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6.1.4-т заасны дагуу баталсан хориг арга

хэмжээний жагсаалт /цаашид “хориг арга хэмжээний жагсаалт” гэх/-д орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

6^{1.2}.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож, энэ тухай Санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдээлнэ.

6^{1.3}.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх ба шаардлагатай бол хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан арга хэмжээг авна.

6^{1.4}.Хориг арга хэмжээний жагсаалтыг энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд хүргэх, хориг арга хэмжээ болон хуульд заасан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эдгээр арга хэмжээний хэрэгжилтийн тайлан гаргахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 5.14-т заасан журмаар зохицуулна.

7 дугаар зүйл.Гүйлгээний талаар мэдээлэх

7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.

7.2.Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

7.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд мэдээллийг факс, цахим хэлбэрээр, эсхүл бичгээр Санхүүгийн мэдээллийн албанд түүний баталсан маягт, журмын дагуу хүргүүлэх үүрэгтэй.

7.4.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Монголбанкны Ерөнхийлөгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан мэдээлэл өгөх журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад гаргаж өгнө.

8 дугаар зүйл.Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах

8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгална.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэл, баримт бичгийг энэ хуулийн 4.1-д заасан этгээд эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.

9 дүгээр зүйл.Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл

9.1.Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл дараах агуулгатай байна:

9.1.1.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

9.1.2.харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;

9.1.3.тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, он, сар, өдөр, дансны дугаар, гүйлгээний бусад оролцогч болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;

9.1.4.тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;

9.1.5.холбогдох бусад баримт бичиг.

9.2.Санхүүгийн мэдээллийн алба нь сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулбар, данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар, банкны харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс гаргуулан авах эрхтэй.

10 дугаар зүйл.Дансанд хяналт тавих

10.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглаж байгаа гэж үзэх үндэслэл байгаа бол Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн харилцагчийн дансанд хяналт тавьж болно.

11 дүгээр зүйл.Хөрөнгө битүүмжлэх, түдгэлзүүлэх

11.1.Хийгдэхээр хүлээгдэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй бол Санхүүгийн мэдээллийн албаны дарга тухайн гүйлгээг ажлын гурав хүртэл өдрийн хугацаагаар түдгэлзүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд шүүх уг хугацааг сунгаж болно.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан шийдвэрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бичгээр, боломжгүй бол утсаар мэдэгдэж, шийдвэрийг 24 цагийн дотор хүргүүлнэ.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасны дагуу гүйлгээг түдгэлзүүлэх хугацаанд Санхүүгийн мэдээллийн алба дараах арга хэмжээ авна:

11.3.1.тухайн гүйлгээний талаар гадаад, дотоодын холбогдох байгууллагаас шаардлагатай мэдээлэл цуглуулах;

11.3.2.тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан гэж үзэх баримт, үндэслэл тогтоогдсон бол энэ тухай эрх бүхий хууль сахиулах байгууллагад мэдэгдэж холбогдох баримт бичгийг нэн даруй шилжүүлэн шалгуулах;

11.3.3. тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсан гэдэг нь тогтоогдвол гүйлгээг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг цуцалж, энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд нэн даруй мэдэгдэх.

12 дугаар зүйл. Хариуцлагаас чөлөөлөх

12.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй.

12.2. Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

12.3. Тодорхой гүйлгээг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан болон Санхүүгийн мэдээллийн алба, тус албаны албан хаагчийг Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

12.4. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон Санхүүгийн мэдээллийн албаны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан бол хохирлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

13.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг энэ хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.

13.2. Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хянан шалгагч, шинжээч, ажилтан албан үүргийнхээ дагуу олж авсан харилцагчийн гүйлгээтэй холбогдох мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулахыг хориглоно.

14 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт

14.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь түүний төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах удирдлагаас баталсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна.

14.2. Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр нь энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцсэн байх ба мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.

14.3.Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн харьяалагддаг санхүүгийн нэгдэл, тэдгээрийн бүх салбар нэгж, охин компани нь нэгэн адил хэрэгжүүлнэ.

14.4.Дотоод хяналтын хөтөлбөрт дараах асуудлыг тусгана:

14.4.1.харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал;

14.4.2.өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам;

14.4.3.шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний зохицуулалт;

14.4.4.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны журам;

14.4.5.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд дагаж мөрдөх зохицуулалт;

14.4.6.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт;

14.4.7.тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны журам;

14.4.8.корреспондент банкны харилцаа тогтоох журам;

14.4.9.мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам;

14.4.10.сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах журам;

14.4.11.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;

14.4.12.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр;

14.4.13.хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан бусад нөхцөл, шаардлага.

14.5.Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь өөрийн харьяалагддаг хяналт тавих эрх бүхий байгууллагад хүргүүлж бүртгүүлнэ.

14.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороо, эсхүл бие даасан дотоод хяналтын нэгжээр дамжуулан дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллана.

15 дугаар зүйл. Монгол Улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах

15.1. Зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ.

15.2. Энэ хуулийн 15.1-д заасны дагуу мэдүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийг гаалийн байгууллага нэгтгэж, сар бүр холбогдох журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ.

15.3. Энэ хуулийн 15.2-т заасан мэдүүлгийн маягтын загварыг Санхүүгийн мэдээллийн албаны даргатай зөвшилцөж Гаалийн ерөнхий газрын дарга батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

16 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн алба

16.1. Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл, энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага байна.

16.2. Санхүүгийн мэдээллийн алба нь Монголбанкны дэргэд ажиллана.

16.3. Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг тус албаны дарга, үйл ажиллагааны төсвийг тус албаны даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална.

16.4. Санхүүгийн мэдээллийн албаны даргыг эрх бүхий хууль сахиулах байгууллагын даргатай зөвшилцөн Монголбанкны Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.

16.5. Санхүүгийн мэдээллийн албаны дарга дараах шаардлагыг хангасан байна:

16.5.1. банк, санхүү, эсхүл хууль зүйн салбарт таваас доошгүй жил ажилласан;

16.5.2. зээлийн болон баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй.

16.6. Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагч, шинжээч дараах шаардлагыг хангасан байна:

16.6.1. банк, санхүү, эсхүл хууль зүйн салбарт хоёроос доошгүй жил ажилласан;

16.6.2. зээлийн болон баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй.

16.7.Санхүүгийн мэдээллийн албаны дарга нь санхүүгийн мэдээллийн улсын ахлах байцаагч, хянан шалгагч, шинжээч нь санхүүгийн мэдээллийн улсын байцаагч байна.

16.8.Санхүүгийн мэдээллийн албаны улсын ахлах байцаагчийн эрхийг Монголбанкны Ерөнхийлөгч, улсын байцаагчийн эрхийг улсын ахлах байцаагч олгоно.

16.9.Санхүүгийн мэдээллийн албаны дарга болон хянан шалгагч, шинжээч шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийх, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагаас лавлагаа гаргуулж авах бүрэн эрхтэй.

16.10.Санхүүгийн мэдээллийн албаны дотоод үйл ажиллагаатай холбогдох бусад журам, зааврыг Санхүүгийн мэдээллийн албаны дарга батална.

17 дугаар зүйл. Эрх бүхий хууль сахиулах байгууллагын чиг үүрэг

17.1.Санхүүгийн мэдээллийн албанд эрх бүхий хууль сахиулах байгууллагын төлөөллийг ажиллуулна.

17.2.Эрх бүхий хууль сахиулах байгууллагын төлөөлөл нь энэ хуулийн 16.9-д заасны дагуу хяналт шалгалт хийх, санхүүгийн лавлагаа гаргуулж авах эрхтэй.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан төлөөллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагын даргын саналыг үндэслэн Санхүүгийн мэдээллийн албаны дарга томилж, чөлөөлнө.

17.4.Шаардлагатай тохиолдолд эрх бүхий хууль сахиулах байгууллага, Санхүүгийн мэдээллийн алба хамтарсан ажлын хэсэг гарган ажиллаж болно.

18 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүрэг

18.1.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 10, 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1.энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх;

18.1.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх, шилжүүлсэн сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;

18.1.3.сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар ирүүлсэн мэдээллийн дагуу авсан арга хэмжээний тухай энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон эрх бүхий хууль сахиулах байгууллагад тухай бүр мэдээлэх;

18.1.4.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;

18.1.5.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах;

18.1.6.хориг арга хэмжээний жагсаалтыг энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;

18.1.7.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх;

18.1.8.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

18.1.9.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах.

18.2.Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагч мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, илэрсэн зөрчлийг арилгахыг энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс шаардах, эсхүл эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах буюу тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгуулах талаар санал боловсруулж эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх эрхтэй.

18.3.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний албан тушаалтныг хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавина.

18.4.Санхүүгийн мэдээллийн алба өөрийн үйл ажиллагааны талаарх тайланг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд жил бүр танилцуулна.

18.5.Санхүүгийн мэдээллийн албаны дарга, ажилтан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэл, хилээр нэвтэрсэн тухай бүртгэл, хөрөнгө оруулалтын бүртгэл, татвар төлөлтийн бүртгэл, банк, санхүүгийн байгууллага хоорондын гүйлгээний бүртгэлийн лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулж авах эрхтэй.

19 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналт

19.1.Энэ хуулийн 4.1.1-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Монголбанк, энэ хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо, энэ хуулийн 4.1.8, 4.1.9-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг тухайн төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх бүхий байгууллага эрсдэлд суурилсан хэлбэрээр тус тус хэрэгжүүлнэ.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан эрх бүхий байгууллага, Санхүүгийн мэдээллийн алба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

19.2.1.энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд газар дээрх шалгалт хийх, зайнаас хяналт тавих, шалгалтын удирдамж, журам, заавар, зөвлөмж гаргах;

19.2.2.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, шалгалт хийх зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах;

19.2.3.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, гүйцэтгэх удирдлага, ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлох;

19.2.4.санхүүгийн нэгдлийн оролцогч нь өөр улсад бүртгэгдсэн, эсхүл байршдаг бол холбогдох хяналт тавих эрх бүхий байгууллага нь тухайн улсын хяналт тавих эрх бүхий байгууллагатай гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан мэдээлэл солилцох, хамтарсан шалгалт хийх хэлбэрээр хамтран ажиллах;

19.2.5.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгоор холбогдох хяналт тавих эрх бүхий байгууллага хоорондоо болон Санхүүгийн мэдээллийн албатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах;

19.2.6.энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч байгаа арга хэмжээ болон хариуцлагын талаарх статистик мэдээг нийтэд түгээх;

19.2.7.санхүүгийн нэгдлийн хэмжээнд хуулийн хэрэгжилтийг шалгах шаардлагатай гэж үзвэл Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийх.

19.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан нь хянан шалгагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангана.

19.4.Санхүүгийн мэдээллийн алба шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 4.1-д заасан этгээд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг энэ хуулийн 19.1-д заасан этгээдтэй хамтран хэрэгжүүлж болно.

20 дугаар зүйл.Мэдээллийн сан

20.1.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуульд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сантай байна.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан мэдээллийн санд мэдээлэл хадгалах, түүнийг ашиглах журмыг Санхүүгийн мэдээллийн албаны дарга батална.

21 дүгээр зүйл.Гадаад улсын ижил төстэй байгууллагатай харилцах

21.1.Санхүүгийн мэдээллийн алба ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар ижил түвшний, гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

21.2.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 21.1-д заасан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн түүнд шаардлагатай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгч болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

22 дугаар зүйл.Хамтын ажиллагааны зөвлөл

22.1.Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны зөвлөл ажиллана.

22.2.Хамтын ажиллагааны зөвлөлд гадаад харилцаа, санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл ажиллана.

22.3.Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Санхүүгийн мэдээллийн алба хэрэгжүүлнэ.

22.4.Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн, түүний удирдлагыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

22¹ дүгээр зүйл.Үндэсний зөвлөл

22¹.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллах бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд батална.

22¹.2.Үндэсний зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүнд прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөллийг оролцуулна.

22¹.3.Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Санхүүгийн мэдээллийн алба хэрэгжүүлнэ.

23 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

23.2.Энэ хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол энэ хуулийн

19.1-д заасан байгууллагын эрх бүхий албан тушаалтан үүссэн нөхцөл байдал, дутагдлыг харгалзан дараах арга хэмжээг авна:

23.2.1.дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх, хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

23.2.2.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

23.2.3.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах;

23.2.4.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох.

23.3.Эрх бүхий албан тушаалтнаас энэ хуулийн 23.2-т заасны дагуу өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, сануулга, шаардлагыг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

24.1.Энэ хуулийг 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад терроризмтой тэмцэх эрх зүй, зохион байгуулалтын үндсийг тогтоож, энэ чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдээс хүлээх үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ хуульд заасан терроризмтой тэмцэх талаарх бүхий л зохицуулалтад үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх аливаа ажиллагаа нэгэн адил хамаарна.

2 дугаар зүйл. Терроризмтой тэмцэх тухай хууль тогтоомж

2.1.Терроризмтой тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг баримтална.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааг;

3.1.2.“олон улсын терроризм” гэж олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх зорилго бүхий улс дамжсан терроризмыг;

3.1.3.“террор ажиллагаа” гэж

3.1.3.1.террорист үйлдэл хийх, түүнд оролцох зорилгоор террорист бүлэг байгуулах;

3.1.3.2.террорист үйлдлийг бэлтгэх, зохион байгуулах;

3.1.3.3.террорист үйлдэлд бүрэн буюу хэсэгчлэн ашиглуулах зорилгоор өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа эд хөрөнгө, мөнгийг террорист байгууллага болон түүнийг дэмжигч хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар, эсхүл санаатайгаар өгөх, хуримтлуулах;

3.1.3.4.терроризмын зорилгоор мэдээллийн цахим сүлжээнд халдах;

3.1.3.5.терроризмын зорилгоор иргэнийг элсүүлэх, түүнийг зэвсэглэх, сургах;

3.1.3.6.террорист үйлдэлд байгууллага, иргэнийг өдөөн хатгах, албадах, эсхүл өдөөн хатгах, албадахыг оролдох;

3.1.3.7.терроризмын үзэл санааг дэлгэрүүлэхийг;

3.1.4.“террорист үйлдэл” гэж хүн амд айдас төрүүлэх, эсхүл энэ зорилгоор иргэнийг төрийн байгууллага, олон улсын байгууллагаас аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардах, эсхүл зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй иргэний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулах санаатай үйлдлийг;

3.1.5.“террорист хүн” гэж хууль бусаар болон зориудаар, шууд болон шууд бусаар террорист үйлдлийг үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан, террорист үйлдэлд хамтрагчаар оролцсон, бусад этгээдийн террорист үйлдэл үйлдэхийг зохион байгуулсан, удирдсан, эсхүл бүлэг этгээдийн террорист үйлдэл үйлдэх санаа зорилгыг мэдэж байсан, террорист үйлдлийг үргэлжлүүлэх зорилгоор санаатайгаар дэмжсэн хүнийг;

3.1.6.“террорист бүлэг” гэж террор ажиллагаа, террорист үйлдэл явуулах зорилгоор нэгдсэн бүлэг этгээдийг;

3.1.7.“террорист байгууллага” гэж хууль бусаар болон зориудаар, шууд болон шууд бусаар террор ажиллагаа үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан, террор ажиллагаанд хамтрагчаар оролцсон, террорист ажиллагаа үйлдэх бүлгийг санаатайгаар дэмжсэн террорист бүлгийг;

3.1.8.“терроризмоос сэргийлэх” гэж улс орондоо терроризм үүсэх шалтгаан, нөхцөл бүрдэхээс болон иргэдийн аюулгүй байдлыг террор ажиллагаа, террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор төр, түүний байгууллага, иргэн, хуулийн этгээдээс авч хэрэгжүүлж буй улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг;

3.1.9.“террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа” гэж террор ажиллагаа, террорист үйлдлийг илрүүлэн таслан зогсоох, террорист этгээдийг аюулгүй болгох, баривчлах зорилгоор цагдаа, тагнуулын болон цэргийн салбар, байгууллагын хүч хэрэгслээр нэгдмэл бодлого, төлөвлөгөө, нэгэн удирдлагаар гүйцэтгэх ажиллагааг;

3.1.10.“терроризмтой тэмцэх” гэж терроризмоос сэргийлэх ажиллагаа, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгдлийг;

3.1.11.“террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүс” гэж террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулахаар энэ хуулийн дагуу тогтоосон нутаг дэвсгэр, тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, түүнтэй хиллэсэн дэвсгэр газрыг;

3.1.12.“үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах аливаа үйл ажиллагааг.

4 дүгээр зүйл. Терроризмтой тэмцэх үндсэн зарчмууд

4.1.Терроризмтой тэмцэхэд дараахь зарчмыг удирдлага болгоно:

4.1.1.хууль дээдлэх;

4.1.2.терроризмоос сэргийлэх арга хэмжээг урьтал болгох;

4.1.3.терроризмоос сэргийлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, ухуулга, сурталчилгааны арга хэмжээг цогцолбороор хэрэгжүүлэх;

4.1.4.терроризмын аюулд өртсөн иргэдийн амь нас, эрүүл мэндийг эрхэмлэн дээдлэх, аргагүй нөхцөлд учирч болох хор уршиг, хохирлыг аль болох багасгах;

4.1.5.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны удирдлага нэгдмэл байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕРРОРИЗМООС СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮНДЭС

5 дугаар зүйл. Терроризмоос сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэл

5.1.Терроризмоос сэргийлэх арга хэмжээг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

5.1.1.улс орондоо террорист байгууллага, бүлэг үүсэх шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхээс сэргийлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах;

5.1.2.иргэдэд терроризмыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх;

5.1.3.газар нутагтаа олон улсын терроризм, террорист этгээд үл нэвтрэх, үл орогнох, үл нутагших орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.4.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох цэрэг, тагнуул, цагдаагийн салбар, нэгжийг тусгайлан байгуулах, эсхүл томилох, тэдгээрийн үүрэг гүйцэтгэх бэлтгэл, чадавхи, бэлэн байдлыг хангах;

5.1.5.иргэдийн аюулгүй байдал, эд хөрөнгийг болзошгүй террорист үйлдлээс сэргийлэх, хамгаалах;

5.1.6.галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологи /бактериологи/-ийн болон хүчтэй үйлчлэх хорт бодисыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх;

5.1.7.төрийн байгууллага, эдийн засгийн дэд бүтцийн барилга, байгууламж болон соёл, олон нийтийн үйлчилгээний чухал газруудыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах;

5.1.8.террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, үүдэн гарах хор уршиг, хохирлыг багасгахад чиглэгдсэн арга хэмжээг урьдчилан авах;

5.1.9.бусад улс, тэдний хууль сахиулах байгууллага, тусгай албад, олон улсын холбогдох байгууллагатай терроризмоос сэргийлэх, террорист үйлдлээс сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах.

6 дугаар зүйл. Терроризмоос сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх үүрэг

6.1.Терроризмоос сэргийлэх талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан терроризмоос сэргийлэх үндсэн арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах;

6.1.2.терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.3.террорист үйлдлийн улмаас онц байдал тогтоох нөхцөл байдал үүссэн тохиолдолд онц байдал тогтоох асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлүүлэх;

6.1.4.энэ хуулийн 7.1.7, 8.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор террорист этгээдийн жагсаалт батлах, жагсаалтаас гаргах, түүнийг хянах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, жагсаалтад алдаатай нэрс оруулснаас үүсэх хохирлыг шийдвэрлэх, гэм буруугүй этгээдийн хөрөнгийг гэм буруутай этгээдийн хөрөнгөөс тусгаарлахтай холбоотой журмыг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн батлах.

6.2.Төрийн захиргааны байгууллага хуулиар хүлээсэн чиг үүрэг, эрх хэмжээнийхээ хүрээнд терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөний дагуу терроризмоос сэргийлэх төлөвлөгөөг баталж, мөрдөж ажиллана.

6.3.Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын терроризмоос сэргийлэх талаар мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “Зохицуулах зөвлөл” гэх/-ийг тагнуулын төв байгууллагын даргаар ахлуулан байгуулж ажиллуулна.

6.4.Зохицуулах зөвлөл нь дор дурдсан чиг үүрэг хүлээнэ:

6.4.1.терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлэх;

6.4.2.терроризмын талаарх мэдээ, мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийж, Засгийн газрыг шуурхай мэдээллээр хангах, санал оруулах;

6.4.3.терроризмоос сэргийлэх талаар төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

6.4.4.террорист үйлдлээс сэргийлэх зорилгоор төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд үүрэг өгч, түүнийхээ хэрэгжилтийг хангуулах.

6.5.Зохицуулах зөвлөлийн дүрэм, ажиллах журмыг Засгийн газар тогтоож, бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд томилно.

6.6.Терроризмоос сэргийлэх талаар төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавина.

7 дугаар зүйл. Терроризмоос сэргийлэх талаар хуулийн этгээдийн хүлээх үүрэг

7.1.Терроризмоос сэргийлэх талаар хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:

7.1.1.терроризмоос сэргийлэх арга хэмжээг үйл ажиллагааныхаа онцлогт нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэх;

7.1.2.Зохицуулах зөвлөлөөс терроризмоос сэрэмжлүүлж өгсөн үүргийг хугацаанд нь бүрэн биелүүлэх;

7.1.3.терроризмоос сэргийлэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг явуулахад төрийн байгууллагад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

7.1.4.терроризмоос сэргийлэхтэй холбогдсон аливаа мэдээ, мэдээллийг төрийн байгууллагад нэн даруй хүргэх;

7.1.5.террорист үйлдлийн эсрэг гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий төрийн байгууллагад мэдээлэл олзлох боломжийг бүрдүүлэх;

7.1.6.терроризмын сурталчилгаа явуулахгүй байх;

7.1.7.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад орсон террорист үйлдэл, террорист хүн, террорист

байгууллага, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээд болон тэдгээртэй хамаарал бүхий хувь хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогыг нэн даруй зогсоож холбогдох эрх бүхий байгууллагад 48 цагийн дотор мэдэгдэх.

8 дугаар зүйл. Терроризмоос сэргийлэх талаар иргэний хүлээх үүрэг

8.1.Терроризмоос сэргийлэх талаар иргэн дараахь үүрэг хүлээнэ:

8.1.1.терроризмоос сэргийлэхтэй холбогдсон аливаа мэдээллийг төрийн холбогдох байгууллагад нэн даруй өгөх;

8.1.2.террор ажиллагаа, үйлдэлд өдөөн хатгасан аливаа явуулгад автахгүй байх;

8.1.3.терроризмоос сэргийлэх арга хэмжээ, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

8.1.4.терроризмын сурталчилгаа явуулахгүй байх.

8.2.Энэ хуулийн 7.1.7-д заасан жагсаалтад орсон этгээд, эсхүл түүний удирдлагад хамаарах этгээд, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс зөвшөөрөгдөөгүй этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТЕРРОРИСТ ҮЙЛДЛИЙН СӨРӨГ ТУСГАЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮНДЭС

9 дүгээр зүйл. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа

9.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагын болон цэргийн хамтарсан хүч хэрэгслээр тусгайлан хэрэгжүүлэх дараахь ажиллагаа хамаарна:

9.1.1.террор ажиллагаа, террорист үйлдлийг илрүүлэх, түүнээс иргэн, байгууллагыг сэрэмжлүүлэх, хамгаалах;

9.1.2.террорист үйлдэлд өртсөн иргэн, эд хөрөнгийг аврах, хамгаалах;

9.1.3.террор ажиллагаа, террорист үйлдэлд хүргэж буй шалтгаан нөхцөлийг арилгах;

9.1.4.террорист үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

9.1.5.террорист этгээдийг баривчлах, аюулгүй болгох;

9.1.6.террор ажиллагаа, террорист үйлдэлд ашиглаж байгаа буюу ашиглахад зориулсан эд хөрөнгө, мөнгө, террорист ажиллагаа, террорист үйлдлээс олсон орлогыг илрүүлэх, хураах;

9.1.7.тухайн нөхцөл байдлаас шалтгаалан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр бэлтгэж явуулах хууль тогтоомжид заасан бусад тусгай ажиллагаа.

10 дугаар зүйл. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох байгууллагын хүч хэрэгсэл

10.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дор дурдсан байгууллагын хүч хэрэгсэл оролцоно:

10.1.1.цагдаагийн төв, орон нутгийн байгууллага;

10.1.2.тагнуулын төв, орон нутгийн байгууллага;

10.1.3.улсын хил хамгаалах байгууллагын гүйцэтгэх ажил эрхлэх салбар, нэгж;

/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

10.1.4.дотоодын цэргийн томилогдсон салбар, нэгж;

/Энэ заалтыг 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

10.1.5.дотоод цэргийн томилгоот салбар, нэгж.

10.2.Шаардлагатай тохиолдолд Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрлөөр Зэвсэгт хүчний ерөнхий зориулалтын цэргийн томилогдсон анги, салбарыг террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд татан оролцуулна.

10.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд гадаадын цэрэг, цагдаагийн тусгай хүчний салбар, нэгжийг Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуульд заасны дагуу оролцуулж болно.

11 дүгээр зүйл. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг удирдах

11.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг шуурхай штаб удирдана.

11.2.Шуурхай штабыг террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны зорилго, агуулга, далайцад нийцүүлэн Зохицуулах зөвлөл тухай бүр байгуулж ажиллуулна.

11.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцож байгаа салбар, нэгж, бие бүрэлдэхүүн тусгай ажиллагаа үргэлжлэх хугацаанд шуурхай штабын даргад шууд захирагдана.

11.4.Шуурхай штабын хүсэлт, шаардлагыг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нэн даруй биелүүлж, түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

12 дугаар зүйл. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах журам

12.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг энэ хууль болон холбогдох бусад хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн гаргасан дүрмийн дагуу явуулна.

12.2.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрмийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

12.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрмийн нууцын зэрэглэлийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд нийцүүлэн тогтооно.

12.4.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсийг шуурхай штабын дарга тогтоож, Цагдаагийн албаны тухай хуулийн 4, 5 дугаар бүлэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хойшлуулшгүй ажиллагааг явуулж болно.

13 дугаар зүйл. Террорист үйлдлийн хор уршиг, хохирлыг арилгах

13.1.Хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд террорист үйлдлээс үүсэх гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар зохион байгуулна.

13.2.Террорист үйлдлийн хохирлыг арилгах арга хэмжээг Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

14 дүгээр зүйл. Террорист ажиллагаа, террорист үйлдэлд оролцсон этгээдэд хүлээлгэх хариуцлага

14.1.Террор ажиллагаа, террорист үйлдэлд оролцсон этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

15 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

15.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА
Ж.БЯМБАДОРЖ**

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИАС

5.10 дугаар зүйл.Терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих

1.Терроризмоос сэргийлэхтэй холбогдсон аливаа мэдээллийг төрийн холбогдох байгууллагад даруй өгөх, эсхүл террор ажиллагаа, үйлдэлд өдөөн хатгасан аливаа явуулгад автахгүй байх, эсхүл терроризмоос сэргийлэх арга хэмжээ, террор үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Зохицуулах зөвлөлийн терроризмоос сэрэмжлүүлэх талаар өгсөн үүрэг, эсхүл террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг удирдах шуурхай штабын хүсэлт, шаардлагыг хуулийн этгээд даруй биелүүлэх, эсхүл түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс сэргийлэхтэй холбогдсон аливаа мэдээллийг төрийн холбогдох байгууллагад даруй өгөх, эсхүл террор ажиллагаа, үйлдэлд өдөөн хатгасан аливаа явуулгад автахгүй байх, эсхүл үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс сэргийлэх арга хэмжээ, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

/Энэ хэсгийг 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн/

4.Зохицуулах зөвлөлийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс сэрэмжлүүлэх талаар өгсөн үүрэг, эсхүл үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг удирдах шуурхай штабын хүсэлт, шаардлагыг хуулийн этгээд даруй биелүүлэх, эсхүл түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.29 дүгээр зүйл.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих

/Энэ зүйлийг 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу:

1.1.нэргүй, дугаарласан, хуурамч нэрээр данс нээх, эсхүл гүйлгээ хийх;

1.2.хаагдсан данс ашиглах;

1.3.халхавч банктай харилцсан;

1.4.халхавч банктай харилцаа тогтоосон банктай харилцсан;

1.5.халхавч банктай өмнө нь харилцаа тогтоосон байсан харилцааг үргэлжлүүлэхийг хориглосон журам зөрчсөн бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй

тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Эцсийн өмчлөгчийг тогтоох талаар хуульд заасан зохицуулалтыг зөрчсөн бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хуульд заасны дагуу харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүргээ биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хуульд заасан харилцагчийг таньж мэдэхийн тулд авах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хуульд заасны дагуу харилцагчийг таньж мэдэх хүрээнд шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзсан хүн, хуулийн этгээдэд аливаа үйлчилгээ үзүүлсэн бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хялбаршуулсан журмаар харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа явуулах тухай холбогдох зохицуулалтыг зөрчсөн бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Хуульд заасны дагуу улс төрд нөлөө бүхий этгээд, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээдийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэгэн адил авч үзээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хийх, хүлээн авах, дамжуулах шилжүүлэг нь шилжүүлэгч, хүлээн авагчийн талаархи хуульд заасан мэдээллийг бүрэн агуулаагүй байхад шилжүүлэг хийсэн, хүлээн авсан, эсхүл дамжуулсан бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс, эсхүл төрийн холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх талаар хуульд заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Мэдээллийн нууцлалыг хадгалах талаар хуульд заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах талаар хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд саад учруулсан, хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, биелүүлэхгүй байхыг уриалсан, шаардсан мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь өндөр эрсдэлтэй харилцагчийн хувьд харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх журмыг зөрчсөний улмаас уг дутагдлыг арилгах талаар хянан шалгагч, улсын байцаагчийн өгсөн үүрэг, даалгавар, шаардлагыг биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.Хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь гадаад гуйвуулга, шилжүүлэг, төлбөр тооцоо хийх зорилгоор гадаад улсын банктай корреспондент харилцаа тогтоохоос өмнө хуульд заасны дагуу мэдээллийг авах үүргээ биелүүлээгүйн улмаас уг дутагдлыг арилгах талаар хянан шалгагчийн өгсөн үүрэг, даалгавар, шаардлагыг биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь шинэ бүтээгдэхүүн, технологи нэвтрүүлэхийн өмнө түүний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдаж болох эрсдэлийн үнэлгээг хийх, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх хуульд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас уг дутагдлыг арилгах талаар хянан шалгагч, улсын байцаагчийн өгсөн үүрэг, даалгавар, шаардлагыг биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг таньж мэдэх талаар хуульд заасан мэдээлэлд байнгын хяналт тавих, өөрчлөлт орох бүрд мэдээллийг шинэчлэх үүргээ биелүүлээгүйн улмаас уг дутагдлыг арилгах талаар хянан шалгагч, улсын байцаагчийн өгсөн үүрэг, даалгавар, шаардлагыг биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16.Хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх тохиолдолд тавигдах шаардлагыг зөрчсөний улмаас уг дутагдлыг арилгах талаар хянан шалгагч, улсын байцаагчийн өгсөн үүрэг, даалгавар, шаардлагыг биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

17.Хуульд заасан тусгай хяналтын талаар тогтоосон журмыг зөрчсөний улмаас уг дутагдлыг арилгах талаар хянан шалгагчаас өгсөн үүрэг, даалгавар, шаардлагыг биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

18.Хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналтын талаар тогтоосон журмыг зөрчсөний улмаас уг дутагдлыг арилгах талаар хянан шалгагч, улсын байцаагчийн өгсөн үүрэг, даалгавар, шаардлагыг биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

19.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь:

19.1.дотоод хяналтын хөтөлбөрийг баталж бүртгүүлээгүй;

19.2.шаардлага хангаагүй албан тушаалтныг ажилд томилсон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

20.Гүйлгээний талаар мэдээлэх, сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл, хөрөнгө битүүмжлэх, түдгэлзүүлэхтэй холбоотой хуульд заасан бусад үүргээ биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

21.Хуульд заасан харилцагчийг таньж мэдэх, тусгайлан хяналт тавих, гүйлгээний талаар мэдээлэх, харилцагчийн талаархи баримт материалыг хадгалахтай холбоотой

үүргийг биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

22.Гаалийн байгууллагад:

22.1.үнэн зөв мэдүүлэг гаргахаас зайлсхийсэн;

22.2.үнэн зөв мэдүүлэг гаргахаас татгалзсан;

22.3.худал мэдүүлсэн бол зөрчилтэй төлбөрийн хэрэгслийн, эсхүл валютын үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүн, хуулийн этгээдийг зөрчилтэй төлбөрийн хэрэгслийн, эсхүл валютын үнийн дүнгийн 15 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ЭРҮҮГИЙН ХУУЛИАС

18.6 дугаар зүйл.Мөнгө угаах

1.Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;

2.2.байнга тогтвортой үйлдэж;

2.3.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

29.10 дугаар зүйл.Террор үйлдэхийг санхүүжүүлэх

1.Террорист хүн, террорист байгууллага, террор ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд, шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа

явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

29.11 дүгээр зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх

1. Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Ашигласан материал

- Комплаенсын систем, Оймандах Жамъянсүрэн, 2017 он
- Getting ahead of the watchdogs: Real-time compliance management, 2018 State of Compliance, PwC
- Handbook on Anti-money laundering and combating the financing of terrorism for non-bank financial institutions, Asian Development Bank, 2017
- Gary Gegenheimer, AML/CFT Customer Due Diligence Guideline for Non-bank financial institutions, 2018
- <https://www.int-comp.org>
- <http://www.corporatecomplianceinsights.com/>
- <https://www.corporatecompliance.org/>
- https://www.complianceweek.com/sites/default/files/bna_compliance_portfolio.pdf
- <https://na.theiaa.org/standards-guidance/Public%20Documents/PP%20The%20Three%20Lines%20of%20Defense%20in%20Effective%20Risk%20Management%20and%20Control.pdf>
- <https://www2.deloitte.com/us/en/pages/finance/articles/cfo-insights-compliance-risks.html>
- <http://static1.squarespace.com/static/559fb5d6e4b0b8eb00f70a64/t/55b231d2e4b0f48e249a5fea/1437741522647/W03.pdf>
- <https://www.occ.treas.gov/publications/publications-by-type/comptrollers-handbook/compliance-mgmt-systems/pub-ch-compliance-management-systems.pdf>
- <https://www.complianceweek.com/blogs/jose-tabuena/conducting-a-practical-compliance-risk-assessment#.W-3YJpMzZsM>
- <http://www.marketing.org.mn/news/read/“ҮНЭТ-ЗҮЙЛСЭЭ-ХУВААЛЦЬЯ”>
<https://www.fsrc.kn/compliance-documents/271-minimum-guidelines-for-the-approval-of-a-compliance-or-reporting-officer/file>
- https://www.kas.de/c/document_library/get_file?uuid=c482d4de-585c-0d09-6e4a-5650a89ee54c&groupId=252038
- <https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/global/Documents/Governance-Risk-Compliance/dttl-grc-riskassessmentinpractice.pdf>
- <https://core.ac.uk/download/pdf/82611967.pdf>
- <https://www.legalinfo.mn/>
- <https://governance.mn>